

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР
АЙМАГ, СУМЫН ТӨВҮҮДИЙН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Талууд Монгол Улсын Засгийн газар (цаашид “Монгол Улс” гэх) болон Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх) нь энэхүү Санхүүжилтийн Ерөнхий Хэлэлцээр (цаашид “СЕХ” гэх)-ийг []-ийн өдөр байгуулав.

ҮШСХ-ийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр Монгол Улс нь энэхүү хэлэлцээрийн Хуваарь 1-т тодорхойлсон Аймаг, сумын төвүүдийн бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тууштай дэмжиж, хэрэгжүүлэх юм.

2022-2032 оны хооронд хэрэгжих Аймаг, сумын төвүүдийн бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нийт санхүүжилтийн зардал нь 735,000,000 ам.доллар байхаар тооцоолж байна.

Үе шатлалт санхүүжилтийн хөтөлбөр Үе шатлалт санхүүжилтийн хөтөлбөр (ҮШСХ)-ийн зорилго нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд энэхүү СЕХ-т тусгасан ойлголцлын дагуу Хуваарь 4-т¹ заасан шалгуурыг хангасан бүрэлдэхүүн хэсгийг санхүүжүүлэхэд оршино.

Үүнд:


- (i) Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай, татах хүч сайтай аймаг болон сум (аймгийн дэд бүрэлдэхүүн)-ын төвүүдийг хөгжүүлэх;
- (ii) Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлт мөн тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх;
- (iii) Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй малын өртгийн сүлжээг бий болгох хүртээмжтэй санхүүжилт (санхүүгийн зуучлалын зээл [С33]-тэй бүрэлдэхүүн хэсэг); мөн
- (iv) Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бүсчилсэн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх.

Энэхүү СЕХ байгуулснаар АХБ аливаа санхүүжилт олгох хууль зүйн үүрэг хүлээх үндэслэл болохгүй. АХБ нь Монгол Улсын гаргасан санхүүжилтийн аливаа хүсэлтээс татгалзах, Хөтөлбөрийн авч ашиглах үүрэг хүлээгээгүй эх үүсвэрийг буцаан татах, цуцлах болон Хөтөлбөрийн эх үүсвэрээс аливаа үе шатны санхүүжилт хүсэх Монгол Улсын эрхийг цуцлах эрхтэй. Тус хөтөлбөрийн эх үүсвэрийг энэхүү СЕХ-т туссан, мөн Хөтөлбөрийн ерөнхий нөхцөл болон ойлголцлын хүрээнд ашиглаж байгаа тохиолдолд АХБ-наас үе шатлалт санхүүжилтийг олгож болно.

Энэхүү СЕХ байгуулснаар нь Монгол Улсын хувьд санхүүжилтийн хүсэлт гаргах хууль зүйн үүрэг хүлээх үндэслэл болохгүй. Монгол Улс нь Хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт хүсэхгүй байх эрхтэй. Түүнчлэн, Монгол Улс нь Хөтөлбөрийн хүрээнд нөөцлөн баталгаажуулаагүй аливаа хөрөнгийг хэдийд ч цуцлах эрхтэй.

Монгол Улс болон АХБ нь Хөтөлбөрийг мөн түүний нөөцлөн баталгаажуулаагүй аливаа хөрөнгийг цуцлах тус тусын эрхээ хэрэгжүүлж болох бөгөөд АХБ нь санхүүжилтийн хүсэлтэд татгалзах эрхээ нөгөө талд

¹ Үүнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас томъёолсон хөдөө аж ахуйн логистик, ханган нийлүүлэлтийн төвүүд, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын загвар болоод зорилтот байршлуудтай хөтөлбөрийг уялдуулах ажил багтсан болно.



бичгээр мэдэгдэл өгөх замаар хэрэгжүүлж болно. Бичгээр өгсөн мэдэгдэл нь татгалзах эсвэл цуцлах болсон шалтгааныг мөн цуцалсан бол тус өдрийг тодорхой тусгасан байна. АХБ нь АХБ-ны бодлого эсхүл СЕХ-т заасан нөхцөл журмыг зөрчсөн, санхүүжилтийн хүсэлтийг хугацаандаа гаргаагүй эсвэл хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт саатсан тохиолдолд Хөтөлбөрийг цуцлах эсхүл санхүүжилтийн хүсэлтэд татгалзаж болно.

Санхүүжилтийн төлөвлөгөө

Аймаг, сумын төвүүдийн бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн төлөвлөгөөний хураангуйг дор үзүүлэв.

Санхүүжилтийн эх үүсвэр	Нийт (сая \$)	Нийт хувь (%)
1. Азийн Хөгжлийн Банк		
(i) ЭХЭҮ (энгийн зээл)	135.0	18.4
(ii) ЭХЭҮ (хөнгөлөлттэй зээл)	135.0	18.4
(iii) Тусгай сангийн ЭҮ (АХС-гийн буцалтгүй тусламж)	3.0	0.4
2. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж) ^a	45.0	6.1
3. Уур амьсгалын ногоон сан (зээл) ^a	130.0	17.7
4. Европын хөрөнгө оруулалтын банк (буцалтгүй тусламж) ^b	30.0	4.1
5. Европын хөрөнгө оруулалтын банк (зээл) ^b	150.0	20.4
6. Монгол Улсын Засгийн газар	75.3	10.2
7. Ашиг шим хүртэгчид	6.7	0.9
8. МУХБ/Арилжааны банкнууд/Хувийн хэвшил	25.0	3.4
Нийт хөрөнгө оруулалтын хөтөлбөр	735.0	100.0

АХС = Азийн Хөгжлийн Сан, МУХБ = Монгол Улсын Хөгжлийн Банк, ЭХЭҮ = Энгийн хөрөнгийн эх үүсвэр.

^a Азийн хөгжлийн банк захиран зарцуулна.

^b Зэрэгцээ хамтарсан санхүүжилт, Азийн хөгжлийн банкнаас удирдан хэрэгжүүлэхгүй
Эх сурвалж: Азийн хөгжлийн банкны тооцоолол.

Санхүүжилтийн нөхцөл

Монгол Улс доор дурдсан ойлголцлуудтай нийцсэн болон бүрэлдэхүүн хэсгүүд нь тус ойлголцлуудтай нийцсэн тохиолдолд АХБ нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг санхүүжүүлэх зээл, буцалтгүй тусламжийн эх үүсвэрийг олгох, эсхүл хамтын санхүүжилтийг зохицуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Зээл, буцалтгүй тусламж болон хамтын санхүүжилт нэг үе шатлалт санхүүжилтийг бүрдүүлнэ.

Үе шатлалт санхүүжилт бүр өмнөх болон дараагийн үе шатлалт санхүүжилтийн нөхцөлөөс өөр нөхцөлөөр санхүүжих боломжтой. Тухайн Санхүүжилтийн нөхцөл нь тухайн төслөөс, капитал зах зээлийн нөхцөл, АХБ-ны санхүүжилтийн бодлого хамаарна

Үе шатлалт санхүүжилтийг дараалан эсхүл нэгэн зэрэг олгож болох бөгөөд зарим үед давхцуулж болно.

Үе шатлалт санхүүжилтийн санд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл оногдуулахгүй. Хураамжийг зөвхөн АХБ-наас зээлийн хэлбэрээр олгосон бодит санхүүжилтэд оногдуулна. Санхүүжилт олгох тухайн үе шатны хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж буй АХБ-ны хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэлийн журам үйлчилнэ.

年月日 /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Санхүүжилтийн хэмжээ

Хөтөлбөрөөс олгох санхүүжилтийн дээд хэмжээ нь 448 сая ам.доллар байна. АХБ-ны энгийн хөрөнгийн эх үүсвэр, АХБ-ны Тусгай Сангийн эх үүсвэр (Азийн хөгжлийн сан), болон АХБ-ны удирдан зарцуулах УАНС-гийн эх үүсвэр бүхий зээл, буцалтгүй тусламж зэргийг дараах байдлаар зохицуулна. Үүнд:

АХБ-ны энгийн хөрөнгийн эх үүсвэр: 135 сая ам.доллар (энгийн зээл)

АХБ-ны энгийн хөрөнгийн эх үүсвэр: 135 сая ам.доллар (хөнгөлөлттэй зээл)

АХБ-ны Тусгай Сангийн эх үүсвэр (Азийн хөгжлийн сан): 3 сая ам.доллар (буцалтгүй тусламж)

УАНС-гийн зээл: 130 сая ам.доллар

УАНС-гийн буцалтгүй тусламж: 45 сая ам.доллар тус тус хамаарна.

Европын Хөрөнгө Оруулалтын Банк (ЕХОБ)-ны хамтарсан санхүүжилт (АХБ-наас захиран зарцуулахгүй) 150 сая ам.доллартой тэнцэх зээл, 30 сая ам.доллартой тэнцэх буцалтгүй тусламж байна.²

Хүчинтэй хугацаа

Хөтөлбөрийн ашиглалтын сүүлийн хугацаа 2032 оны 12-р сарын 31-ний өдөр байна. Санхүүжилтийн сүүлчийн үе шатлалт санхүүжилтийн хэлэлцээг 2027 оны 12-р сараас хэтрэхгүйгээр байгуулагдсан байна.

Нөхцөл

Энэхүү санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт туссан нөхцөл болон үе шатлалт санхүүжилтийн хууль зүйн гэрээ, хэлэлцээрт туссан Хөрөнгө оруулалтын Хөтөлбөрийн зардлын санхүүжилтийн дагуу Монгол Улс үе шатлалт санхүүжилтийг зарцуулна.


Гүйцэтгэл

Гүйцэтгэгч байгууллага нь Эдийн засаг, хөгжлийн яам байна. Гүйцэтгэгч байгууллага нь энэхүү СЕХ-ийн Хуваарь 1-т заасан нөхцөлүүд болон үе шатлалт санхүүжилт бүрийн хууль зүйн гэрээ, хэлэлцээрт туссаны дагуу Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Монгол Улсын Хөгжлийн Банк (МУХБ) байна.

Үе шатлалт санхүүжилтийн хүсэлт

Монгол Улс Үе шатлалт санхүүжилтийн хүсэлт (ҮШСХ)-ээр Хөтөлбөрийн хүрээнд Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг болон бүрэлдэхүүн хэсгүүдийг санхүүжүүлэх зорилгоор зээл, буцалтгүй тусламж, хамтын санхүүжилтийг хүсж болох ба үүнийг АХБ зөвшөөрөх боломжтой. ҮШСХ бүрийг Монгол Улс хүргүүлнэ. Монгол Улс ЭЗХЯ-анд, ЭЗХЯ цааш МУХБ-нд ҮШСХ-ийн дагуу болон үе шатлалт санхүүжилтийн хууль зүйн гэрээ, хэлэлцээрийн дагуу санхүүжилтийг олгоно.

² Европын холбооны Азийн хөрөнгө оруулалтын сангийн буцалтгүй тусламжийг Европын хөрөнгө оруулалтын банк хариуцдаг.



ҮШСХ-ийн хэмжээ 100 сая ам.доллар ба түүнээс багагүй байна. АХБ нь ҮШСХ-ийг хянаж, шаардлага хангасан гэж үзвэл холбогдох хуулийн хэлэлцээрийг бэлтгэнэ.

ҮШСХ-ийн хүрээнд санхүүжилт авах бүрэлдэхүүн нь Хуваарь 4-т заасан сонгон шалгаруулалтын шалгуур хангасан, зохих магадлал судалгаа хийгдсэн, холбогдох хамгааллын болон итгэлцлийн ерөнхий хүрээ, бусад баримт бичигтэй нийцсэн байх шаардлагатай. Хөтөлбөр нь энэхүү СЕХ-ийн Хуваарь 3-т заасан ерөнхий хүрээ, ЭЗХЯ, БХБЯ, ХХААХҮЯ, МУХБ болон АХБ харилцан тохиролцсон Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлагын дагуу хэрэгжүүлнэ.

Монгол Улсаас өөрөөр мэдэгдээгүй бол Сангийн сайдыг ҮШСХ-т гарын үсэг зурах эрхтэй Монгол Улсын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэж үзнэ.

**Хэрэгжилтийн
ерөнхий
хүрээний
журам**

Хөтөлбөрт энэхүү хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан ерөнхий хүрээний дагуу хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн нөөцөөс санхүүжилт хийгдэх үе шатууд нь дараах журам, нөхцөлийг хангана. Үүнд:

- (i) Монгол Улс нь ҮШСХ-ийг хүргүүлэхээс өмнө АХБ-нд урьдчилан мэдэгдэнэ.
- (ii) Монгол Улс нь АХБ-тай харилцан тохиролцсон загварын ҮШСХ-ийг хүргүүлнэ.
- (iii) АХБ нь санхүүжилтийн аливаа үе шатлалт санхүүжилтийн хууль зүйн гэрээ, хэлэлцээр дээр хэлэлцээ хийх болон хэрэгжүүлэхээс өөрийн хүсэлтээр татгалзаж болно.
- (iv) Хэрэв АХБ нь ҮШСХ-ийг зөвшөөрч буйгаа баталгаажуулбал талууд хэлэлцээ хийж, хэлэлцээр байгуулна.

**ҮШСХ-ийн
мэдээлэл**

ҮШСХ нь тохиролцсон загварын дагуу бэлтгэгдэж дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- (i) Зээл, буцалтгүй тусламж эсхүл хамтын санхүүжилтийн хэмжээ;
- (ii) Санхүүжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүдийн танилцуулга;
- (iii) Зардлын тооцоо ба санхүүжүүлэх төлөвлөгөө;
- (iv) Тухайн бүрэлдэхүүн хэсгийн тусгайлсан зохицуулалтууд;
- (v) Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр бөгөөд түүнийг үргэлжлүүлэн мөрдөж буй талаарх баталгаа;
- (vi) Өмнөх Зээлийн хэлэлцээр болон Хөтөлбөрийн хэлэлцээрийн (хэрэв хамааралтай бол) заалтуудыг мөрдөж буй талаарх баталгаа; болон
- (vii) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлагын дагуу шаардагдах эсхүл АХБ-ны үндэслэлтэйгээр хүсэж болох бусад мэдээлэл.

Хамгаалал

Хөтөлбөрийн хөрөнгийг захиран хэрэгжүүлэх явцад дагаж мөрдөх Хамгааллын хүрээг Хуваарь 5-д тусгасан болно.

Тухайн үе шатлалт санхүүжилтэд гарын үсэг зурсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж буй АХБ-ны Хамгааллын бодлогыг мөрдөх ба тухайн үе шатлалт санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн хэсэгт хамаарна.

Гарын үсэг /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улсанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Худалдан авах ажиллагаа	Хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх бүх ажил, бараа, үйлчилгээг АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого (2017 онд батлагдсан бөгөөд түүнд орох нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын дагуу худалдаж авна.
Зөвлөх үйлчилгээ	Хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх аливаа зөвлөх үйлчилгээг АХБ-ны зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам (2017 онд батлагдсан бөгөөд түүнд орох нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын дагуу худалдаж авна.
Урьдчилан гэрээ байгуулах, нөхөн санхүүжилт	АХБ нь зохих хүсэлтийг үндэслэн бодлого, журмын дагуу үе шат бүрийн зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнөх 12 сарын хугацаанд зээлийн дүнгийн 20 хүртэлх хувьтай тэнцэх төслийн хүрээнд гарсан зөвшөөрөгдөх бараа, ажил болон үйлчилгээтэй холбоотой зардлыг (i) урьдчилан гэрээлэх; мөн (ii) зээлийн данснаас зарлагдан нөхөн санхүүжүүлэхийг тус тус зөвшөөрч болно. Урьдчилан гэрээ байгуулах болон/эсвэл нөхөн санхүүжилтийг батлах нь АХБ-наас холбогдох төслийг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй болохыг Монгол Улс хүлээн зөвшөөрч байна.
Зарцуулалт	Хөтөлбөрийн нөөцөөс санхүүжих аливаа үе шатны ашиглалтын сүүлийн өдөр нь 2032 оны 11 дүгээр сарын 25 эсхүл түүнээс өмнө байна. Үе шат бүрийн санхүүжилтийг АХБ-ны <i>Зээлийн зарцуулалтын гарын авлага</i> (2017 онд батлагдсан бөгөөд түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын нөхцөлийн дагуу зарцуулна.
Хяналт шинжилгээ, үнэлгээ тайлагнах тогтолцоо	Хөтөлбөрийн гүйцэтгэлийн менежментийн систем (ХГМС)-ийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн хамаарал, хяналт-шинжилгээний байдлын талаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллагууд, хөтөлбөрийн ашиг шим хүртэгчидтэй ярилцаж, зөвлөлдөнө. Хөтөлбөр боловсруулах явцад бүтээгдэхүүн ба үр дүнгийн үзүүлэлтүүдийн түвшинд задалсан цуглуулсан суурь дата, мэдээллийг ТХН бэлтгэх улирал, жилийн ажлын явцын тайлан, АХБ-ны томилгоот ажил бүрийн дараа шинэчилж, мэдээлнэ. Жилийн тайлан нь АХБ-ны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлангийн системийг шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг өгөх болно. Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед ТХН нь төсөл 1-ийн зөвлөх үйлчилгээний дэмжлэгтэйгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн орц, гарцын талаар системтэйгээр мэдээлэл бий болгож, нэгдсэн ХГМС-ийн журмыг боловсруулж, хөтөлбөрийн нөлөө ба үр дүнг хэмжихэд ашиглах шалгуур үзүүлэлтийг боловсруулна. Хөтөлбөрийн гүйцэтгэлийг хянах, тайлагнах ажлыг ТХН хариуцах болно. Гүйцэтгэлийн хяналт тавих үндэс нь хөтөлбөрийн нөлөөлөл, үр дүн, үр дүнгийн гүйцэтгэлийн зорилтыг тодорхойлсон хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ (ХШХ) ба УАНС-гийн санхүүжилтийн саналын логик хүрээ байх болно. ХШХ болон УАНС-гийн санхүүжилтийн саналын логик хүрээнд тодорхойлогдсон эх сурвалжаас мэдээлэл цуглуулснаар ТХН нь хөтөлбөрийн гүйцэтгэлийн талаар жил бүр тайлагнах болно. Тайлангийн тодорхой шаардлагыг АХБ ба Засгийн газар хоорондын төсөл тус бүрийн гэрээнд тусгана. ЭЗХЯ нь мэдээлэл цуглуулах, шалгуур үзүүлэлтийг тооцоолох, үр дүнд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн төлөвлөсөн бүтээгдэхүүн, үр дүнд хэр хүрч байгаа талаар мөн хөтөлбөрийн ерөнхий үр нөлөөг тодорхойлсон товч тайлан гаргах болно. Үүний зэрэгцээ хөтөлбөрийн нөлөөллийг хэмжихэд ашиглах нийгэм, эдийн засаг, байгаль орчны харилцан тохиролцсон үзүүлэлтүүдийг улам сайжруулах болно. ТХН нь (i) хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед ХГМС-ийн хүрээг сайжруулж

нэгтгэх; (ii) зорилтот түвшинд хүрэх боломжтой эсэхийг баталгаажуулах; (iii) баримтжуулах, хянах, тайлагнах зохицуулалтыг боловсруулах; мөн (iv) хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 6 сараас доошгүй хугацаанд систем, журам нэвтрүүлнэ. Хуваарь 2-т хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг харьцуулан үнэлэхээр тогтоосон сангийн ХШХ-г харуулав.


Үүрэг амлалт Монгол Улсын хүлээх үүрэг, амлалтыг Хуваарь 6-д тусгасан болно.

Монгол Улс

Азийн Хөгжлийн Банк

Эрх бүхий төлөөлөгчийн нэр

Эрх бүхий төлөөлөгчийн нэр



ХУВААРЬ 1

ҮЕ ШАТЛАЛТ САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР БҮРДЭЛ ХЭСГҮҮД

А. Ерөнхий зураглал

1. Монгол Улс 1990 онд Зөвлөлт Холбоот Улсаас тусгаарласны дараагаас шилжилтийн үед орсон. *Аймаг болон сумын төвүүд* нь эдийн засгийн үйл ажиллагааны татах төвийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон³. Малын гаралтай бүтээгдэхүүнүүд болон мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ бага үнийн зөрүүтэй их хэмжээний бүтээгдэхүүнүүд давамгайлж чанарыг эрэлхийлэх хөшүүргийн дутагдалтай болсноор муудсан. (i) малын үнэ цэнэ бага, (ii) мал үржил, тэжээл хангамж болон мал эмнэлгийн үйлчилгээ муугаас үүдэлтэй мал илүүтэй өвчлөх болсон, (iii) мөн 2000-2001 он, 2010 онд тохиосон зуд (ган гачигтай зуны дараах өвлийн хүндрэл)-наас үүдэлтэй их хэмжээний малын хорогдол зэргээс шалтгаалан малчид олноороо хот суурин газар бараадах болсон.⁴ Хот, суурин газрын шингээх чадвараас давсан тооны айл өрх Улаанбаатар хот, *аймгийн төвүүдийн* захад шинээр суурьшиж, улмаар төлөвлөлт зохион байгуулалтгүйгээр гэр хорооллыг бий болгосон нь Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь, *аймгийн төвүүдийн* хүн ам 70 гаруй хувийг эзэлж байна.⁵ 2020 онд хот-хөдөөгийн суурьшлын харьцаа тус улсын 3.3 сая хүн амд 70:30-тай болсон байна. Үүнээс үүдэн ашиглалтын нас нь аль хэдийн хэтэрсэн байсан хотын систем муудаж, Монголын өсөн нэмэгдэж буй хотын хүн амын өнөөгийн болон ирээдүйд бий болох хэрэгцээг хангахад хүчин чадал дутах хэмжээнд очсон.⁶ Нийт 1.6 сая хүн амтай Улаанбаатар хот нь хотын хүн амын 69 орчим хувийг, дотоодын нийт бүтээгдэхүүний 63 хувийг эзэлж байна. Нийслэл хотын хүн ам зүй, эдийн засагт үзүүлэх жин нь тус улсад газар нутгийн эрс тэнцвэргүй байдал үүссэн болохыг харуулж байна.

2. Малчид (ялангуяа зудаас үүдэлтэй) малын хорогдох эрсдэлээ тооцоолж, мал сүргийн тоо толгойг нэмэгдүүлэхээс гадна бэлчээрийн зохицуулалт байхгүй, ямааны эзлэх хувь нэмэгдэж сүргийн бүтцэд тэнцвэргүй байдал үүссэн, мөн бэлчээрийн менежментийн зохисгүй дадал бий болсон нь Монгол орны бэлчээрт ноцтой аюул учруулж байна.⁷ Бэлчээрийн даац дунджаар 22.6%-иар давсан бөгөөд үүнээс болж бэлчээрийн талбайн 70

³ *Аймгийн төв* нь *аймгийн* нийслэл. Дархан, Эрдэнэтээс бусад (тус бүрдээ 80,000 орчим хүн амтай) *аймгийн төвүүдийн* хүн ам нь 15,000-40,000 хооронд хэлбэлзэж байна. *Сумын төв* гэж тухайн *сумын* дахь гол тосгоны хэлнэ. Сум дундын төв гэж тухайн аймаг дахь стратеги, эдийн засгийн ач холбогдол бүхий 2000-10000 хүн амтай сумын төвүүдийг хэлнэ.

⁴ Өмнөх *зуднаар* ихээхэн хэмжээний малын хорогдол амсаж ирсэн нь малчдын эмзэг байдал, улсын хэмжээнд малын тоо толгойд томоохон нөлөөл үзүүлж буйг харуулж байна. 2000-2001 оны *зуднаар* улсын хэмжээнд нийт малын 25% хорогдсон. 1999-2003 оны хооронд өвөлжилт хүндэрснээс амьжиргаагаар алдсан 180,000 малчид Улаанбаатар хот руу шилжин суурьшсан гэсэн тооцоо гарчээ.

⁵ Гэр хороолол гэж гол төлөв зохион байгуулалтгүй хашаа, тэдгээр хоорондын шороон замаас бүрдэх бага, дунд орлоготой өрхүүдийн сууриныг хэлнэ. Эдгээр иргэд хашаандаа байшин болон гэрт амьдрах бөгөөд тэдгээр нь дулаалга муутай, ялангуяа өвлийн улиралд нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт, агаарын бохирдлын эх үүсвэр болсон үр ашиггүй нүүрсний зуухаар галладаг.

⁶ *Аймаг болон сумын төвүүдэд* хот суурин газрын үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг ихэвчлэн (i) нүүрсэнд суурилсан төвлөрсөн халаалт, бохир ус цэвэрлэх систем, усан хангамжийн үйлчилгээний хүчин чадал дутагдалтай; (ii) ус зайлуулах хоолой, үерээс хамгаалах дэд бүтцийн дутагдалтай; (iii) ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ)-нд хангалттай хөрөнгө хуваарилдаггүй; (iv) дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж буй эдийн засгийн зогсонги байдал; (v) орон нутгийн бизнес эрхлэгчдийн өсөлтийг дэмжих зорилгоор эдийн засаг, хот суурин газрын зохих үйлчилгээ бүхий эдийн засгийн бүс, хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн парк байхгүй; (vi) хатуу хог хаягдлын менежментийн дутагдалтай; (vii) ахуйн болон үйлдвэрийн зохих бохир ус цэвэрлэх байгууламж байхгүй; (viii) ялангуяа *сумын төвүүдэд* олон нийтийн барилга байгууламж (боловсрол, төрийн болон эрүүл мэндийн үйлчилгээний) хүчин чадлаа дийлэхгүй, муудсан; (ix) орлогод нийцсэн орон сууцаар хангах боломж хомс зэргээс харж болно.

⁷ Ямаа нь бэлчээрт нэн хөнөөлтэй боловч ноолуураас олох орлогоос үүдэн тоогоороо тэргүүлж байна. Бэлчээрийн талбай нь нийт газар нутгийн 82 хувийг эзэлдэг Монголын хамгийн түгээмэл ангиллын газар нутаг юм.

орчим хувь нь доройтжээ.⁸ Үүнээс үүдэн малын шим буурч, малчид уур амьсгалын өөрчлөлт, малын өвчинд улам өртөмтгий болж, улмаар мах, ноос, мал аж ахуйн бусад бүтээгдэхүүний чанар улам бүр доройтохын хэрээр малчид багассан орлогоо малын тоо толгойгоо нэмэгдүүлэх замаар нөхөж байна.⁹ Энэхүү сөрөг эргэх тойрог нь малын тоо толгойг хяналтгүй, хэт ихээр нэмэгдэхэд хүргэсэн. 1970-1990 онд малын тоо толгой 20-25 сая байсан бол 2017 онд 60 сая, 2018 онд 66 сая толгойд хүрсэн.¹⁰ Зогсолтгүй явагдаж буй бэлчээрийн доройтол нь газрын гадарга ба газар доорх биомассын хэмжээг эрс багасгасан, хөрсний нүүрстөрөгч байх хэмжээгээсээ хамаагүй буурахад хүргэж байна. Бэлчээрийн менежментийг сайжруулснаар уур амьсгалын нөлөөллийг ихээхэн бууруулах боломжтой юм. Хөрсний нүүрстөрөгч шингээлтийн арга хэмжээ авснаар ирэх 20 жилийн хугацаанд Монгол Улсад 440 гаруй сая тонн нүүрстөрөгчийн давхар исэлтэй тэнцэх (tCO₂ e) нөлөөг бууруулах юм.¹¹

3. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар бэлчээрийн талхагдлын өнөөгийн чиг хандлагыг өөрчлөх, малын тоог цөөрүүлэн тогтвортой түвшинд байлгах бодлого, зорилт дэвшүүлсэн. Гэсэн хэдий ч тус хүчин чармайлтаар малын хэд нугарсан өсөлтийг зогсоож, мал аж ахуйн салбарт тулгарсан хоршмол саад бэрхшээлийг даван туулж чадсангүй.¹² Швейцарын хөгжлийн агентлаг Ногоон алт төслөөр дамжуулан бэлчээр ашиглагчдын бүлэг ба бэлчээр ашиглах гэрээг нэвтрүүлсэн.¹³ Ногоон алт төслийн үйл ажиллагааг аажмаар Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо болон *Аймгийн бэлчээр ашиглагчдын бүлгүүдийн холбоодод* хүлээлгэн өгсөн. Гэсэн хэдий ч цөөн хэдэн БАГ албан ёсоор бүртгэгдсэн, мөн үүнээс ч цөөн тооны бэлчээрийн тохируулгын хувь хэмжээг нэвтрүүлсэн болно. БАХ-дэд малаа эдийн засгийн эргэлтэд оруулж, сүргийнхээ тоог бууруулах урамшуулал, зах зээлийн боломж хомс байна¹⁴. Сайн ажиллаж буй хоршоо цөөн, гэрчилгээжүүлэлтийн систем сул, мөн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээтэй холбоос муу байгаа нь малын гаралтай чанартай түүхий эдээр хангах, сүргийн тоо толгойг цөөрүүлэх тогтвортой механизмыг бий болгох, бэлчээрийн менежментийг тогтвортой байлгахад саад болж байна.

4. **Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил сул болох нь.** Зээлийн хүү өндөр, хугацаа богино, барьцааны хөрөнгийн шаардлага өндөр, ялангуяа үл хөдлөх хөрөнгө хатуу шаарддаг, захиргааны журам хэт төвөгтэй, мөн зээлдэгч ЖДҮ-ийн санхүүгийн мэдлэг бага

⁸ Монгол мал үндэсний хөтөлбөр (ММУХ)-ийн талаарх Үндэсний статистикийн хороо (ҮШСХ)-ны мэдээлэлд суурилсан. Баруун бүсийн мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны боловсруулсан *сумын түвшний дата сэтэд* үндэслэсэн.

⁹ ҮШСХ-ны мэдээллээс харахад таван малчин өрх тутмын хоёр нь ядууралд автсан байна. Хэрэв энэ янзаар үргэлжилбэл илүү олон малчин өрх ядууралд орж, үндэсний хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг сулруулж, бэлчээр цөлжихөд хүргэх болно.

¹⁰ Үүнтэй харьцуулахад 1970-1990 оны хооронд малын тоо толгой 20 саяас 25 сая хэлбэлзэж байсан. Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооны мал тооллогын мэдээлэл. Монгол Улсын Үндэсний статистикийн мэдээлэл (2021 оны 9-р сарын 3-ны байдлаар).

¹¹ Нүүрстөрөгч шингээлтийн арга хэмжээ гэж нүүрстөрөгчийн давхар ислийг шингээж, хадгалах үйл явцыг хэлнэ. Үүнийг ашиглан агаар мандал дахь нүүрстөрөгчийн ислийн хэмжээг бууруулж, даян дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулах юм.

¹² 2010 оноос хойш мал аж ахуй эрчимтэй өссөнөөр өнөөгийн малын тоо толгой нь ХХААХҮЯ-ны зорилтоос давсан байна. ММУХ-т 2021 онд хонин толгойд шилжүүлсэн малын тоог 79.7 сая байлгахад заасан бол 2019 оны 119.0 сая болж, төлөвлөсөн хэмжээнээс 49 хувиар давсан байна. Өнөөгийн хурдаар малын тоо толгой 2021 онд 140 сая болж, төлөвлөсөн хэмжээнээс 75 хувиар давахад байна.

¹³ Швейцарын хөгжлийн агентлаг. 2021 *Тогтвортой менежменттэй бэлчээр ба эрүүл мал: Монголын "Ногоон алт" төсөл*. БАГ нь малчид болон *сумын захиргаа* сайн дураар хамтдаа байгуулж, (i) Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль ёсоор хүлээн зөвшөөрч, бүртгүүлсэн; (ii) нийгэм, улс төрийн хувьд бүх талууд хүлээн зөвшөөрсөн гэрээ юм. Хуулийн дагуу бүртгүүлж мөрдүүлэхийн тулд сүргийн тоо толгой, бүтэц, бэлчээр ашиглалт, бэлчээрийн төлөв байдал, даац зэрэг таван хавсралт оруулах шаардлагатай.

¹⁴ Бэлчээрийн тохируулгын хувь хэмжээ гэж тухайн газрын бэлчээрийн даацаас доогуур эсхүл түүнээс хэтрэхгүй хэмжээнд байх малын тоо толгойг хэлнэ.

байгаа нь жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийн хөгжих боломжийг хязгаарлаж байна.¹⁵ Алслагдсан аймгийн ЖДҮ-т хотын болон эдийн засгийн зохих үйлчилгээ хангалтгүй байна. Орон нутгийн бизнес болон нийлүүлэлтийн сүлжээ нь санхүүгийн экосистем сул хөгжсөн, Улаанбаатар хотын агро-бизнесийн компаниудын давамгайл байдал, бизнес эрхлэх ур чадвар дутагдалтай, болон санхүүжилт, хөнгөлөлттэй санхүүгийн бүтээгдэхүүний хүрэлцээ бага, дэмжлэг үзүүлэх үндэсний бодлого, хөтөлбөр дутагдалтай зэргээс үүдэн хөгжиж чадахгүй байна. Эдгээр бэрхшээл нь хэрэгцээ үүссэн цэгт агро-бизнесийн хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлаж, улмаар эдийн засгийг төрөлжүүлж, уул уурхайн салбарын хамаарлыг багасгаж, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг эргүүлэхэд шаардлагатай ажлын байр, орон нутгийг хөгжлийг бий болгоход саад тотгор болж байна.

5. **Баруун аймгууд.** Уулархаг бэлчээр, өндөр уулсаас эх авсан усны урсгал, баян бүрдээс хараат баруун гурван аймаг болох Баян-Өлгий, Ховд болон Увсын экосистемийн эмзэг байдал нь хүн ам, байгаль орчныг уур амьсгалын өөрчлөлтөд илүү өртөмтгий болгодог. Эдгээр гурван аймгийн хүн ам, хүрээлэн буй орчин нь уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий юм. Мөнх цэвдэг, мөстлөгүүд хайлж, агаарын хэм нэмэгдэж, хур тунадасны төлөв өөрчлөгдөж байгаа нь усны нөөцийн тогтоц, тархцад сөргөөр нөлөөлж байна. Бэлчээрийн даац байх хэмжээнээс 27.4%-иар хэтэрсэн байгаа нь улсын дунджаас таван нэгж хувиар өндөр байна. Хэдий (i) нутаг дэвсгэрийн хөгжлийг тэнцвэржүүлэх болон бүс нутгийн худалдааг нэмэгдүүлэхэд Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (КАРЕК)-ны коридор 4а дагуух баруун бүсийн хөгжлийн холбоос болох стратегийн ач холбогдолтой; (ii) Монгол улсын нутаг дэвсгэрийн тэнцвэржүүлж, бүс нутгийн худалдааг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой; мөн (iii) хөдөлмөр эрхлэлтийн бүтцэд мал аж ахуй эзлэх хувь өндөр (нийт хөдөлмөр эрхлэлтэд 38%-51% орчмыг эзэлдэг) хэдий ч эдгээр баруун гурван аймагт хөрөнгө оруулалт хангалттай хийж ирээгүйгээс болж тусгаарлагдаж, нөөц боломж нь багассан байна.

6. **Засгийн газрын ерөнхий зураглал.** Монгол Улсын Засгийн газар уг хүндрэлтэй нөхцөл байдлыг бүрэн ухамсарлаж, урт хугацааны хөгжлийг чиглүүлж, хүний хөгжил, амьдралын чанар, ногоон хөгжил, бүс нутгийн хөгжлийн тогтвортой байдлыг дэмжих хоёр үе шаттай Монгол Улсын Алсын хараа-2050 баримт бичгийг боловсруулсан болно.¹⁶ Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого (ШСБ)¹⁷ нь Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн эхний үе шат (2021-2030 он)-ын хэрэгжилтийн зорилтуудыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн юм. ШСБ нь боомтын сэргэлт, эрчим хүчний сэргэлт, аж үйлдвэржилтийн сэргэлт (ялангуяа агро-бизнесийн салбарыг хөгжүүлж, дотоодын хүнсний боловсруулалтын нэмүү өртөг шингэсэн үйлдвэржилтийг нэмэгдүүлж, дотоодын зах зээлийг хангаж, экспортыг нэмэгдүүлэхийг дэмжих), хот, хөдөөгийн сэргэлт (бүсчилсэн кластерийг хөгжүүлж, Улаанбаатар хор руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг эргүүлж, нийслэл хотын төвлөрлийг бууруулахыг дэмжих), ногоон хөгжлийн сэргэлт (бэлчээрийн тогтвортой менежмент болон хотын ногоон хөгжлийг дэмжих), мөн төрийн бүтээмжийн сэргэлтийг тус тус бий болгох зорилготой юм. Эцэст нь, Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний талаарх тогтоолыг¹⁸

¹⁵ 2019 оны 3-р сарын байдлаар ЖДҮ-ийн бизнесийн зээлийн дундаж хүү 17.7%, хувиараа бизнес эрхлэгчийн зээлийн дундаж хүү 19.7% байгаа нь Монголбанкны бодлогын 11.0%-ийн хүү, томоохон аж ахуй нэгжийн 13.0% -14.0%-ийн хүүтэй харьцуулахад хамаагүй өндөр байна. Банкнууд нийт тохиолдлын 99.7% хувьд зээлийн баталгаа болгож барьцаа хөрөнгө шаарддаг бөгөөд зээлийн үнийн дүнгийн 200%-тай тэнцэх барьцаа шаардаж буй нь хэт өндөр байна.

¹⁶ Улсын Их Хурал. 2020 он. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Улаанбаатар хот.

¹⁷ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор хүчин төгөлдөр болсон

¹⁸ 2022 оны 6-р сарын 17-нд УИХ-аас "Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг баталсан бөгөөд үүнд дараахь үндсэн арга хэмжээ багтсан болно: (i) хүнсний хангамжийг хангахад засгийн газрын бонд, баталгаа, олон улсын хөгжлийн түншүүдийн болон хөрөнгө оруулагчдын зээл, ТХХТ-аар дамжуулан 540 сая ам.долларын эх үүсвэрийг босгохос 2022 онд хүнсний хангамжийг дэмжихэд зориулж 160 сая ам.доллар зарцуулах; (ii) экспортод чиглэсэн хүнсний үйлдвэрлэлийг

УИХ-аас батлагдсаны дараа Засгийн газар ЭЗХЯ-аар дамжуулан Монголын цаг уур, газарзүйн онцлог, нөөцийн боломжид тулгуурлан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт, логистикийн кластеруудыг тодорхой сумдад сайжруулахад чиглэсэн нэгдсэн төлөвлөлтийн аргыг ашиглан дотоодын хүнсний аюулгүй байдал, тогтвортой хүнсний хангамжийн стратегийг боловсруулсан.¹⁹ Түүнчлэн зарим яамд энэхүү ерөнхий зураглалын хэрэгжилтэд удирдамж, дэмжлэгээр хангах салбарын бодлого, төлөвлөгөөг гаргасан байна.²⁰ БХБЯ болон ЭЗХЯ нь аймгуудын хөгжил, төрийн болон хувийн хэвшлийн тэргүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалтын стратегийн гол чиглэлийг томьёолсон нутаг дэвсгэр, бүсчилсэн хөгжлийн судалгааг хэрэгжүүлж байна. ХХААХҮЯ нь 2015 онд Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2016–2025), 2020 онд Монгол мал үндэсний хөтөлбөр болон 2018 онд Монгол Улсын тогтвортой мал аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Эцэст нь, Монгол Улсын Үндэсний гуравдагч тайланг нь уур амьсгалын үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд удирдлага болгосон байна.²¹

7. **Хөтөлбөрийн зорилт ба аргачлал.** Аймаг сумдад Засгийн газраас иж бүрэн бодлого хэрэгжүүлснээр КОВИД-19-ын нөлөөллөөр улам хүндэрсэн дээр дурдсан хоорондоо харилцан хамааралтай, бие биеэ харилцан бататгаж буй саад тотгоруудыг зогсоох боломжтой. Үүнийг хэсэгчилсэн, богино хугацаанд эсвэл нэг салбарт чиглэсэн байдлаар хэрэгжүүлэх нь тогтворгүй байх болно. Тухайлбал, эдийн засгийн зогсонги байдалтай байгаа үед зөвхөн дэд бүтцэд хөрөнгө оруулах нь үр дүнгүй байх бөгөөд динамик хот байгуулалтын үйл явцыг эрчимжүүлэхгүй. Хоцрогдсон дэд бүтэц, ЖДҮ-ийн нарийн төвөгтэй захиргааны үйлчилгээ, малын үнэ цэнэ муутай асуудалд анхаарал хандуулахгүйгээр мал аж ахуйд санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь эдийн засгийн хувьд ашиггүй. Хүртээмжтэй, ногоон нийлүүлэлтийн сүлжээг дэмжих зах зээлийн холбоосыг бий болгох дэмжлэг үзүүлж, малчдад үйлчилгээг ойртуулалгүйгээр байгалийн баялгийн менежментийг дангаар сайжруулах нь тогтворгүй бөгөөд үр дүн багатай байх юм. Цогц, олон салбарыг хамарсан урт хугацааны ҮШСХ нь дараах байдлаар хөдөө орон нутагт өөрчлөлтийг бий болгоход туслах болно. Үүнд: нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй малын нийлүүлэлтийн сүлжээ (НБУАТМААНС)-гээр урамшуулж, тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай, амьдрахад таатай аймаг болон сумдыг хөгжүүлэх болно. ҮШСХ нь энэхүү аргачлалыг бүсчилсэн хөгжлийн стратегидаа тусгаж, орон нутгийн болон үндэсний түвшинд бодлогын шинэчлэл хийж, институтийг бэхжүүлэх ажлыг тусгасан бөгөөд ЭЗХЯ-наас томьёолсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хангамж ба логистикийн кластерын загварт тулгуурласан ногоон хөдөө аж ахуйн бүсчилсэн загварыг²² боловсруулах юм.

8. **Бодлогын хүрээ.** Ерөнхий зураглалын урт хугацааны хөгжлийн стратегийн

дэмжих, импортын хүнсний хараат байдлыг бууруулахын тулд импортыг орлох хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; (iii) хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдаанд стандарт, чанарын хяналт, лаборатори, технологи, ХШҮ-ний механизмыг сайжруулах; (iv) өвс, тэжээлийн дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх; (v) усалгааны систем, усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих; (vi) кластерт суурилсан хөдөө аж ахуйн өртгийн сүлжээг бий болгох зорилгоор хөдөө аж ахуйн паркуудыг хөгжүүлэх; (vii) малын эрүүл мэндийг сайжруулж, бэлчээрийн менежментийг сайжруулах; (ix) эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих; (x) дотоодын хүнсний боловсруулалтыг дэмжих тус тус болно..

¹⁹ Үүнд баруун бүсийн 10 сумд багтсан болно.

²⁰ Хоёр үе шаттай үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө (2021–2030, 2030–2050), АХБ-ны дэмжлэгтэйгээр бий болсон. Монгол Улс: Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр болон Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн Бүс нутгийн хөгжлийн бодлого.

²¹ Байгаль орчин, аялал жуулчлалын яам. 2018. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хүрээнд хэрэгжүүлж буй Монгол Улсын үндэсний гурав дахь тайлан. Улаанбаатар хот

²² Нутаг дэвсгэрт суурилсан хандлага нь эдийн засгийн хөгжил, нийгмийн оролцоо, байгаль орчны тогтвортой байдлын хоорондын стратегийн менежментээр дамжуулан тухайн нутаг дэвсгэрийн боломжийг бүрэн ашиглахад чиглэгддэг. Агро-нутаг дэвсгэрийн хөгжил нь жижиг хот, суурин газрыг хөдөө орон нутгийн "хамрах хэсэг"-тэй холбож, хот, хөдөөгийн ядуу иргэдэд хоол хүнсээр хангагдах, орлого олох боломжийг сайжруулахад зорилготой юм. 2017 он. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага. Хөгжлийн эдийн засгийн бодлогын төлөвлөгөөний тайм: Хөдөө орон нутаг, хот хоорондын хүчтэй үялдаа холбоо нь ядуурлыг бууруулах чухал үүрэгтэй. Ром хот.

зорилтуудтай уялдуулсан тус хөтөлбөр нь бодлогын орчныг бий болгох, чадавхыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт хийхдээ удирдлага болгох харилцан уялдаатай, нэгдсэн зарчмуудыг баримтлах болно. Үүнд: (i) амьдрах орчин, тэргүүлэх ач холбогдолтой хот суурин газрыг орон нутгийн эдийн засгийн тулгуур болгон хөгжүүлэх замаар хэрэгцээтэй цэгт НБУАТМААНС-ний хөрөнгө оруулалтыг татаж, хот-хөдөөгийн эдийн засгийг дахин холбох үүднээс хот-хөдөөг хүртээмжтэй, ногоон болгож эрс шинэчлэх; (ii) бэлчээрийн менежментийн туршлага, анхан шатны зохион байгуулалтыг хөхиүлэн дэмжиж, малчдыг шилжилтийн үед дэмжих, малын эрүүл мэндийг сайжруулж, илүү ашиг шимтэй, чанартай мал аж ахуйг хөгжүүлж, экосистемийн доройтлыг арилгаж, нүүрстөрөгчийг шингээх чадвар, бэлчээр ашиглалт болон малчдын нөхөрлөлийн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн урамшуулалд тулгуурлан, мөн нөөцийн хэмнэлт болон хүнсний үйлдвэрлэлийг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс үл харгалзан хүнсний аюулгүй байдлыг хангах замаар тогтвортой, уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх мөн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс үл хамааран нөөцийн үр ашиг болоод хүнсний үйлдвэрлэлийг боловсронгуй болгох замаар хүнсний аюулгүй байдлыг сайжруулах; (iii) аймгийн болон сум дундын төвд ажиллаж, амьдарч буй малчид, ЖДҮ эрхлэгчид болон хөдөө аж ахуйн салбар дахь бусад оролцогч талуудад санхүүгийн болон санхүүгийн бус хүртээмжтэй, хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлэх боломжоор хангах үр дүнтэй, хүртээмжтэй НБУАТМААНС-г хөгжүүлэх;²³ мөн (iv) нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн шинэлэг төлөвлөгөө, бодлогыг дэмжихийн тулд хөдөө аж ахуйн салбарын бүхий л оролцогч талуудын дунд төлөвлөлт, чадавх, мэдлэг, институцийг сайжруулах тус тус хамаарна.

В. Стратегийн онцлог


9. **Стратегийн онцлог.** Стратегийн онцлог болон ерөнхий зураглалын урт хугацааны хамтын ажиллагаа нь (i) АХБ-ны Монгол Улсын 2021–2024 түншлэлийн стратеги,²⁴ ялангуяа КОВИД-19-ийн дараах эдийн засгийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцэж буй бөгөөд эдийн засгийн тогтвортой өсөлт ба төрөлжилт, хүртээмжийг дэмжих зорилгоор эдийн засгийн агшилт, хурцадмал тэгш бус байдлыг даван туулахад хувь нэмэр оруулна; (ii) АХБ-ны Стратеги 2030 баримт бичгийн үйл ажиллагааны долоон тэргүүлэх чиглэлтэй уялдсан; мөн (iii) хөдөө аж ахуйн худалдаа, бүс нутгийн нийтийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, хил дамнасан малын өвчнийг тогтооход хувь нэмэр оруулах замаар Зүүн Азийн Бүс Нутгийн Хамтын ажиллагааны 2030²⁵ болон Мал, ургамлын эрүүл ахуй, ариун цэврийн арга хэмжээг шинэчилж, худалдааг хөнгөвчлөх мөрийн хөтөлбөрийн зорилготой нийцэж байна.

10. **Хөгжлийн уялдаа холбоо, түншлэл.** Энэхүү хөтөлбөрийг хот байгуулалт, бэлчээрийн менежмент, мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн Монгол Улсад хэрэгжүүлж буй болон төлөвлөсөн хэд хэдэн санаачилгад уялдуулахаар төлөвлөсөн болно. Хотын дэд бүтэц ба үйлчилгээ нь (i) АХБ-ны төслүүд дээр, үүнд: (a) Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоох суурин газруудын хөгжлийн төсөл; (b) Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл; (c) Аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл; болон (ii) ШХА болон Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэй төсөл (Монгол дахь барилга байгууламжийн

²³ Үр дүнтэй НБУАТМААНС нь нүүрсхүчлийн хийг багасгах, байгалийн нөөцийн тогтвортой менежмент болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохыг дэмжихийн зэрэгцээ үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх үйлчилгээг оролцогч талуудад хангаж өгдөг

²⁴ АХБ. 2021 он. *Улс орны түншлэлийн стратеги: Монгол Улс. 2021–2024: Хүртээмжтэй, бөгөөд тогтвортой өсөлтийн бат бөх суурийг тавих нь*. Манила хот;

²⁵ АХБ. 2018 он. *Стратеги 2030: Хөгжин цэцэглэсэн, хүртээмжтэй, тэсвэртэй бөгөөд тогтвортой Ази, Номхон далайн бүс нутгийг бий болгох нь*. Манила хот.



эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл) тус тус хамаарна.²⁶ Түүнчлэн ус; ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийг сайжруулах чиглэлээр АХБ-ны санхүүжилттэй Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулна. Эцэст нь батлагдах шатандаа яваа Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (2-р үе шат) нь баруун бүсийн тус гурван аймагт хэрэгжих тул эдийн засаг, нутаг дэвсгэрийн хөгжлийн стратеги, үр нөлөөний хувьд хоршин ажиллах томоохон боломж олгож буй юм.²⁷

11. Мал аж ахуй, бэлчээрийн тогтвортой менежмент нь (i) “Ногоон алт”- малын эрүүл мэнд, “Ногоон алт”- бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл (1-4-р үе шатууд) (ШХА), (ii) Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил (Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан), (iii) Монголын хөдөө аж ахуйн маркетинг төсөл (Дэлхийн Банк) зэргийн хүрээнд хийсэн ажилтай уялдана. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь (i) Монгол дахь хөдөө орон нутгийн иргэдийн дасан зохицох чадвар, эрсдэлийн менежментийг сайжруулах төсөл (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр [НҮБХХ]); (ii) Монгол Улсын усны нэн чухал хуримтлал газар дахь усны аюулгүй байдлыг хангахад экосистемд суурилсан дасан зохицох арга төсөл (НҮБХХ); (iii) Малын индексжүүлсэн даатгалын төсөл (Дэлхийн Банк); (iv) Хүнсний ногооны үйлдвэрлэл, усалгаатай газар тариаланг дэмжих төсөл (АХБ); (v) Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн төсөл (ШХА); (vi) Тогтвортой ноолуурын төсөл ба Монголын нэхмэлийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл (Хил Хязгааргүй Малын эмч нар ба Агрономчид ТББ болон ЕХ); (vii) Монгол Улсын мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг сайжруулах төсөл (Дэлхийн Банк); (viii) Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төслийн бэлтгэл (АХБ); (ix) Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төсөл (АХБ); (x) Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэмэлт санхүүжилт (АХБ); (xi) Ногоон бэлчээрийн туршилтын төсөл (Мерси Кор, ШХА болон Хасбанк); (xii) Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих төсөл (ЕХ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага хамтран хэрэгжүүлж буй)-тэй тус тус уялдана.²⁸

12. Эдгээр санаачилгууд нь суралцаж, мэдлэг дамжуулах томоохон боломжууд олгохоос гадна харилцан уялдаатай, хоршиж ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Салбарын хувьд хамааралтай хэдий ч эдгээр төслүүд нь томоохон асуудлын зөвхөн тодорхой хэсэгт чиглэсэн байна. Үр өгөөжтэй, тогтвортой шийдэлд хүрэхийн тулд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн болон салбарын ололт амжилтад дөрөөлж, ашиглаж болохуйц цогц зохицуулалттай арга хэмжээг нутаг дэвсгэр, бүсийн нэгдсэн байдлаар уялдаа холбоотой авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

13. **Үе шатлалт санхүүжилтийн хөтөлбөр.** Уг хөтөлбөрийг санхүүгийн зуучлалын зээл (СЗЗ)-ийн бүрэлдэхүүнтэй ҮШСХ-гийн хэлбэрийг ашиглан гурван үе шаттайгаар нийт 10 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. АХБ-ны уг салбарт авч хэрэгжүүлсэн ижил төстэй үйл ажиллагаанаас авсан сургамжаас харахад хот-хөдөөгийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын хүчтэй шинэчлэл хийх, хөтөлбөрийн үр дүнг тогтвортой байлгах, мөн үр дүнг улсын бусад хэсэгт түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төрийн олон байгууллагууд

²⁶ АХБ. Монгол: Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл; АХБ. Монгол: Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл; АХБ. Монгол Улс: Аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл; АХБ. Монгол: Баруун бүсэд сургуулийн дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл; АХБ. Монгол Улс: Хөдөөгийн нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл; Дэлхийн Банк. 2007 он. Бүх нийтийн боловсрол: Эрчтэй хурдасгах сангийн төсөл. Вашингтон ДС хот.

²⁷ АХБ. Монгол Улс: Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх төсөл (2-р үе шат).

²⁸ Гол техникийн тусламж (ТТ)-ид дараах зүйлс орно, үүнд: АХБ. Зүүн хойд Азийн бүс нутгийн бэлчээрийн менежментэд нүүрстөрөгчийн санхүүжилтийг бэхжүүлэх нь төсөл; АХБ. Монгол Улс: Хоршоод суурилсан хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл төсөл; АХБ. Монгол Улс: Монголын баруун бүсэд нэмүү өртөг шингээсэн үйл ажиллагааг дэмжих нь; болон АХБ. Монгол улс: Монгол орны ой, бэлчээрийн тогтвортой менежментэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хурдасгаж нь.

нягт уялдаа холбоотой ажиллах, төрийн чадавхаа сайжруулах шаардлагатай байдаг.²⁹ Үүнийг ҮШСХ-гийн үе шат, бүтэц бүрэлдэхүүн хэсэгтэй уялдуулсан нарийвчилсан бодлогын хүрээ, чадавхыг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг, оролцогч талуудын оролцоог хангах нарийвчилсан төлөвлөгөөнд суулгаж өгсөн. ҮШСХ-гийн хэлбэр нь шаардлагатай өөрчлөлт хийх АХБ-ны оролцоо, саад бэрхшээлийг арилгах, дараалсан үе шаттайгаар үр дүнг хэрэгжүүлэх, мөн ерөнхий зураглал болон хөтөлбөрт зорьсон суурь өөрчлөлтийг хангах ач холбогдолтой. Дараагийн үе шатны хөрөнгө оруулалт нь ҮШСХ ба түүний бүрэлдэхүүн хэсгийн бүтцийн хүрээнд хэрэгжих бөгөөд эхний үе шатны хэрэгжилт, дэд төслийн бэлэн байдал, сонгон шалгаруулалтын шаардлага болон бусад шийдвэр (Хуваарь 4)-ээс хамааран бусад үе шатуудын хэрэгжих эсэхийг нь шийдвэрлэнэ.


14. **Санхүүжилтийн хэлбэрийн давуу тал.** Бусад хэлбэртэй харьцуулахад зөвхөн ҮШСХ нь зорилтот бүлгүүд, Засгийн газар, хувийн хэвшил хамтран мал аж ахуйн салбар, хотын эдийн засаг ажиллаж байгаа одоогийн тогтсон жишгийг тогтвортой өөрчлөхөд шаардлагатай чухал масс, залгамж чанар, түгээн дэлгэрүүлэх механизмыг бүрдүүлж чадна.³⁰ ҮШСХ-ийг тодорхой хамрах хүрээтэй, үе шаттай багцлан хэрэгжүүлснээр Засгийн газар ерөнхий зураглалын зорилгоо хангахад шаардлагатай ногоон хөдөө аж ахуйн бүсчилсэн загварыг ЭЗХЯ-ны тодорхойлсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хангамж болон логистикийн кластерт төвлөрсөн байдлаар хөгжүүлж, улс даяар түгээн дэлгэрүүлж, тогтвортой авч явах боломжтой юм. Тодруулбал, тус санхүүжилтийн хэлбэр нь дараах боломжийг авчирна, үүнд: (i) урт хугацааны тогтвортой оролцоо, үе шаттай байхыг шаарддаг үйл явц, төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгох; (ii) Үе шат 1-ийн хүрээнд туршсан инновацыг тухайн үеийн эрч хүч, чадавх болон мэдлэгийг алдалгүйгээр өргөжүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх; (iii) өмнөх үе шатаас олж авсан сургамжаа дараагийн үе шатад цаг тухайд нь авч хэрэгжүүлэх, орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн шаардлагатай тохируулга хийх; (iv) байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааны механизмыг урьдчилан бэхжүүлж, дараагийн үе шатанд үргэлжлүүлэх; (v) оролцогч талууд болон хөгжлийн түншүүддээ бодлогын яриа хэлэлцээр хийхэд олон нэвтрэх цэгийг бий болгож, өмнөх үе шатаас авсан сургамжийг дараагийнх руу нэвтрүүлэх; мөн (vi) нарийвчлан тодорхойлсон бэлэн байдал болон сонгон шалгаруулалтын шалгуурыг ашиглан, ЭЗХЯ-ны тодорхойлсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хангамж болон логистикийн кластерт төвлөрсөн байдлаар тус салбарын бусад санаачилгаас гарсан сайн туршлагыг ногоон хөдөө аж ахуйн бүсчилсэн хөгжлийн загварт тусгаж, түгээн дэлгэрүүлэх зэрэг давуу талтай юм.

15. **Санхүүгийн зуучлагчийн шаардлага.**³¹ Санхүүжилтийг оролцогч банк руу дамжуулахад санхүүгийн толгой байгууллага байгуулсан байна. Санхүүгийн зуучлагчдыг сонгохдоо дараах зүйлсийг багтаасан шаардлага, сонгон шалгаруулалтын шалгуур дээр үндэслэнэ. Үүнд: (i) Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тус улсад албан ёсоор бүртгэгдсэн банк; (ii) зорилтот аймаг, сумдад хөдөө аж ахуй, агро-бизнесийн иргэдийн банкны үйлчилгээ эрхлэх чадавхтай байх; (iii) АХБ-ны тайлагнал, засаглал, хамгаалал, санхүүгийн магадлан судалгааны бодлого, стандартад нийцсэн байх; (iv) Монголбанкны өмнө хугацаа хэтэрсэн аливаа үүрэг хариуцлагагүй байх эсвэл аудитын сөрөг дүгнэлт аваагүй байх; мөн (v) зорилтот аймгуудад хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байсан мөн олон салбарт санхүүжилт олгож байсан туршлагатай байх зэрэг багтана.

²⁹ Хот байгуулалт, бэлчээр, мал аж ахуйн менежмент, мөн ЖДҮ, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдэд үзүүлсэн санхүүгийн зуучлал ба дэмжлэгийн сургамжийг "Салбарын үнэлгээ (Хураангуй): Ус ба бусад хотын дэд бүтэц, үйлчилгээ; хөдөө аж ахуй, байгалийн нөөц ба хөдөөгийн хөгжил (Ерөнхийлөгчийн тайлан, зөвлөмж [ЕТТ]-ийн Хавсралт 2-т тусгасан холбогдох баримт бичгийн жагсаалтаас авах боломжтой); болон хөгжлийн зохицуулалт"-д тусгасан (Ерөнхийлөгчийн тайлан, зөвлөмж [ЕТТ]-ийн Хавсралт 2-т тусгасан холбогдох баримт бичгийн жагсаалтаас үзэх боломжтой).

³⁰ Санхүүжилтийн хэлбэрийн харьцуулалт (ЕТЗ-ийн Хавсралт 2-т холбогдох баримт бичгүүдийн жагсаалтаас авах боломжтой)

³¹ Нарийвчилсан шаардлага болон сонгон шалгаруулалтын талаар Хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага (ХХГА)-д тусгасан болно (ЕТЗ-ийн Хавсралт 2-т холбогдох баримт бичгүүдийн жагсаалтаас авах боломжтой)



16. **Үе шат 1-3-ын хамрах хүрээ.** Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг 1 болон 2-ын зорилтот хөрөнгө оруулалтад 15 хүртэлх тооны аймгийг хамруулна.³² Бүрэлдэхүүн хэсэг 3-т дээр дурдсан аймгуудыг хамрахаас гадна Хавсралт 1-т тодорхойлсон шалгуурт үндэслэн Монгол улсын хэмжээнд хэрэгжих боломжтой. **Үе шат 1 нь 7 аймагт** хэрэгжинэ. Үүнд Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудад зорилтот хөрөнгө оруулалт хийгдэх ба; дээр нь анхан шатны үйл ажиллагаа болон төслийн бэлтгэл ажлын хүрээнд 4 хүртэлх аймгийг нэмэлтээр Хуваарь 4-т тодорхойлсон шалгуур болон ЭЗХЯ-наас тодорхойлсон хөдөө аж ахуйн кластер байршлын үндсэн дээр Үе шат 1-ийн үед тодорхойлох болно. Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн үйл ажиллагаа (i) Өлгий аймгийн төв болон Баян-Өлгий дэх Дэлүүн сум дундын төв; (ii) Ховд аймгийн төв; болон (iii) Улаангом аймгийн төв болон Увс дахь Өмнөговь сум дундын төвд тус тус хэрэгжинэ. Бүрэлдэхүүн хэсэг 2 нь Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд хамрагдах зорилтот аймаг, сумын нөлөөллийн бүсэд орших ойролцоо сумын төвүүдэд бүгдэд нь хэрэгжинэ.³³ **Үе шат 2 нь Үе шат 1-ийн үйл ажиллагааг цаашид эрчимжүүлэх үүднээс өмнөх үе шатад хамрагдсан аймгууд болон Хуваарь 4-т заасан шалгуурт үндэслэн нэмж сонгосон бусад аймгуудыг хамрах бөгөөд ЭЗХЯ-наас хөдөө аж ахуйн хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой тодорхойлсон байршлуудад тулгуурласан байна (зүүлт 33).** Үе шат 2 нь хөтөлбөрийн зорилтуудтай нийцэж буй АХБ болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн эсвэл бусад санаачилгын хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн ажил мөн хөтөлбөрийн ногоон хөдөө аж ахуйн бүсчилсэн загварт нийцэж байгаа бусад төсөлтэй уялдуулна.³⁴ Үүний адилаар үе шат 3-ын хүрээнд бусад аймаг дахь орон нутгийн амжилтыг үнэлж, хөтөлбөрийн ногоон хөдөө аж ахуйн бүсчилсэн загварыг бүрдүүлэхэд шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтыг хийж, тэргүүлэх ээлжид хамруулахаар тодорхойлсон 15 аймагт тулгуурласан (зүүлт 33) газарзүйн илүү өргөн хүрээг хамруулахын тулд нөөцийг илүү стратегитай ашиглана.

С. Бодлогын хүрээ


17. Бодлогын хүрээ, чадавхын хөгжүүлэлт нь ерөнхий зураглалын стратегийн зорилгуудтай нийцэж байгаа бөгөөд дараахыг дэмжинэ. Үүнд:

- (i) **Стратегийн зорилт 1** нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хотын үйлчилгээ, зохицуулалт ба төлөвлөлтийг дараах замаар сайжруулах, үүнд (a) ялангуяа нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хотжилтын үйл явцыг дэмжих дүрэм, стандарт ба газар ашиглалтын менежментийг ашиглах;; (b) зорилтот *аймгийн* хотын чиг үүргийг зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; (c) газар ашиглалт болон нөөцийн менежмент болон хүнсний аюулгүй байдлын зорилгоор ухаалаг, цогц бөгөөд нэгдсэн цахим менежментийн систем хөгжүүлэх; (d) хотын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүгийн чадавхыг сайжруулах; (e) хот суурин газруудыг нүүрстөрөгчийн агууламж багатай хөдөө аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээ, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх хурдасгуур болох үүргийг нь дахин сэргээх; (f) *аймгийн төвд* зохион байгуулалтгүй *гэр* хорооллыг сайжруулах загварыг судлах; (g)

³² Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хангамж ба логистикийн кластерийн тэргүүлэх ач холбогдолтой ЭЗХЯ-наас тодорхойлсон байршил, мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, хотжилтын түвшин, хот байгуулалт, бэлчээрийн доройтол ба даац хэтрэлт, уур амьсгалд эмзэг байдал, мал аж ахуйн агро-бизнес хөгжүүлэх боломж зэрэг бусад шалгуур үзүүлэлтэд тулгуурласан болно. Хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдлоор нь дараах 15 хүртэлх аймгийг сонгосон болно, үүнд: 1. Ховд, 2. Увс, 3. Баян-Өлгий, 4. Архангай, 5. Дорнод, 6. Төв, 7. Хэнтий, 8. Булган, 9. Сэлэнгэ, 10. Дундговь, 11. Дархан-Уул, 12. Хөвсгөл, 13. Өвөрхангай, 14. Баянхонгор, 15: мөн Завхан тус тус болно.

³³ Ховд аймгийн өмнөд хэсэг эсхүл бусад аймгууд or in other Aimags, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр Монгол Улс. 2021. Монгол дахь орон нутгийн иргэдийн дасан зохицох чадвар, эрсдэлийн удирдлагыг сайжруулах нь. Улаанбаатар хот; АХБ. Монгол Улс: Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл; болон АХБ. Монгол Улс: Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай тариалангийн төсөл.

³⁴ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Монгол Улс. 2021 он. Монгол Улсын хөдөө орон нутгийн иргэдийн дасан зохицох чадвар, эрсдэлийн удирдлагыг сайжруулах нь. Улаанбаатар хот; АХБ. Монгол Улс: Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл; болон АХБ. Монгол Улс: Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай тариалангийн төсөл.



нүүрстөрөгч багатай цэвэр эрчим хүчний шилжилтийг дэмжих (h) хөдөөгийн эдийн засгийн шинэчлэлийг дэмжих үүднээс нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй сум, сум дундын хөгжлийн загварыг бий болгох тус тус болно.

- (ii) **Стратегийн зорилт 2** нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй бэлчээр, мал аж ахуйн менежментийг дараах замаар сайжруулна, үүнд: (a) нутаг дэвсгэр бүрийн бэлчээрийн багтаамжаас хамааран малын төрөл зүйл бүрийг жагсаах, дугаарлах зохицуулалтын механизм нэвтрүүлэх; (b) бэлчээрийн даац хэтрэлтээс үүдэлтэй газрын доройтлыг зогсоох зорилгоор бэлчээр ашиглалт, тэжээлийн үйлдвэрлэлийг удирдах хамтын тогтолцоо нэвтрүүлэх; (c) ямааны бэлчээр хязгаарлалтын бүс, хугацааг тогтоох; (d) мал үржил, мал эмнэлгийн үйлчилгээ, байршил илрүүлэх боломжийг сайжруулах, (e) мал аж ахуйн тэсвэртэй байдал ба ашиг шимийг сайжруулах (f) мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний түвшин тус бүрд гэрчилгээжүүлэлтийн нэгдсэн систем нэвтрүүлэх; (g) бэлчээр ашиглалтын дадлыг сайжруулах; (h) малчдын хоршоодын зохион байгуулалт, үйл ажиллагаанд техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (i) нүүрстөрөгч багатай мал аж ахуйн менежментийн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаанд урамшуулал олгох; (j) малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, мал аж ахуйн бүтээгдэхүүн ба орон нутгийн хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ хоорондын уялдаа холбоог сайжруулах; (k) сайжруулсан усалгааны систем, ус хэмнэх арга хэмжээ, шийдлээр дамжуулан байгалийн нөөцийн менежментийг сайжруулах; (l) сумын түвшинд өвс, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, стратегийн нөөц газартай болоход дэмжлэг үзүүлэх; (m) бэлчээрийн цаашдын доройтлоос урьдчилан сэргийлэх, хөрсний нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа; (n) сүргийн тоо толгойг багасгах; мөн (o) хүнсний аюулгүй байдал болон тогтвортой хүнсний хангамжийг үндэсний хэмжээнд сайжруулах тус тус болно.
- (iii) **Стратегийн зорилт 3** НБУАТМААНС-г дараах замаар сурталчлах бодлогын шинэчлэл хэрэгжүүлнэ, үүнд (a) малчид, хөдөө аж ахуйн хоршоологчдод нийлүүлэлтийн сүлжээнд бүрэн оролцох боломжийг олгоход чиглэсэн барьцаа хөрөнгө орлуулах, зээлийн батлан даалт зэрэг шинэлэг санхүүгийн хэрэгслүүд нэвтрүүлэх; (б) нүүрстөрөгч багатай, тогтвортой бэлчээрийн менежмент, хот-хөдөөгийн холбоосыг сайжруулах, эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлээр ажилладаг малчдын хоршоо, мал аж ахуйн бизнесийг санхүүжүүлэх зорилгоор хувийн хэвшил болон төсвийн хязгаарлагдмал хөрөнгө оруулалтын холимог эх үүсвэртэй бүсийн хөдөө аж ахуйн бизнесийн сан байгуулах, ажиллуулах; (в) НБУАТМААНС-тэй холбоотой инновацыг нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор хувийн хэвшилд төсөлд зарцуулсан зардлын үнийн дүнг нөхөн олгох санхүүгийн дэмжлэгийг олгох тогтолцоог хөгжүүлэх тус тус болно.
- (iv) **Стратегийн зорилт 4** нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй нутаг дэвсгэрийн хөгжлийг бий болгох бодлогын шинэчлэлийг дараах замаар хийх, үүнд (a) газар зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн менежментийг оновчтой болгох систем, хэрэгслүүдийг нэвтрүүлэх; хяналт тавих, тайлагнах, баталгаажуулах механизмыг ашиглах зэргээр бэлчээрийн менежментийг сайжруулах; кадастрын чадавхыг бэхжүүлэх; *аймаг, сумдад* нутаг дэвсгэрийн удирдлагын нэгдсэн дэмжлэг үзүүлэх; (b) олж авсан сургамж мэдлэгийн бүтээгдэхүүнийг боловсруулах, түгээх, мөн Монгол мал үндэсний хөтөлбөр, бэлчээрийн тухай хууль, малын тоо толгойн албан татварын тухай хууль, мах, махан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой үйл ажиллагааны журмыг шинэчилж, боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах; (c) газар ашиглалт, хотын чиг үүрэг, үйл ажиллагаа, шатлал, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг дэмжих зэрэг хот-хөдөөгийн зохион байгуулалтын стратеги нэвтрүүлэх; (d) *аймаг, сумдын* ус тэсвэрлэх чадварыг сайжруулах

төлөвлөлт, хэрэгжилтийг хөнгөвчлөх аргачлалыг нэвтрүүлэх; мөн (е) дотоод болон гадаадад хөтөлбөрийн түгээн дэлгэрүүлэх боломжтой механизм, мэдлэгийг бий болгож, түгээх зэрэг болно.

D. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр

18. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дараах үр нөлөөтэй уялдуулна, үүнд: ногоон хөгжил, бүс нутгийн хөгжлийн тогтвортой байдал, амьдралын чанар болон хүний хөгжлийг хангах (зүүлт 14). Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь дараах үр дүнг хангах болно: ногоон, хүртээмжтэй, хөдөө аж ахуйн нутаг дэвсгэрийн хөгжлийг цогцлоох.³⁵


19. **Бүрэлдэхүүн хэсэг 1: Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай, татах чадвар бүхий аймаг болон сум төвүүдийг хөгжүүлэх нь.** Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд зорилтот аймаг, сум дундын төвүүдийг нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ (НБУАТМААНС)-ний хөрөнгө оруулалт татаж, уур амьсгалд тэсвэртэй хөдөөгийн эдийн засгийн тулгуур болгоход түлхэц үзүүлэх тэргүүлэх чиглэлийн дэд бүтэц болон үйлчилгээг хөгжүүлнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь ЭЗХЯ-наас тодорхойлсон хөдөө аж ахуйн логистик, ханган нийлүүлэлтийн төв, үйлдвэр болон кластерын зориулалттай тодорхойлсон байршилд тулгуурлан ногоон агро-бизнесийн хөгжил болон хөдөө аж ахуйн салбарыг дэмжихэд шаардлагатай аймаг, сумдын дэд бүтцийн дутагдлыг шийдвэрлэх юм. Үүний хүрээнд хотын үйлчилгээний өнөөгийн дутагдалтай байдал (төвлөрсөн дулаан хангамж, ус зайлуулах хоолой, үерийн хамгаалалт, эрчим хүч, авто зам, хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, бохир ус цэвэрлэх, усан хангамж)-ыг шийдвэрлэж, аймгийн болон сум дундын төвүүдийн амьдрах орчныг сайжруулахад нэгдсэн, цогц аргачлалыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүний хэмнэлттэй хотын үйлчилгээ болон барилга байгууламжийг ашиглах замаар нүүрстөрөгч багатай шийдлийг дэмжих юм. Зорилтот *аймаг, сумын төв тус бүр* НБУАТМААНС-нд зориулсан хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн парк, түүний дотор боловсруулах үйл ажиллагааг татахуйц инженерийн шугам сүлжээ, инкубаторын төв зэргийг байгуулна.³⁶ Эцэст нь, газар зохион байгуулалтын ухаалаг төв нь газар зохион байгуулалт, хот байгуулалтын менежментийг сайжруулж, бэлчээрийн эрүүл мэнд, усны нөөц, хөрсний нүүрс төрөгчийн шингээлтийг хянах болно.³⁷

20. **Бүрэлдэхүүн хэсэг 2: Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй бөгөөд тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх нь.** Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нэмүү өртөг өндөр шингэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ бэлчээрийн доройтлыг арилгах зорилгоор эмзэг бүлгийн малчдын бүлгийн мал аж ахуйн менежментийн тогтвортой үйл ажиллагаа эрхлэлт (бэлчээрлэх дадлыг сайжруулах, сүргийн бүтцийг тэнцвэржүүлэх, сүргийн тоо толгойг багасгах, малын үүлдэр угсааг сайжруулах г.м)-ийг дэмжих юм. Үүний хүрээнд БАГ-т гарын үсэг зурсан, хамтын оролцоотой, хүртээмжтэй сүргийн менежментийн төлөвлөгөө (ХОХСМТ)-нд багтсан БАХ-т хамаарах малчдын бүлгүүдийн дунд олон нийтэд түшиглэсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх, оролцогч БАХ-ийн хоршоодод санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гэрчилгээжүүлэх систем, журмыг бий болгох, сүргийн тоо толгойг багасгах урамшуулал олгох, мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг өсөн нэмэгдүүлэх, сүргийн зохистой бүтцийг бий болгох, мал үржүүлгийг сайжруулах мөн тэжээлийн үйлдвэрлэлийг

³⁵ Хяналт-шинжилгээний ерөнхий хүрээг Хуваарь 2-т харуулсан.

³⁶ Хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн паркууд нь боловсруулах байгууламжуудыг хэрэгцээтэй цэгт бий болгож (улмаар боловсруулах хэлхээг богиносгож, мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулж, малчид, бэлчээрийн менежмент, хүнсний үйлдвэрийн хооронд газарзүйн болон эдийн засгийн уялдаа холбоог сайжруулах замаар орон нутгийн эдийн засгийг дэмжих болно), хүнсний экспорт болон эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлнэ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт болон логистикийн кластеруудыг ЭЗХЯ-наас эрэмбэлэн гаргана.

³⁷ Бэлчээрийн эрүүл мэнд гэдэг нь түүний бүтээмж, биологийн олон янз байдлыг тогтвортой байлгах байгаль орчны цогц нөхцөлийг хэлнэ.



нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.³⁸ Усалгаатай газарт хийх сайжруулах ажил, ус хамгаалах шийдлүүд нь тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй усны хомсдолыг даван туулах малчдын чадварыг нэмэгдүүлэх боломжийг олгоно. Малын эрүүл мэндийн найдвартай хяналт, мөшгөх тогтолцоог бий болгохын тулд хөдөө аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээний шат дамжлага болгонд мал эмнэлгийн үйлчилгээг бэхжүүлнэ. Үүнд хөдөө аж ахуй үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт болон логистикийн кластерыг дэмжих үүднээс ЭЗХЯ-ны тодорхойлсон байршил дахь мал эмнэлгийн лаборатори байгуулахад ажил мөн багтсан болно. Гэрчилгээжүүлэх систем ба малын чанар, эрүүл мэндийг сайжруулсан байх нь НБУАТМААНС-ийн хөрөнгө оруулалтыг татах, гэрчилгээжсэн малчид, хоршоо, БАХ-үүдийг холбох, мөн малчдын амьжиргааг тогтвортой байлгахад нэн чухал юм.

21. Бүрэлдэхүүн хэсэг 3: Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй малын өртгийн сүлжээг бий болгох хүртээмжтэй санхүүжилтийг бий болгох (СЗЗ-тэй бүрэлдэхүүн хэсэг). Уг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд зорилтот байршил, ялангуяа ЭЗХЯ-наас тодорхойлсон хүнсний үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт ба логистикийн кластерууд дахь агро-бизнес эрхэлдэг ЖДҮ-т тулгардаг санхүүгийн бэрхшээлийг арилгах үүднээс уур амьсгалын ухаалаг санхүүгийн механизм болон институцийн зохион байгуулалтаар хангах нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөө БНХХААБС-г байгуулна. БНХХААБС-г НБУАТМААНС-нд хувийн хэвшлийн оролцоог татахад ашиглах юм. БНХХААБС нь дараах шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ, үүнд: (i) зах зээлээс доогуур хүүтэй, зээлийн нөхцөл сайн, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаатай, санхүүжилт өндөртэй бөгөөд Хуваарь 1-ийн 4-р дэд хэсэгт дурдсан ЖДҮ-т тулгарч буй санхүүгийн саад бэрхшээлүүдийг шийдвэрлэж, НБУАТМААНС-ийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн мөчлөг, улирлын шинж чанарыг харгалзан тохируулга хийсэн эргэн төлөлтийн төлөвлөгөө бүхий зээл;³⁹ (ii) зээл олгохдоо барьцаа хөрөнгийн оронд зээлийн батлан даалтын үйлчилгээ ашиглан санхүүжүүлэгчдийн эрсдэлийг бууруулж, улмаар зээлийн хүүг бууруулж, БНХХААБС-ний зээлд хамрагдах боломжийг хөнгөвчлөх; мөн (iii) шинэлэг ногоон бүтээгдэхүүн, процесс, бизнесийн загварыг хөгжүүлэх замаар шинэлэг хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг дэмжих инновацын дэмжлэг олгох зэрэг болно. Орон нутгийн хөгжил, экспортыг дэмжих зорилгоор бэлчээрийн тогтвортой менежментийн хүрээнд гэрчилгээжсэн бөгөөд боломжтой бол хөдөө аж ахуйн паркуудад байрлах малчид, БАХ, хоршоодтой нийлүүлэлт талын холбоос мөн/эсхүл ашиг хуваах тодорхой механизмыг бий болгох хөрөнгө оруулалтыг БНХХААБС дэмжих юм.

22. Бүрэлдэхүүн хэсэг 4: Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бүсчилсэн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх нь. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөтөлбөрийн үр дүнтэй удирдлага, хэрэгжилтийг

³⁸ ХОХСМТ нь бэлчээрийн менежмент, малын чанар, БАХ-ын гишүүдийн амьжиргааг сайжруулахад чиглэсэн богино болон дунд хугацааны хөрөнгө оруулалт, арга хэмжээг тодорхойлж, эрэмбэлдэг. БАХ нь түүний бүрэлдэхүүн нэг хэсэг юм.

³⁹ БНХХААБС нь зээлийн гурван цонхтой байна. Цонх 1-ийн хүрээнд малын боловсруулалт, жижиглэнгийн худалдаа, экспортын зориулалттай арилжааны болон логистикийн хөрөнгө оруулалт, эдийн засгийг төрөлжүүлэх бусад хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлдэг ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор жилийн 7.0%-8.5% хүүтэй, 10 хүртэлх жилийн хугацаатай гурван ангиллын зээл олгоно. Дэд төслүүдийг ЖДҮ эрхлэгчид баталгаажсан малчдын хоршоодтой түншлэлийн болон ашиг хуваах гэрээгээр хэрэгжүүлж, НБУАТМААНС-нд тусгасан байж зээлд хамрагдах шаардлага хангасан гэж үзнэ. Цонх 2-ын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, маркетинг, олон улсын худалдаанд оролцдог мэргэшсэн дунд, том үйлдвэрүүдэд жилийн 10-12% хүртэл хүүтэй зээл олгоно. Тухайн хөдөө аж ахуйн бизнес эрхлэгч компаниуд нь НБУАТМААНС-тэй нийцсэн, тууштай үйл ажиллагаа явуулдаг байх ёстой. Цонх 3-ын хүрээнд хадгаламжийн зээлийн хоршоогоор дамжуулан гол төлөв гэртээ бичил үйлдвэр эрхэлж буй баталгаажсан малчдад чиглэсэн бичил санхүүжилтийн боломжит өргөжүүлэх ажлыг туршина. Санхүүжилтийн нөхцөл, нарийвчилсан мэдээллийг ХХГА-ын Хавсралт 3-т тусгасан Хайрцаг 4 (ЕТЗ-ийн Хавсралт 2-т тусгасан холбогдох баримт бичгийн жагсаалтаас үзэх боломжтой) болон энэхүү СЕХ-ийн Хавсралт 1-д оруулсан.

хангах засгийн газар болон бусад оролцогч талуудын чадавхыг⁴⁰ тур дундаа ЭЗХЯ-наас тодорхойлсон тэргүүлэх ач холбогдолтой байршлуудад бэхжүүлэхэд чиглэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 4 нь (i) ХОХСМТ, нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн хөгжлийн төлөвлөгөө (НБУАТХААБХТ), хотын ногоон хөгжил, мөн гэрчилгээжүүлэлт ба мөшгөх тогтолцоо зэрэг хөтөлбөрийн бусад бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтэд шаардлагатай зөөлөн арга хэрэгсэл болон төлөвлөгөөг нэвтрүүлж; (ii) хөтөлбөрийн хэмжилт, тайлагнал ба баталгаажуулалт, хянах, үнэлэх системийн боловсруулалт, суурилуулалт болон ашиглалтыг дэмжиж; мөн (iii) хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн паркийн менежменттэй холбоотой төр-хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтыг судална. Хөдөө аж ахуйн бүсчилсэн, ногоон, нэгдсэн хөдөө аж ахуйн хөгжил, мөн уур амьсгалын ухаалаг мал аж ахуй, бэлчээрийн менежмент, хот байгуулалтын хөгжилд тохирсон бодлого, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, мөн мөрдүүлэх төрийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн бодлогын хүрээг энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мөн авч хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хөдөө аж ахуйн бүсчилсэн хөгжлийн загварыг Монголд болон гадаадад түгээн дэлгэрүүлэхээр бодлогын яриа хэлэлцээр, нөлөөллийн ажил хийж, нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бэлчээрийн менежментийн чиглэлээр Төв Азид түншлэл үүсгэх боломжийг судлах юм.⁴¹

E. Санхүүжүүлэх төлөвлөгөө

23. Хөтөлбөрийн нийт өртгийг 735.0 сая ам.доллар байхаар тооцсон. Хөтөлбөрийн 1, 2, 4-р бүрэлдэхүүн хэсгийг хамарсан хөрөнгө оруулалт 617.4 сая ам.доллар байна (Хүснэгт 1). СЗЗ-ийг хамарсан Бүрэлдэхүүн хэсэг 3-т ойролцоогоор 117,6 сая ам.доллар шаардагдана. Зардлын данс, санхүүгийн эх үүсвэрээр ангилсан зардлын нарийвчилсан тооцоог хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага (ХХГА)-д оруулсан болно.⁴² Хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг нь барилгын ажил, тоног төхөөрөмж, БАХ, хоршоодод үзүүлэх дэмжлэг, зураг төсөл, барилгын хяналт, төслийн удирдлага, хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг, хамгаалал, магадлан судалгаа, зөвлөх үйлчилгээг хамарна.

Хүснэгт 1: Зардлын хураангуй

(сая ам.доллар)

Зориулалт.	Хэмжээ ^a
A. Суурь зардал^b	
1. Бүрэлдэхүүн хэсэг 1: Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай, татах чадвартай аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх	395.7
2. Бүрэлдэхүүн хэсэг 2: Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй бөгөөд тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх	99.2
3. Бүрэлдэхүүн хэсэг 4: Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бүсчилсэн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх	38.5
Дэд нийлбэр (A)	533.4
B. Магадлашгүй зардал^b	59.3
C. Хэрэгжилтийн явцад тооцох санхүүжилтийн төлбөр^c	24.7
Нийт (A + B + C)	617.4

^a Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 48.0 сая, төслийн 1-д 16.2 сая ам.долларын татвар, хураамж оруулан тооцсон дүн. Энэхүү дүн нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зардлын томоохон хэсгийг эзлэхгүй болно. Засгийн газар татвар, хураамжаас чөлөөлөх замаар энэхүү хэсгийг санхүүжүүлнэ.

^b 2020 оны 11-р сарын 30-ны байдлаарх үнэ.


^c Барилгын ажил, бараа болон зөвлөх үйлчилгээний магадлашгүй зардлыг 5% гэж тооцсон. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнийн магадлашгүй зардлыг гадаад валютын зардлын хувьд 1.4%, дотоодын валютын зардлын хувьд 6.4% гэж тооцсон бөгөөд худалдан авах чадварын квотын ханшийн таамаглалд үндэслэн ханшийн хэлбэлзлийн боломжит эрсдэлийн нөөцийг тооцон оруулав.

^f Үүнд хүүгийн төлбөр, хөрөнгө хуваарилсны төлбөр болон бусад санхүүжилтийн шимтгэлийг оруулж тооцов. Барилгын ажлын явцад хүүг тооцоолохдоо (i) ердийн хөрөнгийн эх үүсвэр (ЕХЭҮ)-ийн хувьд 5 жилийн ам.долларын тогтмол своп хүү, хүчин төгөлдөр гэрээний хүү 0.5% болоод матюрити шимтгэл 0.1%-ийн

⁴⁰ Үүнд ХАА-н салбарын мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид, малчид, тариаланчид, хувийн хэвшил болон ЖДҮ багтана.

⁴¹ ХХГА-ийн 6-р хайрцгийг үзнэ үү (ЕТЗ-ийн Хавсралт 2-т холбогдох баримт бичгийн жагсаалтаас үзэх боломжтой).

⁴² ХХГА (ЕТЗ-ийн Хавсралт 2-т холбогдох баримт бичгийн жагсаалтаас үзэх боломжтой).



нийлбэрээр, (ii) хөнгөлөлттэй ердийн хөрөнгийн эх үүсвэр (хөнгөлөлттэй ЕХЭҮ)-ийн хувьд жилийн 2%-иар тус тус тооцов. Зарцуулагдаагүй зээлийн дүнд тооцогдох ЕХЭҮ-ийн зээлийн хариуцлагын хураамж нь жилийн 0.15%. Уур амьсгалын ногоон сан зээлийн санхүүжилтийн төлбөрт жилийн 0.25%-ийн үйлчилгээний төлбөр, зээлийн зарцуулаагүй үлдэгдэл тооцогдох 0.50%-ийн төлбөрийн хураамжийг оруулсан болно. Европын хөрөнгө оруулалтын банкны зээлийн хэрэгжилтийн явцад санхүүжилтийн төлбөрийг 5 жилийн ам.долларын тогтмол своп хүүгээр тооцсон.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банкны тооцоо.

24. **Санхүүжилтийн төлөвлөгөө.** Засгийн газар нь холимог эх үүсвэртэй ҮШСХ-өөс нийт 448 сая ам.долларын хүртэлх санхүүжилт авах хүсэлт гаргасан бөгөөд үүнд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл (135 сая ам.доллар), АХБ-ны Тусгай сангийн эх үүсвэр (Азийн хөгжлийн сан [АХС])-ийн буцалтгүй тусламж (3 сая ам.доллар), АХБ-наас удирдан зарцуулах Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гийн хамтарсан санхүүжилтийн зээл (130 сая ам.доллар) болон буцалтгүй тусламж (45 сая ам.доллар)-аас тус тус бүрдэж байна. Европын хөрөнгө оруулалтын банкнаас 150 сая ам.доллартой тэнцэх зээл, 30 сая ам.доллартой тэнцэх буцалтгүй тусламжийг хамтран санхүүжүүлэх юм (АХБ-наас удирдан зарцуулахгүй).⁴³ Татвар, хураамж, нүүлгэн шилжүүлэлт, барилгын ажил, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ, төслийн удирдлага болон бусад зардлыг багтаасан 75.3 сая ам.долларыг Засгийн газраас санхүүжүүлнэ. Хөрөнгө оруулалтын төслийн бүрэлдэхүүн хэсэг нь 1, 2, 4-р бүрэлдэхүүн хэсгүүдэд хамаарах бөгөөд 617.4 сая ам.долларын өртөгтэй болно. Бүрэлдэхүүн хэсэг 3-ыг С33-ийн хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газар үүнд зориулж УАНС-гийн зээлээс 87.6 сая ам.долларыг БНХХААБС-д хуваарилна. Түүнчлэн УАНС-гийн 5.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийг Засгийн газраас хэрэгжүүлж буй ногоон инновацын буцалтгүй тусламжийн хөтөлбөрт олгож, ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн инновацыг сурталчлах зорилгоор шаардлага хангасан хөрөнгө оруулагчдад төсөлд оруулсан зардлын үнийн дүнг нөхөн олгох санхүүгийн дэмжлэгийг хэрэгжүүлэх болно. Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгийн удирдлагын компани (МУХБ-ХУК) нь БНХХААБС-г удирдан зохион байгуулах бөгөөд хөтөлбөрийн санхүүжилтийг шаардлага хангасан байдал, сонгон шалгаруулалтын шаардлага хангасан эсэхээс хамааран санхүүгийн зуучлагчаар дамжуулан олгох санхүүжилтийг хариуцсан санхүүгийн толгой байгууллага болно.⁴⁴ УАНС-ийн зээлийн хөрөнгө нь 25.0 сая ам.долларын хамтарсан санхүүжилт гаргах хувийн бизнес эрхлэгчид, Монгол Улсын Хөгжлийн банк болон бусад арилжааны банкнуудад очихоор тооцоолж байна. Ашиг хүртэгч өрхүүдийн оруулах хувь нэмрийг 6.7 сая ам.доллар гэж тооцсон. ҮШСХ нь Засгийн газраас холбогдох санхүүжилтийн талаар үечилсэн санхүүжилтийн хүсэлт гаргаж, үе шат тус бүртэй холбоотой зээл, төслийн гэрээний биелэлт, санхүүжилтийн хүрээний гэрээнд заасан нөхцөл, журам, шаардлагыг бүрэн хангаж ажилласан эсэхээс хамааран гурван үе шаттай хэрэгжих юм.

Хүснэгт 2: Санхүүжүүлэх төлөвлөгөөний хураангуй (сая ам.доллар)

Эх үүсвэр	Үе шат (ҮШСХ ирүүлэх жил)				Нийт эзлэх хувь (%)
	1 (2021)	2 (2024)	3 (2026)	Дүн	
А. Хөрөнгө оруулалтын төслийн бүрэлдэхүүн хэсэг					
Азийн Хөгжлийн Банк					
(i) Ердийн хөрөнгийн эх үүсвэр (ердийн зээл)	45.0	50.0	40.0	135.0	18.4
(ii) Ердийн хөрөнгийн эх үүсвэр (хөнгөлөлттэй зээл)	45.0	52.2	37.8	135.0	18.4
(iii) Тусгай сангийн эх үүсвэр (АХС - буцалтгүй тусламж)	3.0	0.0	0.0	3.0	0.4
2. Уур амьсгалын ногоон сан (зээл) ^a	11.8	18.4	12.2	42.4	5.8
3. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж) ^a	22.0	10.8	7.2	40.0	5.4

⁴³ Европын холбооны Азийн хөрөнгө оруулалтын байгууламжийн буцалтгүй тусламжийг Европын хөрөнгө оруулалтын банк хариуцдаг.

⁴⁴ Толгой байгууллагатай байх механизм гэж ихэвчлэн хөгжлийн түнш байгууллагын санхүүжилттэй С33-ийн санхүүгийн зуучлагчдын хоёр дахь давхаргад дамжуулдаг санхүүгийн байгууллагуудтай байхыг хэлэх бөгөөд хоёр дахь шатлалын санхүүгийн зуучлагчид нь эргээд тухайн зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдэгчдэд олгоно.

Эх үүсвэр	Үе шат (ҮШСХ ирүүлэх жил)				Нийт эзлэх хувь (%)
	1 (2021)	2 (2024)	3 (2026)	Дүн	
4. Европын хөрөнгө оруулалтын банк (зээл) ^б	52.9	59.4	37.7	150.0	20.4
5. Европын хөрөнгө оруулалтын банк (буцалтгүй тусламж) ^б	10.5	11.4	8.1	30.0	4.1
6. Монгол Улсын Засгийн газар	20.7	33.5	21.1	75.3	10.2
7. Ашиг шим хүртэгчид	3.4	2.0	1.3	6.7	0.9
Дэд нийлбэр (А)	214.3	237.7	165.4	617.4	84.0
В. Санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүн хэсэг					
1. Уур амьсгалын ногоон сан (зээл) ^а	38.4	29.6	19.6	87.6	11.9
2. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж) ^а	3.0	1.2	0.8	5.0	0.7
3. МУХБ/Арилжааны банкууд/Хувийн хэвшил	14.3	7.5	3.2	25.0	3.4
Дэд нийлбэр (В)	55.7	38.3	23.6	117.6	16.0
Нийт (А + В)	270.0	276.0	189.0	735.0	100.0


АХС = Азийн хөгжлийн сан, МУХБ = Монгол Улсын Хөгжлийн банк, ҮШСХ = үечилсэн санхүүжилтийн хүсэлт.

^а Азийн хөгжлийн банкнаас удирдан хэрэгжүүлнэ.

^б Зэрэгцээ хамтарсан санхүүжилт, Азийн Хөгжлийн Банкнаас удирдан хэрэгжүүлэхгүй.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банкны тооцоо.

25. ҮШСХ-ийн хүрээнд АХБ болон АХБ-ны удирдан хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийн 114.2 сая ам.долларыг уур амьсгалын нөлөөллийг бууруулах, 113.8 сая ам.долларыг уур амьсгалын дасан зохицоход тус тус зарцуулахаар тооцсон. Цогц хөтөлбөрийн уур амьсгалын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан АХС-гийн 13 сэдэвчилсэн эх үүсвэрээс чадавхыг бэхжүүлэх, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, хууль эрх зүйн болон институцийн тогтолцоог сайжруулах, эмзэг бүлгийн хүн ам болон экосистемд чиглэсэн даван туулах чадварыг сайжруулах, ногоон хөдөө аж ахуйн загвар буюу экосистемд суурилсан шинэлэг шийдлүүд гаргахад нэмэлт буцалтгүй тусламж үзүүлнэ (зүүлт 38).



ХУВААРЬ 2

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХҮРЭЭ

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нөлөөлөл нь Хүний хөгжил, амьдралын чанар, ногоон хөгжил, бүс нутгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангахтай уялдана ("Алсын хараа-2050" Монгол Улсын үрт хугацааны хөгжлийн бодлого) ^a			
Үр дүнгийн гинжин хэлхээ	Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд	Мэдээллийн эх үүсвэр ба тайлагнах механизм	Эрсдэл ба чухал таамаглал
Үр дүн Ногоон, хүртээмжтэй, хөдөө аж ахуйн хөгжлийг сайжруулах	2033 он гэхэд a. Хөрсний нүүрстөрөгчийн шингээлт, метаны хий, азотын исэл, нүүрстөрөгчийн ялгарлын бууралтын үр дүнд жилд 3.2 сая тонн нүүрстөрөгчийн давхар исэлтэй тэнцэх ялгарлаас зайлсхийх (2020 оны суурь үзүүлэлт: 0) (OP 3.1) b. 28.8 сая га бэлчээр сайжирч, илүү тогтвортой менежменттэй болсон байх (2020 оны суурь үзүүлэлт: 0) (OP 3.3.3) c. 550,000 иргэдийн уур амьсгал, гамшгийн тэсвэртэй байдал сайжирсан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0) (OP 3.2, 3.3, 4.1) d. БНХХААБС-ийн хүрээнд 500 ЖДҮ буюу хоршоод, 1000 бичил үйлдвэрүүд бизнес эрхэлдэг болох (2020 оны суурь үзүүлэлт: 0) (OP 1.2, 2.1, 5.2.3) e. 11,400 шууд ногоон ажлын байр бий болгох, үүний 40%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлэх (2020 оны суурь үзүүлэлт: 0) (OP 1.2, 2.1) f. Зорилтот бүсэд байгаа малын тоо толгой жилд 2.5%-иар буурсан байна (2020 оны суурь үзүүлэлт: жилийн 2.5%) g. Зорилтот аймаг, сумын төвүүдийн бохир ус цэвэрлэх үр ашиг 90% болж сайжирсан байна (2020 оны суурь түвшин: зорилтот аймгийн төвүүдэд 50% ба зорилтот сумын төвүүдэд 0%) (OP 4.3)	a – b. Хөндлөнгийн баталгаажуулсан ГЗБГЗЗГ ба Цаг уур, орчны шинжилгээний газрын ХТБ-ын тайлан, ХХААХҮЯ-ны мал аж ахуй болон газар ашиглалтын жилийн тайлан в. ГЗБГЗЗГ-ын орон нутгийн ажилтан ба сумын засаг захиргааны тайлан d – e. Ашиг хүртэгч аж ахуйн нэгж эсвэл шаардлага хангасан арилжааны банкнаас авсан аудит хийгдсэн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мөн СЗХ-ны хяналтын тайлан f. Үндэсний статистикийн хорооны мал аж ахуйн жилийн статистик g. Аймгийн ус, бохир усны үйлчилгээ үзүүлдэг компаниуд бохир усны урсац дахь хүчилтөрөгчийн биологийн хэрэгцээт зайлуулалтын хэмжилтийг Монгол Улсын стандарт MNS 4943: 2011-ийн дагуу хийх	Э: Засгийн газрын тэргүүлэх чиглэлүүд өөрчлөгдсөнө өр аймгийн хөгжлийг дэмжих хөрөнгө нөөц багасах Т: ЕХОБ-ны орц ба гарцыг цаг тухайд нь хэрэгжүүлэх
Бүрэлдэхүүн хэсэг 1. Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай, татах хүч сайтай аймаг болон сум	2032 он гэхэд 1a. Хотын 35 км зам барьж, 215.9 км туслах замыг сайжруулах; ус хангах хүртэл хүчин чадал цагт 3000 кубээр нэмэгдсэн байх; 25 км усан хангамжийн хоолой тавьсан байх; 35 км бохирын шугам татах; 16 км төвлөрсөн дулаан хангамжийн хоолой тавьсан байх; 135 км цахилгаан шугам барьсан байх; 20 км ус зайлуулах хоолой барьсан байх; 173.5 км оптик кабель тавьсан байх; 10.2 мегаваттыг нарны	1a – 1. Монголын улсын мэргэжлийн хяналтын тайлан, аймаг болон сумын хот байгуулалтын талаарх засаг захиргааны тайлан	Т: Төслийн гол оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа

шалгаруулж томилно.¹ ТХН-ийн бусад гол албан тушаалд ажиллах хот байгуулалтын мэргэжилтэн, ахлах инженер, бэлчээрийн менежментийн мэргэжилтэн, хоршооны мэргэжилтэн зэрэг мэргэжилтнүүдийг ГБ болон хэрэгжүүлэгч байгууллагууд АХБ-ны худалдан авах ажиллагааны бодлогыг баримтлан, өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, ажиллуулна (АХБ хянаж, зөвшөөрөл олгоно). ТХН-ийн бусад ажилтныг гүйцэтгэгч байгууллага эсвэл хэрэгжүүлэх байгууллагууд нь өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргаар шалгаруулан томилж, АХБ батламжилна.

6. БАХНХ олон жилийн туршлагатай, ШХА-тай удаан хугацаанд хамтран ажилласан, ялангуяа баруун аймгуудад БАГ байгуулах, малчдын бүлгийг зохион байгуулахад хүлээх үүрэг, сүлжээ зэргийг харгалзан үзэхэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, ТХН-ийн ажилтнуудыг бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Энэ нь төсөл 1-д 796 хүн олон сарын хугацаатай үүрэг хүлээн ажиллах боломжтой гэдгийг харуулж байна. ХХААХҮЯ, БХБЯ, БАХНХ нь харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, БАХНХ-ны хөтөлбөрт оролцох оролцоог тодорхойлно. Эцэст нь тэмдэглэхэд бүрэлдэхүүн хэсэг 1 ба 4-ийн хүрээнд шаардлагатай зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах ажлыг БХБЯ, бүрэлдэхүүн хэсэг 2-ын зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах ажлыг ХХААХҮЯ, бүрэлдэхүүн хэсэг 3-ын зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах ажлыг МУХБ-ХУК ахалж ажиллана. Хоршоод болон БАХ-г байгуулж, үйл ажиллагааг нь явуулахад барилгын ажил, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх бөгөөд үүнийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан болно. Энэхүү ажилд ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ), үйл ажиллагааны зардал, эргэлтийн хөрөнгө болон сүргийн тоог цөөлөх урамшуулал зэрэг нийт 4.9 сая ам.доллартой тэнцэх хөрөнгө оруулалт мөн хамрах юм. Сум, аймгийн бэлчээр ашиглагч байгууллагуудын үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардал 720,000 ам.доллароор хэмжигдэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ХХГА-ын Хавсралт 1-ээс харна уу.²


7. Мах, ноос, ноолуур, арьс ширний холбогдох холбоод, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, малчдын байгууллагууд, хөдөө аж ахуйн салбарын бүхий л мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл болон хоршоодын төлөөллийг оролцуулсан ХАА-н бизнесийн зөвлөл байгуулах ба тус зөвлөл ТХН-ид эдийн засаг, өртгийн сүлжээний хөгжлийн чиглэлээр удирдамж өгч, дэмжлэг үзүүлж ажиллана.

В. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хяналт

8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд АХБ-ын хяналтын баг орон нутагт тогтмол ажиллаж, төслийн гүйцэтгэлийг хянаж ажиллана. АХБ болон ЭЗХЯ нь (i) хөтөлбөрийн гүйцэтгэлийн менежментийн систем (ХГМС)-ээр макро болон микро асуудлын аль алины шалгуур үзүүлэлтүүд болон зорилтот түвшнийг ашиглан төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх ба (ii) төслийн хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй институцийн, захиргааны, техникийн болон бусад холбогдох асуудлуудыг хянаж үзнэ. Ингэхдээ төслийн хэрэгжилтийн үйл явц болон хуулийн гэрээнд тусгагдсан заалтуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгана. БХБЯ, ХХААХҮЯ болон МУХБ нь төслийн хэрэгжилтэд ерөнхий хяналт тавих ЭЗХЯ-нд тайлагнана.

¹ Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 тоот тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх тухай журам"

² Хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага (Ерөнхийлөгчийн тайлан, зөвлөмжийн 2-р Хавсралт дах холбоос бүхий баримт бичгийн жагсаалтаас үзэх боломжтой).



С. Хяналт-шинжилгээ

9. **Хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ.** ХГМС-ийн индикатор үзүүлэлтүүд, шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн хөтөлбөрт холбогдох байдал болон хяналт-шинжилгээний практик ажиллагааг хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд гүйцэтгэгч ба хэрэгжүүлэгч байгууллагууд, хөтөлбөрийн үр шимийг хүртэгчид авч хэлэлцэнэ. Хөтөлбөрийг боловсруулах үе шатанд цуглуулсан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг, үр дагавартай холбоотой суурь түвшний задаргаа бүхий өгөгдлийг шинэчилж, ТХН ба ХБ-ХУК-аас бэлтгэх улирлын ба жилийн явцын тайлан болон АХБ-ны хяналтын баг ажилласны дараа тухай бүрд тайланд тус тус тусгана. АХБ-ны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлагналын системийн мэдээллийг шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг жилийн тайлангуудад тусгана. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхэд ТХН болон ХБ-ХУК нь хөтөлбөрийн зөвлөх компанитай хамтран хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн орц ба гарц, хөтөлбөрийн үр нөлөө болон үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн талаар системтэй мэдээлэл бэлтгэх нэгдсэн ХГМС-ийн журмыг боловсруулна. ТХН болон ХБ-ХУК нь хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ ба тайлагналыг хариуцаж ажиллана. Хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээ болон УАНС-ийн санхүүжилт хүсэх саналын логик хүрээ буюу хөтөлбөрийн үр нөлөө, үр дүн, үр дагаврын гүйцэтгэлийн зорилтот түвшнийг тодорхойлсон логик хүрээ нь хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний суурь болно. ТХН болон ХБ-ХУК нь хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээ болон УАНС-ийн санхүүжилт хүсэх саналын логик хүрээнд тодорхойлсон эх сурвалжаас мэдээлэл цуглуулан, хөтөлбөрийн гүйцэтгэлийн талаар жил бүр тайлагнана. АХБ болон Засгийн газрын хооронд байгуулах гэрээнд тайлагналын тодорхой шаардлагуудыг тусгана. БХБЯ болон ХБ-ХУК нь мэдээлэл цуглуулах, шалгуур үзүүлэлтийг тооцох, үр дүнд дүн шинжилгээ хийх, хөтөлбөр зорилтот үр дүн, үр дагавар болон ерөнхий үр нөлөөнд хэр хэмжээнд хүрч байгаа талаар товч тайлан бэлтгэх ажлыг гүйцэтгэнэ. Үүний зэрэгцээ хөтөлбөрийн байгаль орчны үр нөлөөг хэмжихэд нийгэм-эдийн засаг ба байгаль орчны харилцан тохиролцсон шалгуур үзүүлэлтүүдийг ашиглана. ТХН болон ХБ-ХУК нь: (i) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх үед ХГМС-ийн хүрээг нарийвчлан нэгтгэх; (ii) зорилтот түвшнүүдэд хүрэх боломжтой эсэхийг баталгаажуулах; (iii) бүртгэл, хяналт-шинжилгээ, тайлагналын зохион байгуулалтыг хийх; (iv) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 6 сарын дотор системүүд болон журмуудыг үйл ажиллагаанд оруулах үүрэг хүлээнэ.

10. **Нийцлийн хяналт-шинжилгээ.** Зээл болон хөтөлбөрийн гэрээний заалтуудыг хэрхэн дагаж мөрдөж байгаа тухай хагас жил тутмын тайланд тайлагнаж, үнэлгээ хийх ба АХБ-ны хяналтын баг ажиллах үеэр баталгаажуулна.

11. **Хамгааллын хяналт-шинжилгээ.** Засгийн газар, БХБЯ болон ХБ эсвэл ХБ-ны ХУК нь хамгааллын тухай Монгол Улсын хууль, тогтоомж болон АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг (2009)-ийг дагаж мөрдүүлэх асуудлыг хангаж ажиллана. БХБЯ нь төслийн хүрээнд хийгдэх бүх ажил, үйлчилгээний гэрээнд хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх заалт болон төсвийг тусгуулж ажиллана.

12. **Албадан нүүлгэн шилжүүлэлт.** Засгийн газар нь БХБЯ-аар дамжуулан: (i) нийгмийн хамгааллын мэргэшсэн, туршлагатай, хөндлөнгийн экспертүүдийг АХБ-нд хүлээн зөвшөөрөгдөх ажлын даалгавар болон сонгон шалгаруулалтын үйл явцаар сонгон шалгаруулан ажиллуулж, нийгмийн хамгааллын хяналт-шинжилгээний үйл явцад гарсан мэдээллийг баталгаажуулах ба аливаа баталгаажуулах үйл ажиллагааг тэдгээр хөндлөнгийн экспертүүдээр гүйцэтгүүлэх; (ii) албадан нүүлгэн шилжүүлэлтийн хамгааллын бодлого, үүнд иргэдийг сайн дурын үндсэн дээр оролцуулах төлөвлөгөө болон СЗЗ-ийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд БОНУС-ийн хэрэгжилт болон тэдгээрийг хэрхэн дагаж мөрдөж

Гарын үсэг /Signature/ м

2020 оны 12 сарын 05 өдөр
/Дарьбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION


байгаа тухай хамгааллын хяналт-шинжилгээний тайланг хагас жил тутамд АХБ-нд явуулах; (iii) тэдгээр тайлангийн холбогдох мэдээллийг сөрөг нөлөөлөлд өртөж буй тухайн хүмүүст өгнө. Хөндлөнгийн экспертүүд нь нүүлгэн шилжүүлэлт болон сайн дурын оролцооны бүх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй үед хагас жилийн хяналт-шинжилгээний тайлангууд, мөн уг үйл ажиллагаа хэрэгжиж дууссанаас хойш 6 сарын дотор гүйцэтгэлийн тайланг тус тус бэлтгэж, БХБЯ болон АХБ-нд илгээнэ.

13. **Хүрээлэн буй орчин ба нийгмийн удирдлагын систем.** Засгийн газар нь ХБ эсвэл ХБ-ны ХУК-иар дамжуулан шаардлага хангасан арилжааны банк тус бүр хагас жил тутмын БОНУС-ийн хяналт-шинжилгээний тайланг бэлтгэж, ХБ-ХУК-д хүргүүлэх, ингэхдээ ХБ-ХУК нь тэдгээр банкны тайланг нэгтгэн, цааш АХБ руу илгээх цаг хугацаанд нь хүргүүлж байх шаардлага тавина.

14. **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.** Барилгын ажлын явцад гэрээт ажил гүйцэтгэгчид нь тухайн дэд төслийн шинэчлэгдсэн БОМТ-нд үндэслэн гэрээт ажил гүйцэтгэгчийн байгаль орчны менежмент болон дотоод хяналт-шинжилгээний систем бүхий БОМТ-г боловсруулан, өөрийгөө хянах үйл ажиллагааг хэрэгжүүлж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын байцаагч болон сумын мэргэжлийн хяналтын байцаагчтай нягт хамтран ажиллана. Гэрээт ажил гүйцэтгэгчид нь гэрээт ажил гүйцэтгэгчийн БОМТ-ний хэрэгжилтийн сар бүрийн тайланг бэлтгэж, ТХН-д илгээнэ. Барилгын ажлын үе шат болон ашиглалтын үе шатанд дэд төслийн БОМТ-ний хэрэгжилтийн өдөр тутмын уялдаа болон баталгаажуулалтыг ТХН нь байгаль орчны зөвлөхүүдийн туслалцаатайгаар гүйцэтгэнэ. ТХН нь байгаль орчны нөлөөллийн хяналт-шинжилгээг тогтмол хугацаанд эрх бүхий байгууллага, зөвлөхүүдээр гүйцэтгүүлнэ. Дэд төслүүдийн БОМТ-ийн хэрэгжилт болон байгаль орчны нөлөөллийн хяналт-шинжилгээний үр дүнг төслийн жилийн БОМТ-ний хяналт-шинжилгээний болон явцын тайлангаар АХБ-нд мэдээлэх ба төслийн хэрэгжилтийн улирал тутмын тайланд хураангуйлан тусгаж байна.³ Төслийн жилийн БОМТ-ний хяналт-шинжилгээний болон явцын тайланг АХБ-ны вэбсайтад олон нийтэд нээлттэй тавина.

15. **Жендер ба нийгмийн арга хэмжээний хяналт-шинжилгээ.** Нийгэм ба жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НЖҮАТ)-ний хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийг ХГМС-д давтан оруулсан. Зорилтот түвшин ба шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой зааж өгсөн бөгөөд хөдөлмөр эрхлэлт г.м. зарим шалгуур үзүүлэлтийг зорилго, зорилтын хүрээнд мөн тусгасан. АХБ-нд тогтмол илгээх төслийн явцын хагас жил тутмын тайланд тэдгээр шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнана. Нийгмийн хөгжил ба жендерийн зөвлөхүүд нь ТХН болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжид хяналт-шинжилгээний үр дүнтэй системийг бий болгоход туслан, ТХН-ийн НЖҮАТ-ний хэрэгжилтийг хангах гол мэргэжилтнүүдэд дэмжлэг үзүүлж ажиллана. НЖҮАТ-ний хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт-шинжилгээ хийж, төслийн хэрэгжилтийн улирал тутмын тайланд тайлагнах бөгөөд АХБ-ны хяналтын баг ажиллах үеэр мөн хяналт-шинжилгээ хийгдэнэ. Мөн хөндлөнгийн хяналтын байгууллага НЖҮАТ-ний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хөндлөнгийн хяналтын хагас жил тутмын тайланг бэлтгэж тайлагнана.

³ Дорвитой ахиц, хэрэгжилтийн асуудал эсвэл өмнө нь тодорхойлсон бэрхшээлтэй асуудлын нөхцөл байдал ямар байгааг хэзээ, хэрхэн тайлагнах шаардлагатай тухай.



ХУВААРЬ 4

ТӨСЛҮҮДИЙГ СОНГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БА БАТЛАХ ҮЙЛ ЯВЦ


Төслийг бэлтгэх ба батлуулах ерөнхий үйл явц

1. Хөтөлбөрийг бэлтгэх явцад төсөл 1-ийн холбогдох техник-эдийн засгийн бүх судалгаа болон хамгааллын бодлогын баримт бичгийг бэлтгэх бөгөөд дагалдах төслүүдийн агуулгыг урьдчилан тодорхойлсон байх ба төсөл 1-тэй төстэй агуулгатай байна.

2. Дагалдах төслүүдийг бэлтгэх ажил тус санхүүжилтийн ерөнхий гэрээний хавсралт 1-т заасан хүрээнд хийгдэх ба зорилтот аймгуудын уур амьсгалын өөрчлөлтийн үндэслэл болон арилжаа, эдийн засаг, санхүү, хууль эрх зүй, зохицуулалт, нийгмийн арга хэмжээ ба техникийн магадлан шинжилгээг гүйцэтгэж, авлигын эсрэг асуудлууд, чадавх, итгэмжлэгдсэн этгээдийн хяналт, засаглал, хэрэгжилт, худалдан авалт, хамгаалал, нийгмийн эрсдэл, тогтвортой байдал ба бусад асуудлыг зохицуулна. АХБ нь магадлан шинжилгээний тусламжтайгаар тухайн хөрөнгө оруулалт нь санхүүжилт хийхэд бэлэн болсон эсэх, хөрөнгө оруулалтыг тохиромжтой байдлаар боловсруулсан мөн АХБ-ны холбогдох бодлого болон харилцан тохиролцсон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хэрэгжүүлэх боломжтой эсэх, түүнчлэн аль нэг үе шатны газар зүйн хамрах хүрээнд санал болгож буй аймаг тус бүрийг хамруулах асуудлыг УАНС-аар батлуулахад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээний уур амьсгалын өөрчлөлтийн үндэслэл болох эсэхийг тодорхойлоход тус болно. Бэлтгэл ажил нь хэрэгжилтийн бэлэн байдал болоод сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт, мөн доор дурдсан УАНС-ийн зээл ба буцалтгүй тусламжийн санхүүжилтийн шийдвэр гаргахад шаардагдах нийцлийн шийдвэр гаргах явцыг мэдээллээр хангаж өгнө.

3. Бэлэн байдлын шалгуур үзүүлэлт:

- (i) Санал болгож буй үе шат нь АХБ-ны дотоод хамгаалал ба магадлан шинжилгээний хяналт хийж, дэмжигдсэн.
- (ii) Өмнө нь батлагдаж, хэрэгжиж байгаа үе шат нь хангалттай түвшинд хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрийн замын зургийн дагуу, үүнд хөтөлбөртэй холбогдох заалтууд болон үе шат тус бүрийн хувьд АХБ-ны зээл ба буцалтгүй тусламжийн гэрээний нөхцөлүүдийн дагуу хэрэгжиж байгаа.
- (iii) Засгийн газар ба Байгаль орчин, аялал жуулчлалын яам (УАНС-аас нэрлэсэн үндэсний байгууллага)-аас холбогдох үе шатыг хэрэгжүүлэхэд үүрэг хүлээх, хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.
- (iv) Тухайн үе шатыг хэрэгжүүлэх аймгуудын уур амьсгалын хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлийн нотолгоо баримт.
- (v) Уур амьсгалын өөрчлөлтийн хувьд тухайн үе шатлалаас гарах үр өгөөж (УАӨҮӨ) дасан зохицохтой холбоотой үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө оруулалтын 10-аас дээш хувьтай тэнцүү байх (шигтгээ).
- (vi) Тухайн үе шат нь хандивлагчийн зохицуулалтыг дэмжих.
- (vii) Тухайн үе шат нь усны эх үүсвэрийг хэмнэхэд гарах шууд нөлөөллийг харуулах.



Шигтгээ: Уур амьсгалын өөрчлөлтийн үр өгөөж

Уур амьсгалын өөрчлөлтийн үр өгөөж (УАӨҮӨ)-ийн индикатор үзүүлэлт нь уур амьсгалын өөрчлөлтийн үнэ цэнийг мөнгөөр илэрхийлэх нэг илэрхийлэл. Энэ нь хөтөлбөрийн үр дүнд уур амьсгалын өөрчлөлтийн хувьд бий болох үр өгөөжийг мөнгөн дүнгээр тооцсон тооцоолол бөгөөд жилийн УАӨҮӨ-ийг хөрөнгө оруулалтын үнийн дүнтэй холбодог. Хөтөлбөрт хамруулах эсэхийг харгалзан үзэхэд тавигдах шаардлага (доорх тооцооллыг харах) нь хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцүү байна. Энэ шаардлагаар УАӨҮӨ нь дангаараа капиталын хөрөнгө оруулалтыг (хамгийн ихдээ) 10 жилийн хугацаанд нөхөх боломжтой гэсэн үг юм. Түүнчлэн дараах нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тохиолдолд Уур амьсгалын ногоон сангийн хамтарсан санхүүжилтийг эхний ээлжид авах хөрөнгө оруулалтыг сонгохдоо капиталын хөрөнгө оруулалтдаа хамгийн өндөр УАӨҮӨ-тэй хөрөнгө оруулалтыг сонгоно.

УАӨҮӨ-ийн мөнгөн дүнг дараах 3 нөхцөлийн нийлбэрээр тооцно. Үүнд:

1. [Нүүрсхүчлийн давхар ислийн (CO₂) жилийн дундаж ялгарал (нийт хугацааны дунджаар)] x дансны үнэ of CO₂-ийн ... үнэ]^a
2. [Жилд нийт хэмнэсэн эсвэл хадгалсан усны хэмжээ (нийт хугацааны дунджаар)] x [усны дансны үнэ]^b
3. [Δ жилд дунджаар өссөн / хонин толгой] x [малын тоо хонин толгойгоор]^c

Эхний нөхцөл нь хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг хэдий чинээ бууруулж чадсан тэр хэмжээг шууд тооцох тооцоолол. Хоёрдох нөхцөл нь Монгол орны хувьд усны хомсдолтой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас усны хүртээмжид сөрөг нөлөөлөл үүсэж байгаа учир хэмнэсэн эсвэл хадгалсан усны хэмжээг тооцох тооцоолол. Гуравдах нөхцөл нь малаас авах ашиг шимийг нэмэгдүүлснээр малын тоог бууруулах хэрэгцээг хэрхэн нөхөх, малын тоог бууруулснаар бэлчээрийн биомассын бууралтыг хэрхэн нөхөх талаарх тооцоолол.

^a Хөтөлбөрт Азийн хөгжлийн банк (ADB)-нд ашигладаг CO₂-ийн дансны үнэ буюу \$36.30/тн нүүрсхүчлийн давхар ислийн эквивалент (тCO₂экв)-ийг ашиглах ба бодит нөхцөлд жил бүр 2% өсөж явна. Үүнтэй харьцуулахад Дэлхийн банканд ашигладаг CO₂-ийн дансны үнэ 2020 онд \$40.00/тCO₂экв байсан ба жилд 2.25%-иар өсдөг. Хөтөлбөр нь үүнийг хялбаршуулан CO₂-ийн дансны үнийн тогтмол утга буюу АХБ-наас 2020 онд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан хэмжээг тогтооход ашигласан утгад үнэлгээ хийж тооцоолсон утга (\$39.62/тCO₂экв)-ыг ашиглана.

^b Усны дансны үнийн хувьд хөтөлбөр нь хэмнэсэн эсвэл хадгалсан усны куб метрийн тогтсон үнэ буюу \$0.55 үнийг ашиглана.

^c Гуравдах нөхцөлийг тооцохдоо нэгж малд ногдох нэмэгдсэн өртгийн сүүлийн 5 жилийн дунджаар (мэдээлэл нь бэлэн байгаа) тооцсон утга болон малын тоог бууруулах болон нэгж малд ногдох нэмэгдсэн өртгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч эхэлснээс хойших 5 жилийн нэгж малд ногдох нэмэгдсэн өртгийн дундаж утгын зөрүүгээр гаргана. Хоёрдох нөхцөл нь арга хэмжээ авч хэрэгжүүлснээс хойш 5 жилийн дараах малын тоо дунджаар (хонин толгойгоор).

Эх сурвалж: АХБ.

4. **Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт.** Хөрөнгө оруулалт тус бүрийг дараах шалгуур үзүүлэлт болон батлах үйл явцын дагуу сонгож, батална. Үүнд:

- (i) Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодорхойлсон хөдөө аж ахуйн логистик, ханган нийлүүлэлтийн төв болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн загвар, сонгосон байршилтай уялдсан байхад
- (ii) Техник-эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой байх ба техник-эдийн засгийн үндэслэлийн нарийвчилсан тайлантай байх;
- (iii) Эдийн засгийн хувьд боломжтой, санхүүжилтийн хувьд тогтвортой байх;
- (iv) Байгаль орчин, нийгмийн үндэслэл сайтай бөгөөд байгаль орчин, нийгмийн хувьд гарч болох аливаа нөлөөллийг хамгааллын хүрээ (хавсралт 5) ба АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичгийн (2009) дагуу бууруулах арга хэмжээг тусгасан байх. Хөрөнгө оруулалт тус бүрээр ядуурал ба нийгмийн


Signature

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

- дүн шинжилгээг АХБ-ны ядуурал ба нийгмийн үнэлгээний зааврын дагуу гүйцэтгэсэн байх;
- (v) Хөрөнгө оруулалтыг хэрэгжилтийн ерөнхий хуваарийн дагуу цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтрагч талаас хангалттай хэмжээний санхүүжилт хуваарилах; мөн
- (vi) Эрчим хүч болон халаалтын нүүрсэнд суурилсан шинэ эх үүсвэрийг санхүүжүүлэхгүй.

5. Үүнээс гадна сонголтын тусгайлсан шалгуур үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалтын нарийвчилсан шаардлага, бүрэлдэхүүн хэсэг 2-ын санхүүжилтийн чиглэлээр УАНС-ийн шийдвэр гаргалтад холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг хавсралт 1-д хавсаргав. Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд УАНС нь зөвхөн нарны цэнэг хураагч хавтан зэрэг сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ.



ХУВААРЬ 5

ЯДУУРАЛ, НИЙГМИЙН АСУУДАЛ БА ХАМГААЛЛЫН ШААРДЛАГА


1. Монгол Улс нь энэхүү Хуваарьд тусгасан шаардлага болоод доор тусгасан байгаль орчин ба нийгмийн хамгааллын хүрээ болон төлөвлөгөөг тус сан болон эхний үе шаттай уялдаатай боловсруулж ажиллахыг хангах ба АХБ-наас хуулбарыг бүрэн эхээр хүргүүлсний дээр энэхүү баримт бичигт дурдах байдлаар бүрэн тусгагдсан гэж үзэх дараах тус санд хамрагдах төслүүдийг боловсруулах болоод хэрэгжүүлэх явцад дагаж мөрдүүлнэ, үүнд.

- (i) _____-ны өдрийн байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ;
- (ii) _____-ны өдрийн нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ;
- (iii) _____-ны өдрийн уугуул иргэдийн төлөвлөлтийн хүрээ;
- (iv) _____-ны өдрийн эхний үе шатын байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө;
- (v) байгаль орчин, нийгмийн менежментийн систем; болон
- (vi) _____ оны нийгэм, жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө.

2. Эдгээр баримт бичгүүд нь АХБ-ны хамгааллын бодлогод заасанчлан хөтөлбөртэй холбоотой мэдээлэл, шаардлагыг агуулсан болно. Үүнд: (i) ҮШСХ-ийн хүрээнд санхүүжүүлэх магадлалтай бүрэлдэхүүн хэсэг эсхүл төслийн байгаль орчин, албадан нүүлгэн шилжүүлэлт болон уугуул иргэдэд үзүүлэхүйц ерөнхий нөлөөлөл; (ii) төслийг сонгоход ашиглах шаардлагатай хамгааллын шалгуур; (iii) үнэлгээ ба ангилал, нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний боловсруулалт, олон нийттэй зөвшилцөх ба мэдээлэл ил болгох (үүнд 120 өдөр ил тавих дүрэм шаардлагатай бол хамаарна), мониторинг ба тайлагналын хүрээнд дагаж мөрдөх шаардлага, процедур; мөн (iv) хамгааллын баримт бичгүүдийг бэлтгэх, хянах болон батлахтай холбоотой институцийн зохицуулалт (төсөв ба чадавхын шаардлагын хамт), зээлдэгч болон АХБ-ны хүлээх үүрэг хамаарна.


3. Тус улсын хууль тогтоомж болон АХБ-ны шинэчилсэн хамгааллын бодлоготой нийцүүлж, ач холбогдолтой байлгах үүднээс тухайн ҮШСХ-ийг бэлтгэхийн өмнө байгаль орчны үнэлгээ, албадан нүүлгэн шилжүүлэлт болон уугуул иргэдийн хамгааллын хүрээ бүрийн хамаарал, ач холбогдлыг үнэлж, шинэчилнэ.

4. Зээлдэгч нь ямар ч тохиолдолд ҮШСХ-ийг тухай бүр шинээр бэлтгэхдээ хэрэгжиж буй төслүүдийг байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөгөө болон хүрээний хувьд дагаж мөрдөж буй статусаар үнэлж, үнэлгээний тайланг хүсэлт гаргаж буй үе шатанд хамаарах төсөлд хамааралтай бусад шаардлагатай хамгааллын баримт бичгийн хамт АХБ-инд хүргүүлнэ. Хэрэгжиж буй төслийн үнэлгээний явцад зөрчил илэрсэн ямар ч тохиолдолд засаж залруулах төлөвлөгөө боловсруулж, АХБ-инд ирүүлнэ.



НИЙГМИЙН, ЖЕНДЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
Бүрэлдэхүүн хэсэг 1: Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай, татах хүч сайтай аймаг болон сум төвүүдийг хөгжүүлэх				
1.1 Халаалт, усан хангамж болон ариун цэврийн экологид ээлтэй шийдлийг өрх толгойлсон эмэгтэйчүүдийг хамруулсан байдлаар гудамжийг дахин хөгжүүлэх туршилтаар нэвтрүүлэх	<p>1.1.1. Ус, ариун цэврийн болон халаалтын систем сайжруулах зорилтот туршилтын гудамжны оршин суугчдын 80% (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.1.2. Ус, ариун цэвэр болон халаалтын систем сайжирсан өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 80% (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.1.3. Зорилтот гудамжны хоёрдогч оршин суугчдын 100%, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд 100% орон сууцны түрээслэх/түрээслээд-өмчлөх өргөдөл гаргах давуу эрх олгох (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.1.4. Орон сууц худалдан авч буй айл өрхүүдийн 100% нь орон сууцны үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээнд нэрээ бүртгүүлэх эмэгтэйчүүдийн эрхийн талаар мэдээлэл өгсөн байна (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<ul style="list-style-type: none"> БХБЯ Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	<p>2024-2028</p> <p>2025: 0%</p> <p>2026: 20%</p> <p>2027: 50%</p> <p>2028: 100%</p> <p>2027: 100%</p> <ul style="list-style-type: none"> 2024-2028 оны мэдээллийн кампанит ажил 2028 онд үнэлэгдэх эмэгтэйчүүдийн өмчлөлийн зорилт 	Төслийн угсралт, ашиглалтын төсөв
1.2 Технологийн зохистой хэрэглээг хангаж, төслийн үр ашгийг оновчтой болгох зорилгоор байгаль орчинд ээлтэй технологийн талаар ММБ-ын аяны ажил хэрэгжүүлэх	<p>1.2.1 Бүх ашиг хүртэгч өрхүүдэд чиглэсэн ММБ-ын аян явуулах; ашиг шим хүртэгчдийн дор хаяж 35% нь ядуу өрхүүд^а. (2020 оны суурь үзүүлэлт: 0) ба 50% нь эмэгтэйчүүд (2020 оны суурь үзүүлэлт: 0) байх</p>	<ul style="list-style-type: none"> БХБЯ Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	2024-2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^с
1.3 Хот төлөвлөх ажилд ядуу өрх, үндэсний цөөнх болон эмэгтэйчүүдийн оролцоог хангах	<p>1.3.1. Туршилтын гудамж төлөвлөх чиглэлээр бүх нийтэд зориулсан зөвлөлдөх уулзалтад оролцогчдын 50%-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх, зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан дор хаяж 2 семинар, мөн/эсвэл фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.3.2. Шаардлагатай тохиолдолд казах, монгол, тува хэл дээр мэдээллийн материалыг бэлтгэж тараасан байх (2019 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<ul style="list-style-type: none"> БХБЯ Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	<p>2024-2028</p> <p>2025: 25%</p> <p>2026: 50%</p> <p>2027: 75%</p> <p>2028: 100%</p>	Төслийн угсралт, ашиглалтын төсөв, удирдлагын дэмжлэг ^с



Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
<p>1.4 Гудамжны хөгжлийн зөвлөл, олон нийтийн төлөвлөлт, удирдлагад ядуу өрх, үндэсний цөөнх, эмэгтэйчүүдийн оролцоог хангах</p>	<p>1.3.3 Өлгий дэх казах бус өрхийн 80%-ийг зөвлөлдөх уулзалтад хамруулах (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.3.4. Жендерийн мэдрэмжтэй нийтийн эзэмшлийн талбай, барилга байгууламж барьсан байна^a (2019 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.4.1. Гудамжны хөгжлийн зөвлөлийн дүрмийн талаар бүх өрхүүд, тэр дундаа ядуу өрхүүд болон үндэсний цөөнх (ялангуяа Өлгий дэх казах биш өрхүүд болон Ховд дахь казах өрхүүд)-ийн дор хаяж 65%-ийг оролцуулж хэлэлцүүлэг хийж, мэдээлэл солилцох (2019 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.4.2. Казах, монгол, тува хэл дээрх мэдээллийн хуудсыг бэлтгэж, шаардлагатай газарт байрлуулж, тараах (2019 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.4.3. Гудамжны хөгжлийн зөвлөлийг бүрдүүлж буй анхан шатны бүлгийн удирдагчдын дор хаяж 30% нь ядуу өрхийг төлөөлнө^a (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.4.4. Гудамжны хөгжлийн зөвлөлийн дарга, дэд даргын дор хаяж 50% нь эмэгтэйчүүд байх (2019 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.4.5. Гудамжны хөгжлийн зөвлөлийн бэлтгэгдсэн гишүүдийн дор хаяж 45% нь эмэгтэйчүүд байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>1.4.6. Гудамжны хөгжлийн зөвлөлүүд Өлгий хотын ядуу өрхүүдийн дор хаяж 80%, казах бус өрхүүдийн 80%-тай олон нийтийн төвийн төлөвлөлт, удирдлагын талаар зөвлөлддөг байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<p>БХБЯ</p> <ul style="list-style-type: none"> • Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	2023–2027	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c
<p>1.5 Нийгмийн бүх үйлчилгээний байгууламж, сайжруулж зассан байгууламж, УАЦЭА-н байгууламж зэрэг нь хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой онцлог хэрэгцээнд нийцсэн байх.</p>	<p>1.5.1. Бүх хэрэгжиж буй УАЦЭА-н байгууламжууд нь хүйс, бага насны хүүхэд, тусгай хэрэгцээтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн бөгөөд үүнд эрэгтэй, эмэгтэй тусдаа байгууламж, тэргэнцэрт тохирсон налуу зам бусад байгууламж, цэцэрлэгийн насны хүүхдэд тохирсон бие засах газар, угаалтуур зэрэг орно (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<ul style="list-style-type: none"> • Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд • Инженерийн компани ба/эсвэл архитектурын инженерүүд 	<ul style="list-style-type: none"> • 2024 он: нарийвчилсан ан зураг төслийг хийж гүйцэтгэх • 2028 он: барилгын ажил 100% дуусах 	Төслийн барилга угсралт, ашиглалтын төсөв, төслийн удирдлагын дэмжлэг ^c

2022 оны 12 сар 05 өдөр
Удирдлагын хөт

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
<p>• Бүрэлдэхүүн хэсэг 2: Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй бөгөөд тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх нь</p> <p>2.1 Ядуу болон/эсвэл эмзэг бүлгийн өрхүүдийг БАХ болон БАГ-нд хамруулж, тэдний бэлчээрийн эрхийг хамгаалах зорилгоор мэдээлэл, зөвлөгөө өгөх.</p>	<p>2.1.1. Зорилтот сумд (аймгийн доорх засаг захиргааны нэгж)-ын малчин өрхийн 100% БАХ-т гишүүнчлэлтэй хэвээр байх (2019 оны суурь үзүүлэлт: 100%)^е</p> <p>2.1.2. Бүх малчин өрх, ялангуяа ядуу малчин өрхийн бэлчээрийн эрхийг хамгаалах зорилгоор Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн БАХ-ийн 25% нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хүлээн зөвшөөрсөн шинэчилсэн БАГ-нд гарын үсэг зурсан байх (2019 оны суурь үзүүлэлт: 17.5 % БАХ)</p> <p>2.1.3. БАХ/БАГ/ХОХСМТ/ОНИХАО-ны талаарх арга барил, алхмуудын талаарх мэдээллийн хуудсыг шаардлагатай бол Монгол, казах, тува хэл дээр бэлтгэж, тараах (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<ul style="list-style-type: none"> ХХААХҮЯ ХХН Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд БАХ 	<ul style="list-style-type: none"> 2024 он мэдээллийн хуудас 2028 он гэхэд бусад зорилтууд 	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c
<p>2.2 БАХ-ийн хамрах газар нутаг бүрд өрх толгойлсон эмэгтэйчүүдийг тодорхойлж, БАХ, БАГ-ний ашиг тусын мэдээлэл өгөх, БАХ-ийн бүтэц дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, БАГ-нд бүх малчин өрхийн эхнэр, нөхөр хоёулаа гарын үсэг зурахыг баталгаажуулах.</p>	<p>2.2.1. Төслийн хүрээнд шинэчлэгдсэн ба/эсвэл гарын үсэг зурсан БАГ-ний 100%-д өрхийн хоёр эхнэр, нөхөр хоёр БАГ-ний хавсралт хэсэг дээр гарын үсэг зурсан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>2.2.2. БАХ-ийг бүтцийн удирдлагад эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээ дор хаяж 20% байх (2020 оны суурь үзүүлэлт: Ногоон алт төслийн хүрээнд бүртгэгдсэн БАХ-ийн 14.4%)^g</p>	<ul style="list-style-type: none"> ХХААХҮЯ ХХН Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд БАХ 	2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c
<p>2.3 ХОХСМТ-г боловсруулах талаар эмэгтэйчүүд, ядуу болон/эсвэл эмзэг бүлгийн өрхүүд, үндэсний цөөнхөд мэдээлж, зөвлөгөө өгөх.</p>	<p>2.3.1. ХОХСМТ-г боловсруулахад БАХ-ийн нийт өрхүүдийн 60%-тай зөвлөлдөхөөс ядуу өрхүүдийн 60%, үндэсний цөөнхийн 60% хамрагдсан байна (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>2.3.2. ХОХСМТ-г боловсронгуй болгохтой холбоотой мэдлэг олгох сургалт, семинарт оролцогчдын 40% нь эмэгтэйчүүд байна; эсвэл БАХ бүрд эмэгтэйчүүдэд зориулсан</p>	<ul style="list-style-type: none"> ХХААХҮЯ ХХН Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд БАХ 	2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c

Гарын үсэг /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хотMinistry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
2.4 ОНИХАО-гоор санхүүжүүлсэн нь төслүүд эмэгтэйчүүд, ядуу өрхүүдэд ашиг тусаа өгдөг байх	2.4.1. ОНИХАО-ны санхүүжилттэй төслүүдийн дор хаяж 60% нь ядуу өрхүүдэд үр өгөөжөө өгсөн байх ^а (2020 оны суурь үзүүлэлт: 2020 оны суурь үзүүлэлт: 0) 2.4.2. ОНИХАО-ны санхүүжилттэй төслүүдийн дор хаяж 50% нь эмэгтэйчүүдэд ашиг тусаа өгсөн байх ^а (2020 оны суурь үзүүлэлт: 0)	• ХХААХҮЯ • ХХН • Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд • БАХ	2024–2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c
2.5 Тогтвортой болоод БАХ-т суурилсан хоршоодод ядуу малчин эмэгтэйчүүдийг хамруулсан байх	2.5.1. Тогтвортой болоод БАХ-т суурилсан хоршоодод нийт БАХ-ийн зохион байгуулалтад орсон малчин өрхийн 70% хамрагдсан байна ^а (суурь үзүүлэлт: 0) 2.5.2. Хоршоодын жилийн ээлжит хурлын оролцогч нийт гишүүдийн дор хаяж 40% эмэгтэйчүүд байна ^а 2.5.3. 30 БАХ байсвэл малчдын бүлэгт суурилсан хоршоо байгуулагдсан (5 аймгаг/сум дундын төв; 3 аймгийн хоршооллын байгууллага, мөн 1 бүс нутгийн хоршооллын байгууллага) (2020 оны суурь үзүүлэлт: 0) байх ба хоршоодын дор хаяж 30% нь эмэгтэй удирдлагатай байна (2019 оны суурь үзүүлэлт: Ногоон алт төслийн хүрээнд бүртгүүлсэн хоршоодын 23%) ⁹	• ХХН • Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд	• 2024–2028 онд жилийн бүх гишүүдийн хуралд эмэгтэйчүүдийн оролцоог үнэлэх • 2024–2028 онд хоршоод дахь эмэгтэй удирдлагын эзлэх хувийг үнэлэх	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c
3.1 Санхүүгийн зуучлагч орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих загварт суурилсан байх	3.1.1. Хөтөлбөрийн гурван санхүүгийн зуучлагчдад зориулж байгаль орчин, нийгмийн менежментийн нэгдсэн системийг боловсруулж, баталсан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0) 3.1.2. Мал аж ахуйн салбарт оролцогч аж ахуйн нэгжүүд 100% ямар нэг хэлбэрээр тогтвортой малчдын байгууллагуудтай хамтын	• БХБЯ • Монгол Улсын банкны хөгжлийн хөрөнгийн удирдлагын компани	2024–2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c

Гарын үсэг /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
3.2 Зорилтот зээлийн санал ирүүлэхэд хувийн хэвшлийн жендэрийн шинжилгээг үнэлгээний явцад оруулсан байх	<p>3.2.1. Хувийн хэвшлийн саналыг үнэлэх, эрэмбэлэх шалгуурууд нь (i) эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг сайжруулах – эмэгтэй ажилчид авч ажиллуулах үйл ажиллагааны төлөвлөгөө; (ii) жендерийн мэдрэмжтэй биет байгууламж, үндэ эмэгтэй, эрэгтэй ажилчдын тусдаа ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө зэрэг орно; мөн (iii) жендерийн мэдрэмжтэй, жендерт ээлтэй ажлын орчин зэрэг бусад жендерийн болон нийгмийн ашиг тус (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>3.2.2. Боловсруулалтын өмнөх байгууламжид хөрөнгө оруулалт хийх ЖДҮ-ийн 40% нь эмэгтэй удирдлагатай байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<ul style="list-style-type: none"> МУХБ-ХУК ХХН Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	<p>2024</p> <p>2023–2027 онд эмэгтэй удирдлагатай ЖДҮ-ийн эзлэх хувийг үнэлэх</p>	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^c
3.3 Оролцогч аж ахуйн нэгжүүдийн бүхий л бодлого, үйл ажиллагаа нь үндэсний тогтоомж, Монгол Улсын жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай тэгш байдлыг хангах тухай хуультай нийцэж байх	<p>3.3.1. Үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг дагаж мөрдөх амлалтад гарын үсэг зурсан бөгөөд оролцогч аж ахуйн нэгжүүдийн саналд үүнийг тусгасан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>3.3.2. Оролцогч аж ахуйн нэгжүүдэд бэлгийн дарамт, жендерт суурилсан хүчирхийлэлгүй ажлын байрны талаар сургалт явуулсан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>3.3.3. Жендерийн асуудлаар оролцогч аж ахуйн нэгжүүдийн эсрэг шүүхэд ямар нэг нэхэмжлэл гараагүй байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<ul style="list-style-type: none"> МУХБ-ХУК Оролцогч аж ахуйн нэгжүүд Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	2024–2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^a
4.1 Жендерийн мэдрэмжтэй чадавч болон институцийг бэхжүүлэх	<p>4.1.1. 2021 он гэхэд хүйсээр ангилсан төслийн гүйцэтгэлийн менежментийн системийг бий болгосон байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>4.1.2. 2023 он гэхэд БНХААБС-ийн дэмжлэгтэй хийх хөрөнгө оруулалтын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, бизнесийн төлөвлөгөө, техникийн тодорхойлолтын</p>	<ul style="list-style-type: none"> АХБ Хэрэгжүүлэгч байгууллагууд ХХН ТХН 	2024–2028	Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар ^a

Гарын үсэг (Signature)
 2022 оны 12 сарын 05 өдөр
 Үлдсэн баатар хот
 Ministry of Finance of Mongolia
 OFFICIAL TRANSLATION

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд загвар, болон сургалтыг (сургагдсан хүмүүсийн 40% нь эмэгтэйчүүд байх) боловсруулсан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0) 4.1.3. ТХН ба ХХН-ийн ажилтнуудын дор хаяж 35% нь эмэгтэйчүүд байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)	Хариуцах байгууллага	Төсөв
<ul style="list-style-type: none"> Бүрэлдэхүүн хэсэг 1-3: Ажлын байр бий болгох 	<ul style="list-style-type: none"> 5.1.1. Барилгын үе шатанд ажлын байрны 20%-ийг эмэгтэйчүүдэд давуу эрхтэйгээр нээлттэй болгож, нийт ажлын байрны 20%-ийг эмэгтэйчүүдэд олгосон байх (2018 оны суурь үзүүлэлт: 17.2%) 5.1.2. Ажлын байрны 20%-ийг ядуу иргэдэд давуу эрхтэйгээр нээлттэй болгох (2020 оны суурь үзүүлэлт: 0) 5.1.3. ОНИХАО-ны хүрээнд санхүүжүүлж буй төслүүдийн 60% нь орон нутгийн ажиллах хүч ашиглах бөгөөд үүний 60% нь ядуу өрхүүд байх (2020 оны суурь үзүүлэлт: 0) 5.1.4. Гэрээлэгчид сурталчилгааны болон/эсвэл ажлын зар байршуулах хэлбэр (өөрөөр хэлбэл туршилтын гудамж талбай мөн/эсхүл сумын төвд байрлуулсан зурагт хуудас, мэдээллийн самбар, мөн/эсвэл олон нийтийн самбарт байрлуулсан мэдээлэл) (2020 оны суурь үзүүлэлт: 0) 	<ul style="list-style-type: none"> Хэрэгжүүлэгч байгууллагууд Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	<p>2023-2028</p> <p>Төслийн угсралт, төсөв</p> <p>барилга ашиглалтын төсөв</p>
<ul style="list-style-type: none"> 5.1b ажлын байрны зарыг цаг тухайд нь нийтэд зарлах; гэрээлэгчид орон нутгийн иргэдэд давуу эрх олгох (туршилтын гудамж ба/эсвэл сумын төвийн оршин суугчид), эмэгтэйчүүд, үндэсний цөөнх, ядуу иргэдийн барилгын ажилд хөлсөлж авах 	<ul style="list-style-type: none"> 5.2.1. 176 бизнес эрхлэгчид, 250 бичил бизнес БНХХААБС-ийн дэмжлэгээр 3850 ногоон ажлын байр шууд бий болгосны 300 нь ур чадвар шаардсан ажлын байр байна. Ур чадвар шаардсан болон шаардахгүй ажлын байрны 40%-ийг эмэгтэйчүүд, 40%-ийг ядуу өрхүүд эзлэх (2020 оны суурь үзүүлэлт: 0) 5.2.2. Аймгуудад 3 инкубатор, сум дундын төвүүдэд 2 инкубатор байгуулж, нийт 80 	<ul style="list-style-type: none"> БХБЯ Оролцогч аж ахуйн нэгжүүд 	<p>2023-2028</p> <p>БНХХААБС-гаас бий болгосон ажлын байр:</p> <p>2024: 0%</p> <p>2025: 10%</p> <p>2026: 30%</p> <p>2027: 65%</p> <p>Төслийн удирдлагын дэмжлэгээс 341,700 ам.доллар^в</p>
<ul style="list-style-type: none"> 5.2 Ядуу өрх, эмэгтэйчүүд зэрэг орон нутгийн ажиллах хүчнийг шинэ ажлын байраар хангах, ашиглалтын үе шатанд ядуу өрх, эмэгтэйчүүдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх 			

2022 оны 12 сарын 05 өдөр
Угсралт багцар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
<p>Зорилт ба үйл ажиллагаа</p>	<p>Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд</p> <p>оффис, ажлын байр бий болохоос 40% нь эмэгтэй удирдлагатай бизнес эрхлэгчдэд очсон байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>5.2.3. <i>Сумын</i> хоршоодын бизнес эрхлэгчид болон ЖДҮ-дэд зориулсан сургалтын хөтөлбөрт оролцогчдын дор хаяж 30% нь эмэгтэйчүүд байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>5.2.4. 1400 га усалгаатай бүсэд 80 ажлын байр бий болгохоос 20% нь эмэгтэйчүүдэд ногдсон байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<p>Хариуцах байгууллага</p> <ul style="list-style-type: none"> • Инкубаторууд 2025 онд 50%, 2026 онд 100% баригдаж дууссан байх • Усалгаатай бүс 2025 онд 25%, 2026 онд 50%, 2027 онд 100% баригдаж дууссан байх 	<p>Хугацаа</p> <p>2028: 100%</p>	<p>Төсөв</p>
<p>• Бүрэлдэхүүн хэсэг 1-3: Болзошгүй эрсдэлийг бууруулж, менежментийг бэхжүүлэх арга хэмжээ</p>	<p>6.1 ХХН түвшинд нийгэм, жендерийн мэргэжилтэн авч ажиллуулах</p>	<p>6.1.1. Нийгэм, жендерийн мэргэжилтнийг ТХН-нд 102 хүн-сар, оролцогч <i>аймгийн</i> ХХН тус бүрд 25.5 хүн-сар авч ажиллуулах (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p> <p>6.1.2. ТХН, ХХН-ийн бүх ажилтнууд нийгэм, жендерийн мэргэжилтнээс жендерийн онцлог хэрэгцээ, тэргүүлэх чиглэл, хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулалт, тайлагналын чиглэлээр сургалт авах (2020 оны суурь үзүүлэлт: 0)</p>	<p>2023</p> <ul style="list-style-type: none"> • АХБ • БХБЯ • Хэрэгжүүлэгч байгууллагууд • ХХН • ТХН 	<p>Төслийн удирдлагын дэмжлэгээс ам-доллар^в 341,700</p>
<p>6.2а Гэрээлэгч болон ажилчдад ХДХВ/ДОХ/БЗДХ, бэлгийн дарамт, мансууруулах бодис, хүний наймааны эсрэг ММБ олгох аян явуулах</p>	<p>6.2.1. Гэрээлэгч, ажилчдад 100% ХДХВ/ДОХ/БЗДХ, мансууруулах бодис, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг явуулсан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0%)</p> <p>6.2.2. Нийгмийн эрүүл мэнд ба ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох ажил явуулах ба оролцогчдын (хүйсээр нь ангилан мэдээлэх) 50% нь эмэгтэйчүүд, 20% нь ядуу иргэд байх (2020 оны суурь үзүүлэлт: 0%)</p>	<ul style="list-style-type: none"> • ТХН • ХХН • Хэрэгжүүлэгч байгууллагууд, гэрээлэгчид • Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	<p>2025-2028</p>	<p>Төслийн удирдлагын дэмжлэгээс ам-доллар^в 341,700</p>
<p>6.2б Нийгмийн эрүүл мэнд, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн оршин суугчдад мэдлэг, мэдээлэл олгох</p>	<p>6.2.2. Нийгмийн эрүүл мэнд ба ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох ажил явуулах ба оролцогчдын (хүйсээр нь ангилан мэдээлэх) 50% нь эмэгтэйчүүд, 20% нь ядуу иргэд байх (2020 оны суурь үзүүлэлт: 0%)</p>	<ul style="list-style-type: none"> • ТХН • ХХН • Хэрэгжүүлэгч байгууллагууд, гэрээлэгчид • Нийгэм, жендер, олон нийтийн оролцооны мэргэжилтнүүд 	<p>2025-2028</p>	<p>Төслийн удирдлагын дэмжлэгээс ам-доллар^в 341,700</p>

Хүний үсэг /Signature/ *М*

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Official Translation of Mongolian
OFFICIAL TRANSLATION

Зорилт ба үйл ажиллагаа	Зорилтот түвшин ба үзүүлэлтүүд	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
6.2с Хөдөлмөрийн үндсэн хэм, хэмжээний хэрэгжилтийг хангах (өөрөөр хэлбэл ижил хөдөлмөрийн хөлс, хүүхдийн хөдөлмөр ашиглахгүй байх гэх мэт), мөн аюулгүй ажиллагааны удирдамжийг гэрээнд тусгасан байх	6.2.3 Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээний талаар бүх барилга угсралтын ажлын гэрээнд тусгасан байх (2020 оны суурь үзүүлэлт: 0)			
6.3 Ирсэн гомдлыг мөшгөх ГШМ ба хяналтын систем бий болгосон байх	6.3.1. Эмэгтэйчүүдэд механизм талаар зохио ёсоор мэдээлэл өгдөг (GRM танилцуулахтай холбоотой аливаа уулзалтад эмэгтэйчүүдийн ирц хамгийн багадаа 45%) (2020 оны суурь үзүүлэлт: 0)	• ТХН	ГШМ-ын системийг 2023 онд хэрэгжүүлж эхэлсэн байх	ТХН

АХБ = Азийн Хөгжлийн Банк; ОНИХАО = орон нутгийн иргэдийн худалдан авалт дах оролцоо; БНХХААБС = Бүсийн ногоон, хүртээмжтэй бүс хөдөө аж ахуйн бизнесийн сан; ГШМ = гомдлыг шийдвэрлэх механизм; ММБ = мэдлэг, мэдээлэл ба боловсрол; м² = метр квадрат; БХБЯ = Барилга, хот байгуулалтын яам; ХОХСМТ = хамтын оролцоотой, хүртээмжтэй сүргийн менежментийн төлөвлөгөө; ТХН = төсөл хэрэгжүүлэх нэрж; БАХ = бэлчээр ашиглагчдын хэсэг; БАГ = бэлчээр ашиглах гэрээ; ЖДҮ = жижиг, дунд үйлдвэр; БЗДХ = бэлгийн замаар дамжих халдвар; ТОСК = Төрийн орон сууцны корпораци; УАЦЗА = ус, ариун цэвэр, эрүүл ахуй.

а АХБ, 2018. Хөрөнгийн өмчийн эрх, бизнес эрхлэлтийг жөндөрийн талаас хэмжих нь: Гүрж, Монгол, Филлиппин улсад явуулсан туршилтын судалгааны арга зүй ба үр дүн, Манила.

б Мянганы сорилтын сангийн өмчийн эрхийн төслийн хүрээнд 2018 онд явуулсан судалгаа.

с БХБЯ, хэрэгжүүлэгч байгууллагууд, ТХН-ийг санал болгох үйл ажиллагааг явуулж, үзүүлэлтийг хянахад төслийн зөвлөхүүд дэмжлэг үзүүлнэ.

д 2019 оны 9-р сард хийсэн нийгэм, эдийн засгийн судалгаагаар Өлгий хотод нэг багийн 13 зорилтот гудамж, нийт өрхийн 40.7%, Ховдын багийн зорилтот гудамж, 31.4%; мөн Увсын багийн зорилтот 4 гудамж, 37.7% нь амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч байна. 2019 оны 1-р сарын 22-ны өдрийн А/12-ны тоот захирамжаар Баян-Өлгий, Ховд, Увс зэрэг баруун бүсийн аймгуудын 2019 оны амьжиргааны доод түвшнийг 190700 төгрөгөөр тогтоосон байна.

е Жендерийн мэдрэмжтэй олон нийтийн орон зай гэдэг нь эмэгтэйчүүдэд нийтийн эзэмшлийн талбайг ашиглахад таатай мэдрэмж төрүүлдэг, нийгмийн тодорхой нөхцөлд жендерийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хот байгуулалтын дизайныг хэлнэ. Соёлын талаас харгалзан үзвэл (тодорхой улс орны эмэгтэйчүүд зарим хот байгуулалтын дизайн тухтай байж болох бол тухайн дизайн нь өөр нийгэмд эмэгтэйчүүд тусгаарлаж байж болох юм); Эмэгтэйчүүдтэй зураг төслийн шатанд зөвлөлдөх ёстой. Жишээлбэл, Францад Парис хотын захиргаанаас гарсан жендерийн мэдрэмжтэй хотын дизайны гарын авлагад эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн дизайныг сурталчлах үүднээс хөдөлгөөнт байдал, нийтийн эзэмшлийн талбайн ашиглалт, аюулгүй байдлын мэдрэмж зэрэг сэдвүүдтэй холбоотой онцлог шинж чанаруудыг тодорхойлсон байдаг. Францын нөхцөлд жендерийн мэдрэмжтэй хотын дизайны жишээг дурдахад явган хүний өргөн цэлгэр зам тавих (хүүхдийн тэрэгтэй эсвэл асаргаа шаардах өндөр настай хүмүүстэй хамт явах эмэгтэйчүүдэд зориулсан), нийтийн гэрлүүлэг, тэмдэглэгээний чанарыг сайжруулах, эмэгтэйчүүдэд зориулсан сууж хүлээхэд тухтай сандалтай автобусны зогсоолын төлөвлөлт хийх зэрэг байж болох юм. Зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийх нь зорилтот зорилтот аймаг, сумдын эмэгтэйчүүдийн дизайны шаардлагатай тэргүүлэх чиглэлийн дизайны онцлогийг тодорхойлоход нэн чухал юм.

ф Монголын бэлчээр ашиглагчдын холбооны статистик мэдээллээр 1-р үе шатын төсөлд хамрагдах зорилтот сумдын малчин өрхүүд 100% БАХ-ийн зохион байгуулалтад орсон байна. Гэсэн хэдий ч чанарын судалгааны хүрээнд хийсэн ярилцлагаас харахад уг тооцоолол хэт өндөрдсөн байна. Төслийн эхэнд Монголын бэлчээр ашиглагчдын холбооноос мэдээллийг цуглуулж, үүнийг баталгаажуулна.

г Швейцарын хөгжлийн агентлаг. 2021 он. Тогтвортой менежменттэй бэлчээр ба эрүүл мал: Монголын "Ногоон алт" төсөл.

Харгалж ашиглагчийн үеэр /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Төслийн ОНИХАО-ны хуудсанд заасан (санхүүжилтийн хүсэлт)-ыг үндэслэсэн бөгөөд төслийн зөвлөхүүд баталгаажуулсан болно.
БАХ-гийн зохион байгуулалтад орсон нь ОНИХАО-ын санхүүжилтийн бүх шалгуурыг хангасан гэж үзнэ (БАГ-нд гарын үсэг зурж, ХОХСМТ ба сүргийн тохируулгын төлөвлөгөө боловсруулсан байх).
Баянхонгор аймаг дахь Хил, хязгааргүй малын эмч нар ба агрономчид ТББ (AVSF)-ын төсөл зэрэг ижил төстэй төслүүдэд хүрсэн зорилт.
Эх сурвалж: АХБ.

Монгол Улсын Сангийн яам
ТӨР БАН ЕСНЭ ОРЧУУЛГА МӨН

арын үсэг /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ХУВААРЬ 6

ҮҮРЭГ АМЛАЛТ

Тус сангийн хүрээнд хамаарах үе шат бүрд зориулан байгуулах хууль ёсны гэрээ, хэлэлцээрүүдээс гадна Монгол Улс Хөгжлийн банк, БХБЯ, ХХААХҮЯ нь дараах үүрэг амлалтыг хүлээж буй болно. Үүнд:

Хэрэгжилтийн зохицуулалт

- (i) *Аймаг, сумын төвүүдийн бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, түүний бүрэлдэхүүн хэсэг, зорилтот үр дүнг хангах, тэр дундаа энэхүү СЕХ-ийн Хуваарь 3-т заасан хэрэгжилтийн зохицуулалтыг хангаж, энэхүү СЕХ-д хавсаргасан ХШХ-г үндэслэн хэрэгжилтэд хянах-шинжилгээ, үнэлгээ хийхээр тасралтгүй зорино.*
- (ii) Энэхүү сангийн хүрээнд санхүүжүүлж буй бүх төслүүдийг энэхүү СЕХ-ийн Хуваарь 4-т заасан шалгуур, журмын дагуу сонгон баталж, тэдгээр бүх төслүүдийг СЕХ-ийн Хуваарь 5-д тусгасан хамгаалал, нийгмийн шаардлагын дагуу боловсруулж, хэрэгжүүлж, тэдгээр шаардлагыг тасралтгүй хангах.
- (iii) Энэхүү СЕХ-ийн Хуваарь 1-д заасан ерөнхий зураглалыг хэрэгжүүлэх.
- (iv) Тус сангийн хүрээнд санхүүжүүлэх төсөл тус бүрийн эдийн засгийн үр ашигт материаллаг нөлөө үзүүлэхүйц ерөнхий зураглал, эдийн засгийн хөгжилтэй холбоотой бодлого, хөтөлбөрүүдийн талаар АХБ-анд мэдээлнэ. ерөнхий зураглал, бодлогын хүрээ, төсөл, санхүүжилтийн төлөвлөгөөнд өөрчлөлт орох тохиолдолд Монгол Улс нь АХБ-тай Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тэдгээрийн үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлж, хөтөлбөрийн хамрах хүрээг зохих ёсоор өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах, мөн үргэлжлүүлэх эсэхийг дахин хэлэлцэнэ.
- (v) Хөтөлбөр болон хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийг ХХГА-д заасан нарийвчилсан зохицуулалтын дагуу хэрэгжүүлнэ. ХХГА-д оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг Засгийн газар болон АХБ-наас баталсны дараа хүчин төгөлдөр гэж үзнэ.
- (vi) Хөтөлбөрт хамаарах төсөл нэг бүрийг байгаль орчны асуудал, уугуул иргэд, албадан нүүлгэн шилжүүлэлт, жендерийн бодлого, авлигатай тэмцэх бодлого, хөдөлмөрийн хэм хэмжээтэй холбоотой, мөн энэхүү СЕХ-ийн Хуваарь 5-д заасан хориотой хөрөнгө оруулалтын жагсаалт, хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үе шат бүрийн гэрээ, хэлэлцээрт хүлээсэн үүрэг амлалт, баталгааны дагуу хэрэгжүүлнэ.
- (vii) Төслийн удирдах хороог ХХГА-д нарийвчлан тодорхойлсны дагуу байгуулна.

Засгийн газрын дэмжлэг ба ашиглалт, засвар үйлчилгээ


- (i) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний төсөв хөрөнгийг цаг тухайд нь хуваарилан гаргаж, хөтөлбөр, төслүүдийн магадалшгүй зардлын төсвөөс давсан зардлын нэмэлт санхүүжилтийг гаргана.
- (ii) Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллагууд нь байгуулсан гэрээ, хэлэлцээрт хүлээсэн үүргээ биелүүлэх, уг сангийн хүрээнд хэрэгжих төслүүдийг цаг тухайд нь хэрэгжүүлж дуусгах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай буюу зохих хэмжээний төсөв хөрөнгө, барилга байгууламж, үйлчилгээ болон бусад нөөцөөр хангах зэрэг бүхий л арга хэмжээг авна.

Харгалууны үеэр /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

- (iii) Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллагууд нь аливаа ажил, бараа болон үйлчилгээний гэрээнд хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд хангалттай хөрөнгөтэй байх нөхцөлөөр хангана.
- (iv) Хэрэгжилтийн бүхий л хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, техникийн болон хүний нөөцөөр цаг тухайд хангана.
- (v) Хөтөлбөрийн бүхий л хугацаанд зохих мэргэжлийн ур чадвартай хүний нөөцөөр хангалттай хэмжээнд хангах ба хөтөлбөрт хамрагдсан бүх ажилтнуудыг оффис, барилга байгууламж, тоног төхөөрөмж, туслах ажилтан, харилцаа холбоо, менежментийн мэдээллийн системээр хангана.
- (vi) Хөтөлбөрийн бүхий л хугацаанд ТХН-ийн (Хуваарь 3-т заасан хэрэгжилтийн зохицуулалтад тодорхойлсончлон) тогтвортой ажиллуулна.
- (vii) Хөтөлбөрийн хүрээнд баригдсан дэд бүтцийн хөрөнгө, бараа материалын ашиглалт, засвар үйлчилгээнд хангалттай төсөв хөрөнгө хуваарилна.




УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТУСГАЙ ШААРДЛАГА.

Бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлсон үйл ажиллагаанууд нь үечилсэн санхүүжилтийн тайлан болон хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлагын Хэсэг 1-д нарийвчлан тусгасан бүрэлдэхүүн хэсэг, үйл ажиллагаанууд болно.

Шигтгээ А1.1: Бүрэлдэхүүн хэсэг 2-ийн сонгон шалгаруулалтын тусгай шаардлага

Бүрэлдэхүүн хэсэг 2-ийн бүх бэлчээрийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. **Нөлөөлөлд оруулах хувь нэмэр.** Хөрөнгө оруулалт нь дараах зүйлсэд шууд хувь нэмэр оруулахаа нотлох ёстой.
 - (i) газар ашиглалт, нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй бэлчээрийн менежмент, хамгаалалт болон бэлчээрийн нүүрстөрөгчийн шингээлтийн нэмэгдэлтээс үүдэх хүлэмжийн хийн ялгарлын бууралт;
 - (ii) уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгалийн гамшгийн эсрэг тэсвэртэй болох, мөн уур амьсгалын өөрчлөлтөд өртөж болзошгүй хамгийн эмзэг бүлгийн иргэд, олон нийт, бүс нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахад хувь нэмэр оруулах зэргээр уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй болгох; мөн
 - (iii) экосистем ба экосистемийн үйлчилгээг байгалийн гамшгийн эсрэг илүү тэсвэрлэх чадвартай болгох.
2. **Үйл ажиллагаа**
 - (i) Уур амьсгалын ногоон сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна.
 - (a) нүүрстөрөгч багатай бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг дэмжиж, чадавхыг бэхжүүлэх;
 - (b) нүүрстөрөгч багатай бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэгт тулгуурласан нүүрстөрөгч багатай малчдын хоршоодод дэмжлэг үзүүлж, чадавхыг бэхжүүлэх;
 - (c) сүргийн тоог багасгахыг дэмжих хөшүүрэг;
 - (d) байгалийн гамшгийн эсрэг тэсвэрлэх чадварыг сайжруулах, бүтээмж, малчдын амьжиргааг дээшлүүлэх жижиг дэд бүтэц, тоног төхөөрөмж;
 - (e) мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах;
 - (f) тэжээл, хүнсний ногооны үйлдвэрлэлийн толгойн байгууламж, усалгааны үндсэн суваг;
 - (g) экосистемд суурилсан байдлаар усыг хамгаалах, ус хураах шийдэл;
 - (h) мал мөшгөх тогтолцоог дэмжих; болон
 - (i) баталгаажуулалтын системийг дэмжих.
 - (ii) Үе шат 1-д заагаагүй нэмэлт үйл ажиллагааг зөвхөн дараах зүйлсийг нотолж чадвал авч үзэж болно.
 - (a) малчдын даван туулах чадвар болон амьжиргаа,
 - (b) экосистемийн тэсвэрт байдал,
 - (c) эдийн засгийг төрөлжүүлэх замаар мал сүргийн тоог шууд буюу шууд бусаар бууруулах,
 - (d) бэлчээрийн системийг сайжруулах.
3. **Магадлан судалгаа.** Азийн Хөгжлийн Банкны магадлан судалгааны зохих бодлогыг дагаж мөрдөх.
4. **Хамгааллын ангилал.** Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны аль нь ч хамгааллын А ангилалд хамаарах ёсгүй.



5. **Жендер.** Хөрөнгө оруулалт нь *жендерийг үр дүнтэй уялдуулан тусгасан* гэх энэ үе шатын ангиллыг дэмжих бөгөөд хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлын үеэр үр дүнтэй зөвлөгөөн хийснээ нотолно.
6. **Байгаль орчны асуудал.** Санхүүжүүлсэн үйл ажиллагаанаас хүлэмжийн хийн ялгаралт нэмэгдэхгүй гэдгийг баталгаажуулна.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк.

Шигтгээ А1.2: Бүрэлдэхүүн хэсэг 2 (Уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй бөгөөд тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх нь) ба 4 (Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бүсчилсэн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх)-ийн үр шимийг хүртэгчдэд тавигдах нөхцөл


1. **Орон нутгийн иргэдийн худалдан авалт дахь оролцоотойгоор бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийн хийх орон нутгийн хөрөнгө оруулалтад тавиа нөхцөл (бүрэлдэхүүн хэсэг 2, үйл ажиллагаа 1).** Үүнд:
 - (i) хэд хэдэн өрхөд ашиг тусаа өгөх бөгөөд хувийн бизнесийн хөрөнгө оруулалт байж болохгүй;
 - (ii) шаардлага хангасан төслүүдийн нэг хэсэг байх;
 - (iii) хамтын оролцоотой, хүртээмжтэй сүргийн менежментийн төлөвлөгөө (ХОХСМТ)-нд тусгагдсан бөгөөд БАХ хэрэгжүүлэх;
 - (iv) БАХ нь хөтөлбөрийн шаардлагын дагуу бэлчээр ашиглах гэрээ (БАГ)-г сумын засаг захиргаатай байгуулсан байх ба үүнд сүргийн тохируулга хийх төлөвлөгөө багтсан байх;
 - (v) БАХ нь нийт хөрөнгө оруулалтын 20 хувь (ажиллах хүч, материал, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын хөрөнгө)-ийг гаргах ёстой; мөн
 - (vi) хөтөлбөрийн шаардлагын дагуу орон нутгийн иргэдийн худалдан авалт дахь оролцооны хөтөлбөрийн хуудсанд дэлгэрүүлж боловсруулсан байх.
2. **БАХ байгууллагуудад үзүүлэх дэмжлэг (бүрэлдэхүүн хэсэг 2, үйл ажиллагаа 2.2).** Зорилтот бүх байршилд эхний хэдэн жилийн эхлэлийн санг нөхөх санхүүгийн дэмжлэгийг сумын БАХ-ийн холбоо ба *аймгийн* БАХ-ийг холбоонд олгоно.
3. **Малчдын хоршоо, тэдгээрийн байгууллагуудад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх (бүрэлдэхүүн хэсэг 2, үйл ажиллагаа 2).** Шаардлага хангасан хоршоод нь амжилттай хэрэгжиж буй БАХ-ийн хөтөлбөрийн дагуу байгуулагдсан хоршоо, эсвэл тавих шаардлагын жагсаалтыг хангасан, эсвэл хангахад дэмжлэг авах сонирхолтой байгаа хоршоод байна. Шаардлагын жагсаалтыг хэрэгжүүлэх шатанд эцэслэн тодорхойлох боловч дараахыг удирдлага болгож, харгалзан үзнэ.
 - (i) Сумын хоршооны гишүүд нь сүргийн тохируулга хийх төлөвлөгөө болон БАГ-нд гарын үсэг зурсан, ХОХСМТ-нд оролцдог гишүүд байна.
 - (ii) Сумын хоршоо нь нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн зарчим, тэр дундаа тогтвортой байдлын гурван тулгуур буюу нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой байдлыг хөхиүлэн дэмждэг. Эдгээр зорилтыг хоршооны статуст тодорхой зааж өгсөн байх ёстой.
 - (iii) Бүх гишүүд хоршооны анхны хөрөнгө оруулалтын хөрөнгийг бүрдүүлэхийн тулд нэгдсэн хуралдааны үеэр тодорхойлсон анхны санхүүгийн хувь нэмрээ оруулсан байх.
 - (iv) Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад гишүүдийн идэвхтэй оролцоог хангасан ардчилсан/доороос дээш засаглалтай байх.
 - (v) Статусыг бүртгэж, шинэчилдэг.
 - (vi) Хоршооны удирдлага нь идэвхтэй, үр дүнтэй ажилладаг.
 - (vii) Ашиг хуваарилалтыг бүх гишүүдийн шийдвэр дээр үндэслэдэг.
 - (viii) Жилийн санхүүгийн тайлангийн бэлэн байдал.
 - (ix) Хоршоо нь эрхэм зорилго, зорилтоо хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх ёс зүйн хороогоор хянагдахаар тохиролцсон байх.
 - (x) Тогтвортой байдлын үзэл баримтлалын тодорхойлолтод нийцсэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нүүрстөрөгч багатай гэрчилгээжүүлэлтийг хэрэгжүүлдэг эсхүл хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байж, улмаар нүүрстөрөгч багатай дадлыг хэрэгжүүлж буй малчдаас гаралтайг шинжлэх ухааны аргаар баталгаажуулдаг байх.
 - (xi) Одоо байгаа хоршоод эдгээр шаардлагыг хангахгүй байгаа бол хөтөлбөрөөс тогтвортой байдал, засаглал, захиргаа удирдлага, санхүүгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдах хүслийг нь үнэлнэ.
4. **Малын тоо толгойг бууруулах урамшуулал (бүрэлдэхүүн хэсэг 2, үйл ажиллагаа 2.3).** Хөтөлбөрийн шаардлагын дагуу БАГ-нд гарын үсэг зурж, жил бүр хяналт тавьж, сүргийн тохируулга хийх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтоо хангасан БАХ үүнд хамрагдана.
5. **Лаборатори, малын үл мөр мөшгөн тогтоолт, мал эмнэлгийн тоног төхөөрөмж, өвчнөөс ангид байгууламж (хэсэг 2, үйл ажиллагаа 4 ба 5)-ийг бүх малчдад үйлчилдэг мал эмнэлгийн ерөнхий газраас удирдан хэрэгжүүлнэ.** Үндсэн шаардлага: зорилтот *аймгийн эсхүл сум дундын төв* (лабораторийн болон өвчнөөс ангид байгууламж, мөн холбогдох сумын сүрэг/БАХ-т мал үржил, мал эмнэлгийн тоног төхөөрөмж ба үл мөшгөх тогтолцоо).

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

6. **Бэлчээрийн менежмент болон мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (бүрэлдэхүүн хэсэг 4, үйл ажиллагаа 2).** Зорилтот сумын бүх малчид болон БАХ нь БАХ ба хоршоод, БАГ, ХОХСМТ, мал үржил, мал эмнэлгийн үйл ажиллагааг хөгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд оролцох эрхтэй.
7. **БАХ бүрийн орон нутгийн иргэдэд түшиглэсэн нэг малын эрүүл мэндийн ажилтан (туслах эмч) сургах ба тоног төхөөрөмжөөр хангах (бүрэлдэхүүн хэсэг 2, үйл ажиллагаа 5).** Зорилтот сумын бүх БАХ хамрагдах эрхтэй.
8. **Усалгаатай бүсийн үндсэн ажлууд (бүрэлдэхүүн хэсэг 2, үйл ажиллагаа 3) нь сонгогдсон аймаг, сум дундын төвийн ойролцоо хэрэгжих болно.** Байршил, техникийн үзүүлэлтүүд, урьдчилсан зураг төсөл, зардлыг ТЭЗҮ боловсруулж, тодорхойлно. Хэрэгжих байршил бүрд “анхдагч” ашиг хүртэгч нь дэд бүтцийг өмчлөгч орон нутгийн засаг захиргаа байх бол “хоёрдогч” ашиг хүртэгчид нь тариаланчид, ус ашиглагчид байх юм. Усалгаатай бүсийн үндсэн ажлуудаас үр шимийг нь хүртэж буй тариаланчид, ус ашиглагчдыг сонгон шалгаруулах ажлыг төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд явуулах бөгөөд ингэснээр тус бүрэлдэхүүн хэсгээс хувийн хэвшил үндсэн ажлыг усжуулалтын бүсийг холбох ажилд шаардлагатай санхүүжилтийн дэмжлэг авах юм. Сонгон шалгаруулалтын шаардлагыг бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулна.
9. **Малчдын хоршоо, тэдгээрийн бүтэц байгуулалт, усалгаатай бүсийн ус ашиглагчдын чадавхыг бэхжүүлэх (бүрэлдэхүүн хэсэг 4, үйл ажиллагаа 2).** Бүрэлдэхүүн хэсэг 4, үйл ажиллагаа 2-ын үр шимийг хүртэгчдийг сонгон шалгаруулахад тавих шаардлага нь бүрэлдэхүүн хэсэг 2-т тавих шаардлагатай ижил байна.
10. **Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн санхүүжилтийн чадавхыг сайжруулах бүрэлдэхүүн хэсэг 4, үйл ажиллагаа 3.** Ашиг хүртэгчид нь (i) нүүрстөрөгч багатай хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тодорхойлсон салбарт ажилладаг хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчид (жижиг, дунд үйлдвэр, хоршоо), байх; мөн (ii) хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүжилтийн механизмыг боловсруулах Монгол Улсын Хөгжлийн банк болон арилжааны банкнууд (арилжааны банкнуудын сонгон шалгаруулалтыг бүрэлдэхүүн хэсэг 3-т нарийвчлан тодорхойлсон болно).

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк.



Шигтгээ А1.3: Бүсийн ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сан (БНХХААБС)-гийн хураангуй

Хөдөө аж ахуйн санхүүжилтийн хүртээмжид тулгарч буй уламжлалт саад бэрхшээл. Дэлхийн Банкнаас уур амьсгалын санхүүжилтийг хөдөө аж ахуйд хэрхэн ашиглаж болохыг шинжилж үзэхэд санхүүжүүлэгчид ашиг багатай, бодит болон боломжит эрсдэл өндөр (болон бусад асуудал) гэх ойлголтоос шалтгаалан хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуйн салбар (мал аж ахуйн салбарыг оролцуулаад)-т олон арван жил хангалттай хэмжээний санхүүжилт олж авахад бэрхшээлтэй байсаар ирснийг тэмдэглэжээ. Тиймээс ихэнх улс орны санхүүжүүлэгчид энэ салбар дахь үйл ажиллагаагаа хязгаарлах, зээлийн хүүгээ өсгөх, зээлийн шаардлагаа чангатгах, хугацааг богиносгох, зээлийн хүнд нөхцөл тавих, хөдөө аж ахуйд зээл өгөхөөс огт татгалзаж зэрэг хариу арга хэмжээ авч, улмаар эдийн засгийн бусад салбаруудаас тогтвортой ашиг олохыг эрмэлздэг байна. Жижиг тариалан эрхлэгчид/малчид, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч (ЖДҮ)-дэд хүртээмжтэй, хангалттай хэмжээний санхүүжилт авах боломжийг хязгаарлаж ирсэн дараах гурван томоохон уламжлалт саад бэрхшээл байгаа бөгөөд эдгээрийг хөдөө аж ахуйн судалгаануудад дутагдаж буй дундын холбоос гэж нэрлэдэг байна. Үүнд: (i) гүйлгээний зардал өндөр, (ii) зохистой орчин бүрдээгүй, мөн (iii) хөдөө аж ахуйн тодорхой эрсдэлийг удирдах санхүүгийн салбарын чадавх хангалтгүй байна.^a Хөдөө аж ахуйн санхүүжилтэд тулгараад байгаа эдгээр бэрхшээл нь Монгол Улсад байгаа нь АХБ-ны хэд хэдэн судалгаа болон хөтөлбөрийн зорилтот *аймаг, сумдад* хийсэн хэлэлцүүлэг зөвлөгөөнөөс харагдаж байна. Эдгээр бэрхшээлийг арилгах нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, тогтвортой бэлчээрийг дэмжихэд дасан зохицох санхүүжилтийг чиглүүлэх, улмаар уур амьсгалд ухаалаг мал аж ахуйн салбарыг Монгол Улсад хөгжүүлэх суурийг бий болгох юм.

БНХХААБС-гийн бүтэц, удирдлага. Бүртгэлийн хэсэг 3-ыг хэрэгжүүлэх хүрээнд, санхүүжилт ба хэрэгжилтийн зохицуулалт нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох холимог санхүүгийн стратегийг ашиглахад санхүүгийн зуучлалын зээл (СЗЗ)-ийн бүрэлдэхүүн хэсгийг ашиглан уур амьсгалд ухаалаг, нүүрстөрөгч багатай мал аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор Монгол Улсад дөхөм үзүүлэх юм.^b Хөтөлбөрийн СЗЗ-ийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн Банкны хөрөнгийн менежментийн компани (ХБ-ХУК) нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлагыг дэмжих зорилгоор Сангийн яам (СЯ)-ны нэрийн өмнөөс БНХХААБС-г байгуулна. Үүний зэрэгцээ, малчид, бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ), хөдөө аж ахуйн хоршоод, тэдгээрийн түнш бизнес эрхлэгч аж ахуйн нэгж өрсөлдөх чадвартай, хүртээмжтэй бөгөөд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ (НБУАТМААНС)-ний ашиг тусыг бүрэн хүртэхэд саад тотгор болж буй санхүүжилтийн бэрхшээлийг энэхүү сан шийдвэрлэх болно.^c ХБ-ХУК нь БНХХААБС-гаар дамжуулан УАНС-ийн санхүүжилтийг ашиглан арилжааны банкнууд болон банк бус санхүүгийн байгууллагууд, жижиг, дунд, тэр ч байтугай томоохон аж ахуйн нэгжүүд, хөдөө аж ахуйн хоршоо болон төрөөс нэмэлт хөрөнгө оруулалт татах болно.

Хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар УАНС-ийн зээлийн хөрөнгөөс 87.61 ам.долларыг БНХХААБС-д хөрөнгө оруулах бөгөөд үүнийг ХБ-ХУК санхүүгийн толгой байгууллагын хувьд удирдана. Мөн нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй инновацыг санхүүжүүлэх зорилгоор 5 сая ам.долларын нөхөн авах буцалтгүй тусламжийн хөрөнгийг БНХХААБС-д дамжуулан олгоно. БНХХААБС нь хувийн хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр байгуулагдах^d бөгөөд эргэлтийн сангийн бүтэцтэй байна. НБУАТМААНС-ний оролцогч талуудын уур амьсгалын ухаалаг санхүүжилтийн хэрэгцээ харилцан адилгүй тул уг сан нь эхний зэлжид (i) оролцогч арилжааны банкнуудаар дамжуулан эсвэл ХБ-ХУК бусад банк, санхүүжүүлэгчидтэй хамтран шууд хэлбэрээр нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй зээлийн хоёр цонхтой, (ii) нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй зээлийн батлан даалтын хөтөлбөртэй, (iii) инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгө оруулалтыг урамшуулж, илүү ногоон, илүү хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай НБУАТМААНС-г бий болгоход чиглэсэн нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй инновацын тэтгэлгийн хөтөлбөртэй тус тус байна (Бүсийн ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сангийн бүтцийг доор харна уу). Бичил бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хэрэгцээг хангах, хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ) болон бусад банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох өөр нэг нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй зээлийн цонхыг үе шат 1-ийн хүрээнд туршиж, үе шат 2-ын хүрээнд өргөжүүлэх боломжтой юм. Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй зээлийн эхний хоёр цонхны хувьд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй бэлчээрийн менежмент хийх, хот-хөдөөгийн холбоосыг хөгжүүлэх, мал аж ахуйн газар тариалангийн нийлүүлэлтийн сүлжээг төрөлжүүлэх чиглэлээр малчид болон малчдын хоршоодтой хамтран үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд зээл авах боломжтой.


Бүсийн ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сангийн бүтэц

Монгол Улсын Сангийн яам
ЗВАН ГСНЫ ОРЧУУЛГА МӨН

ын үеэр /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION



Дамжуулан болон дахин зээлдэх механизм. Орлогч арилжааны банкнуудыг дараах суур болон сонгон шалгаруулалтын шаардлагыг ашиглан сонгоно, үүнд: (i) Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад зохих ёсоор бүртгэгдсэн банк байх; (ii) хөдөө аж ахуй, агро-бизнесийн санхүүжилтийн чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх; (iii) зорилтот *аймаг, сумдад* хөдөө аж ахуй, агро-бизнесийн иргэдийн банкны үйлчилгээ эрхлэх хангалттай чадавхтай байх; (iv) хүлэмжийн хийн санхүүжилт гэх зэрэг ногоон хөгжлийн санаачилгыг дэмжих санхүүжилтийн хөтөлбөр одоо хэрэгжүүлж байгаа эсвэл хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх; (v) АХБ-ны шаардлагад нийцэх компанийн, санхүүгийн болон засаглалын практиктэй байх; (vi) ёс зүй, мөнгө угаахтай тэмцэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар АХБ-ны хийсэн магадлан судалгааг давсан байх бөгөөд тэдгээртэй холбогдох хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан; (vii) Монголбанканд хугацаа хэтэрсэн үүрэг, өглөггүй эсвэл аудитын сөрөг дүгнэлтгүй; (viii) АХБ-ны шаардлагад нийцэх нягтлан бодох бүртгэлийн тайлан хөтлөлт, процедур гэх зэрэг санхүүгийн менежментийн систем, дотоод хяналт болоод эрсдэлийн удирдлагын систем сайн бүрдүүлж ирсэн байх; (ix) АХБ-ны шаардлагад нийцсэн байгаль орчин, нийгмийн менежментийн системтэй байх эсвэл систем бий болгох сонирхолтой байх ба үүнд тус системийг удирдах, хэрэгжүүлэх мэргэшсэн ажилтнууд ажиллуулах зэрэг мөн хамаарна; (x) Хөгжлийн банк, БНХХААБС, ХБ-ХУК, Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбогдох үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, тэдгээрт тайлагнах туршлагатай мэргэжлийн боловсон хүчнийг томилоход бэлэн байх зэрэг орно. Урьдчилан сонгогдсон арилжааны банкнуудад магадлан судалгаа хийж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад жилд хоёроос доошгүй удаа шинэчилж байх болно.

БНХХААБС-гийн зээл олгох цонх 1. Энэхүү цонхны хүрээнд гурван ангиллын дэд төслийг санхүүжүүлэх боломжтой. Тус бүрийн нарийвчилсан мэдээлэл, тэдгээрийн санхүүжилтийн нөхцөлийг доорх хүснэгтэд харуулсан болно.⁶

Ангилал 1-ийн дэд төслүүд	
Шаардлага хангасан дамжуулан зээлдэгч ба дэд төсөл	<p>Энэхүү зээлийн цонхны хүрээнд БНХХААБС нь НБУАТМААНС-тэй холбоотой хөдөө аж ахуйн бизнесийн дараах нэн чухал дэд төслүүд хэрэгжүүлэх этгээдүүдэд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн зээлийг оролцогч банкнуудаар дамжуулан олгоно. Үүнд зээлдэгч нь: (i) гэрчилгээжсэн малчдын хоршоо, эсвэл (ii) дэд төслийн нийт зардлыг санхүүжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд дэд төслийн ашгаас дор хаяж 10%-ийг хоршоонд өгөхөөр зааж, гэрчилгээжсэн малчдын хоршоотой түншлэлийн гэрээ байгуулсан ЖДҮ эрхлэгчид тус тус байна. Дараах чиглэлийн төслүүд хамрагдана, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (i) Зорилтот <i>аймаг, сум</i> дундын төвүүд дэх хөтөлбөрийн санхүүжилттэй хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн паркуудад эсхүл ижил түвшний дэд бүтэц, хотын үйлчилгээтэй байршил дахь шинэ мах боловсруулах цех; (ii) Шинэ усалгаатай бүсүүд (зөвхөн малын тэжээлийн ургамал, үр тариалахад зориулагдсан байх ба бусад зориулалттай бол энэ цонхноос санхүүжилт авах эрхгүй); (iii) Боловсруулах байгууламжуудыг хэрэгцээтэй цэгт дахин байрлуулж, тээвэрлэлтийн хэрэгцээ, шаардлагыг багасгаж, тээвэрлэлтээс үүдэх

2022 оны 10 сарын 05 өдөр
 Улаанбаатар хот
 /Signature/ _____
 Ministry of Finance of Mongolia
 OFFICIAL TRANSLATION

	<p>нүүрстөрөгчийн ялгарал болон тээвэрлэлтийн явц дах хаягдлаас үүдэх нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах;</p> <p>(iv) Сэргээгдэх эрчим хүч, хаягдал материал ашиглах зэргээр нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй технологийг үйлдвэрлэлийн процесст нэвтрүүлж буй дэд төслүүд;</p> <p>(v) Мал үржлийн үйлчилгээ үзүүлэх, хүлэмжийн хийн ялгаруулалт (ХХЯ), бэлчээрт үзүүлэх дарамтыг бууруулж малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож чадварыг дээшлүүлэх зорилгоор ус, тэжээлийн хүртээмжийг сайжруулах зэрэг малчдад арилжааны үндсэн орцоор хангах дэд төслүүд.</p>
Дамжуулан зээлийн хөрөнгийг зарцуулахад зөвшөөрөгдөх зориулалт	<p>(i) Эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ</p> <p>(ii) Тоног төхөөрөмж худалдан авах</p> <p>(iii) Барилга угсралтын ажил</p> <p>(iv) ТЭЗҮ/бизнес төлөвлөгөө боловсруулах</p> <p>(v) ТЭЗҮ/бизнес төлөвлөгөө боловсруулахтай салшгүй холбоотой судалгаа</p> <p>(vi) Инженерийн нарийвчилсан зураг төсөл</p>
Урьдчилсан байдлаарх дамжуулан зээлийн хэмжээ	350,000 ам.доллар хүртэл буюу түүнтэй тэнцэх төгрөг
Урьдчилсан байдлаарх дамжуулан зээлийн нөхцөл	Зээлийн хүү: жилийн 7%; хугацаа: эргэлтийн хөрөнгийн зээл (2 жил хүртэл), бусад: (дээд тал нь 7 жил хүртэл); үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 3 жил хүртэл
Ангилал 2-ын дэд төслүүд	
Шаардлага хангасан дамжуулан зээлдэгч ба дэд төсөл	<p>Энэхүү зээлийн цонхны хүрээнд БНХХААБС нь нийлүүлэлтийн сүлжээ дэх мал аж ахуйн боловсруулалттай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг, дараах дэд төслүүдийг хэрэгжүүлэх хөдөө аж ахуйн бизнесүүдэд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн зээлийг оролцогч банкуудаар дамжуулан олгоно. Зээлдэгч нь (i) гэрчилгээжсэн малчдын хоршоодтой түншлэлийн гэрээ байгуулсан ЖДҮ (тус гэрээнд дэд төслийн ашгийг хамгийн багадаа 10%-15%-ийг хошоонд ногдохоор заасан байна); эсхүл (ii) гэрчилгээжсэн малчид, БАХ, малчдын хоршоо гэх мэт ханган нийлүүлэгчидтэй худалдах, худалдан авах гэрээ (хуваарийг ба чанарыг заасан байх) байгуулж, түүний дагуу түүхий эд, бүтээгдэхүүний төлбөрийг нийлүүлэгч нарт жил бүр (эсвэл улирлаар) хувааж төлөх, ашгаа хуваах үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчид, эсвэл (iii) хоёр талын хооронд харилцан тохиролцсон ажил үүрэг, ашиг хуваах зохицуулалт бүхий гэрээ байгуулан гэрчилгээтэй малчидтай хамтран ажилладаг ЖДҮ эрхлэгчид байна.° Дараах чиглэлийн төслүүд хамрагдана, үүнд:</p> <p>(i) Мах</p> <p>(ii) Арьс шир</p> <p>(iii) Ноос</p> <p>(iv) Ноолуур</p> <p>(v) Сүү</p> <p>Эдгээр хөдөө аж ахуйн бизнес санхүүжилт авахын тулд уг хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зорилтот <i>аймаг, сумын</i> хөдөө аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын оролцоо, хамтын зөвшилцлийн үндсэн дээр боловсруулсан нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөө (НБУАТХААБХТ)-нд тусгагдсан байх ёстой. Тэд мөн <i>аймаг</i> эсвэл <i>сум дундын</i> төв дэх хөтөлбөрийн санхүүжилттэй хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн парк эсхүл ижил түвшний дэд бүтэц, хотын үйлчилгээтэй байршилд байрлаж байх ёстой. Мах, арьс, ширний чиглэлээр хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн хувьд хөтөлбөрийн санхүүжилттэй хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн паркт байрлах бөгөөд мах боловсруулах үйлдвэртэй эсхүл удахгүй ашиглалтад орохоор байх ёстой.</p>
Дамжуулан зээлийн хөрөнгийг зарцуулахад зөвшөөрөгдөх зориулалт	<p>(i) Эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ</p> <p>(ii) Тоног төхөөрөмж худалдан авах</p> <p>(iii) Барилга угсралтын ажил</p> <p>(iv) ТЭЗҮ ба/эсвэл бизнес төлөвлөгөө боловсруулах</p> <p>(v) ТЭЗҮ ба/эсвэл бизнес төлөвлөгөө боловсруулахтай салшгүй холбоотой судалгаа</p>

Монгол Улсын Сэнтийн яам
 ӨМӨЗО-ны Үйлдвэр, Уулза МОН

...-ын үсэг /Signature/ *m*


2022 оны 12 сарын 05 өдөр
 Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
 OFFICIAL TRANSLATION

	(vi) Инженерийн нарийвчилсан зураг төсөл
Урьдчилсан байдлаарх дамжуулан зээлийн хэмжээ	500,000 ам.доллар хүртэл буюу түүнтэй тэнцэх төгрөг
Урьдчилсан байдлаарх дамжуулан зээлийн нөхцөл	Зээлийн хүү: жилийн 7.5%; хугацаа: эргэлтийн хөрөнгийн зээл (2 жил хүртэл), бусад нь: (дээд тал нь 7 жил хүртэл); үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 3 жил хүртэл
Ангилал 3-ын дэд төслүүд	
Шаардлага хангасан дамжуулан зээлдэгч ба дэд төсөл	<p>Энэхүү зээлийн цонхны хүрээнд БНХХААБС нь бэлчээр болон мод бэлтгэлээс ангид, XX бага ялгаруулдаг эдийн засгийн төрөлжилтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэрчилгээжсэн малчдын хоршоо, тэдгээрийн бизнесийн түнш аж ахуйн нэгжийн дэд төслүүдэд оролцогч банкнуудаар дамжуулан нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн зээлийг олгоно. Малчдын амьжиргааны эх үүсвэр, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн төрөлжилтийг дэмжихэд гол хүчин зүйл болох хүнсний ногооны хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой дэд төслүүд нь НБУАТХААБХТ-нд тусгагдаагүй ч гэсэн энэ цонхны хүрээнд санхүүжилт авах боломжтой болно. Үүнд дараах болон бусад төслүүд хамрагдаж болно, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (i) Мал аж ахуйн маркетинг, түүний дотор экспортын зах зээлтэй холбоотой дэд төслүүд; (ii) <i>Аймаг</i>, сум дундын төвүүдийн үйлчилгээний салбаруудтай холбоотой, гэрчилгээжсэн малчин өрхийг орлогын нэмэлт эх үүсвэрээр хангах боломжтой дэд төслүүд; (iii) Хүлэмжийн аж ахуй (тайлбар: энэ төрлийн дэд төслийн байршлыг хязгаарлахгүй); мөн (iv) <i>Аймаг</i>, сум дундын төв дэх хөтөлбөрийн санхүүжилттэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн паркуудад байрлах малын хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах бизнесийн төсөл. <p>Эдгээр хөдөө аж ахуйн бизнес санхүүжилт авахын тулд уг хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зорилтот аймаг, сумын хөдөө аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын оролцоо, хамтын зөвшилцлийн үндсэн дээр боловсруулсан НБУАТХААБХТ-нд тусгагдсан байх ёстой.</p>
Дамжуулан зээлийн хөрөнгийг зарцуулахад зөвшөөрөгдөх зориулалт	<ul style="list-style-type: none"> (i) Эргэлтийн хөрөнгийн шаардлага (ii) Тоног төхөөрөмж худалдан авах (iii) Барилга угсралтын ажил (iv) ТЭЗҮ/бизнес төлөвлөгөө боловсруулах (v) ТЭЗҮ/бизнес төлөвлөгөө боловсруулахтай салшгүй холбоотой судалгаа (vi) Инженерийн нарийвчилсан зураг төсөл
Урьдчилсан байдлаарх дамжуулан зээлийн хэмжээ	Нэг сая ам.доллар хүртэл буюу түүнтэй тэнцэх төгрөг
Урьдчилсан байдлаарх дамжуулан зээлийн нөхцөл	Хүүгийн хэмжээ: жилийн 8.5%; хугацаа: эргэлтийн хөрөнгийн зээл (2 жил хүртэл), бусад: (дээд тал нь 10 жил хүртэл); үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 3 жил хүртэл

БНХХААБС-гийн ногоон зээлийн цонх 2. Энэхүү зээлийн цонхны хүрээнд БНХХААБС нь нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн 500,000-5,000,000 ам.долларын зээлийг нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, борлуулалт, мах, арьс, шир, сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд экспортын бизнес эрхэлдэг дунд, томоохон аж ахуйн нэгжүүдэд бусад банкнууд болон/эсвэл санхүүгийн байгууллагуудтай зэрэгцүүлэн санхүүжүүлэх юм.

Энэхүү цонхны хүрээнд санхүүжилт авахын тулд эдгээр дунд, томоохон аж ахуйн нэгжүүдийн бизнес төлөвлөгөөнд дараах зүйлийг тодорхой зааж өгсөн байх ёстой. Үүнд:



- (i) бэлчээрийн тогтвортой менежмент эрхэлдэг гэрчилгээжсэн малчдын хоршоодтой ажиллаж, ашиг орлогоо хуваалцах;
- (ii) нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хот-хөдөөгийн холболт, хөгжлийг дэмжих, нарны хавтан, нарны дээвэр, эсвэл эрчим хүчний хэмнэлттэй арга хэмжээ гэх мэт эрчим хүчний хэрэглээгээр хүлэмжийн хийн нөлөөллийг бууруулах хөрөнгө оруулалт хамруулах; хог хаягдлыг ашигладаг эсвэл хог хаягдлыг бууруулдаг хөрөнгө оруулалт (нийлүүлэлтийн сүлжээ дэх алдагдал); түүхий эд, бүтээгдэхүүний алслагдмал байдал, тээвэрлэлтийг богиносгох хөрөнгө оруулалт хийж, улмаар тээвэрлэлттэй холбоотой хүлэмжийн хийн хэмжээг бууруулах;
- (iii) НБУАТМААНС-г эрчимжүүлэх явцад нэмэлт ажлын байр, хөдөлмөр эрхлэлт бий болгох,
- (iv) хөтөлбөрийн зорилтот *аймаг, сумдын* орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлж, илүү өрсөлдөх чадвартай болгох тус тус болно.

Эдгээр хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчид зорилтот *аймаг, сумдад* хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулсан нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй нийцэж, тууштай үйл ажиллагаа явуулахаа нотлох шаардлагатай. Шаардлага хангасан дамжуулан зээлийн хөрөнгийг зарцуулахаар зөвшөөрөгдсөн зардалд бүх барилга угсралтын ажил, тоног төхөөрөмж, техник эдийн засгийн үндэслэл, бизнес төлөвлөгөө боловсруулалт, инженерийн нарийвчилсан зураг төсөл зэрэг багтана. Энэ цонхны хүрээнд БНХХААБС-аас авах зээлийн хүү нь одоогоор жилийн 10%-12% хүртэл байхаар тооцож байгаа бөгөөд УАНС-гийн зээлээр олгосон хөнгөлөлтийг хамгийн их хэмжээгээр тусгасан холимог санхүүжилтийн бүтээгдэхүүн байх болно.

БНХХААБС-гийн нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй зээлийн батлан даалтын хөтөлбөр.

Ази, Европ, Африкийн хөдөө аж ахуйн зээлийн баталгааны ижил төстэй хэлбэрүүд/сангуудаас авсан сургамжийг судалсны үндсэн дээр БНХХААБС-ийн зээлийн батлан даалтын хөтөлбөр (ЗБДХ)-ийн загварыг (i) хөдөө аж ахуйн хоршоо, бичил үйлдвэр, ЖДҮ, түүнчлэн томоохон аж ахуйн нэгжүүдэд олгосон БНХХААБС-гийн дамжуулан зээлд төлбөрийн чадамжгүй байдал үүсэх тохиолдолд зээлдэгчийн алдагдлыг бүрэн буюу хэсэгчлэн нөхөх замаар гуравдагч этгээдийн зээлийн эрсдэлийг бууруулах хэрэгслийг зээлдүүлэгчид үзүүлэх; (ii) үл хөдлөх барьцаа хөрөнгө байхгүй хөдөө аж ахуйн хоршоо, ЖДҮ-ээс гол төлөв бүрдэх БНХХААБС-нд хамрагдах боломжгүй зээлдэгчид барьцаа хөрөнгийг орлуулах; (iii) авлагын хөнгөлөлттэй санхүүжилт, факторинг гэх зэрэг хөдөө аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээний шинэлэг санхүүжилтийн схемд барьцаа хөрөнгө орлуулан хүлээн зөвшөөрөх боломжийг хөнгөвчлөх, мөн (iv) дамжуулан зээлийн батлан даагдсан хэсэг зээл олгох санхүүгийн байгууллагуудад бага эрсдэлтэй буюу эрсдэлгүй гэж ангилагдах тул зээлийн хүүг бууруулах байдлаар тус тус боловсруулсан.

ЗБДХ нь дараах үндсэн шинж чанаруудаас бүрдэнэ, үүнд: (i) батлан даалт/даатгалын хураамжийн бүтэц, хамрах хүрээ нь БНХХААБС-гийн дамжуулан зээлийн хэмжээ, зорилго, дамжуулан зээлдэгчдээс хамаарна; (ii) дамжуулан зээл-барьцаа хөрөнгийн үнэлгээний дээд хязгаарыг дамжуулан зээлдэгчдийн эргэн төлөх чадвар, гаргах боломжтой барьцаа хөрөнгө (зээл)-өөс хамаарч тогтооно; (iii) батлан даалтын хамрах хүрээ нь дамжуулан зээлийн зорилго, хэмжээ, хугацаа, дамжуулан зээлдэгчийн төрлөөс хамааран дамжуулан зээлийн үнийн дүнгийн 70%-90% хүртэл хэлбэлзэж болно; (iv) дамжуулан зээлдэгч зээлээ төлөх чадваргүй болсон буюу дутуу төлсөн тохиолдол үүссэн эсэхийг дамжуулан зээлийн шинж чанар, эргэн төлөлтийн схемийг үндэслэн тодорхойлно; (v) данс нээх эсэх нь зээл олгох оролцогч санхүүгийн байгууллагаас өгөх баталгаа, мэдэгдлийн системээр хийж болно; мөн (vi) ХБ-ХУК нь тус хөтөлбөрийн менежерийн хувьд зээл олгох оролцогч санхүүгийн байгууллагын зээлийн баталгааны шугамын хүрээнд олгогдсон дамжуулан зээлийн баримт бичиг, санхүүгийн чадварыг үнэлэх зорилгоор түүвэрлэсэн хяналт шалгалт хийх эрхтэй болно.

Зээлийн батлан даалтад хамруулах. БНХХААБС-гийн эх үүсвэртэй нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй дамжуулан зээл олгох оролцогч санхүүгийн байгууллагууд нь хөтөлбөрийн зээлийн батлан даалтын үйлчилгээг хүргэх эрхтэй. БНХХААБС-гийн ЗБДХ-т хамруулж, эх үүсвэрээс зарцуулалт хийх үйл явц дараах байдалтай явагдана, үүнд: (i) санхүүгийн байгууллагууд (банк, ХЗХ, банк бус санхүүгийн байгууллагууд) БНХХААБС-нд зээлийн батлан даалтын шугамыг ашиглах хүсэлт гаргана; (ii) ХБ-ХУК нь БНХХААБС-гийн зээлийн цонх 1, 2-ын хүрээнд оролцогч санхүүгийн байгууллагуудад тавигдах ЗБДХ-ийн батлагдсан шаардлагын дагуу тухайн хүсэлтийг үнэлнэ; (iii) хүсэлт батлагдах тохиолдолд ХБ-ХУК болон хүсэлт гаргагч санхүүгийн байгууллагын хооронд батлан даалтын гэрээ байгуулна. Гэрээнд батлан даалтын хураамжийн бүтэц, хамрах хүрээ, дамжуулан зээлийн хязгаар, дамжуулан зээл-барьцааны үнэлгээ, зээлдэгчийн өөрийн өмч, зөвшөөрөгдөх барьцаа ба үнэлгээ, шаардлага хангасан дамжуулан зээлийн зориулалт, мөн батлан даасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт үндэслэн тодорхойлсон төлбөрийн

in your /Signature/ *u*
 2022 оны 12 сарын 05 өдөр
 Улаанбаатар хот
 Ministry of Finance of Mongolia
 OFFICIAL TRANSLATION

чадваргүй байдал үүссэн гэж үзэх тохиолдол зэргийг агуулсан заалтуудыг тусгасан байна; мөн (iv) батлагдсан батлан даалтын шугамтай бөгөөд ХБ-ХУК-тай байгуулсан батлан даалтын гэрээтэй санхүүгийн байгууллагууд нь БНХХААБС-гийн зээлийн цонх 1, 2-ын шаардлага хангасан дамжуулан зээлийг өөрийн батлан даалтын шугамын эрхийн хүрээнд шаардагдах баталгаа, мэдэгдэл хүргэх замаар батлан даалтад албан ёсоор хамруулна. Уг баталгаа, мэдэгдэлд дараах зүйлсийг тусгасан байна, үүнд: (а) дамжуулан зээлийг, түүний эргэн төлөлтийг баталгаажуулсан барьцаа хөрөнгөтэй холбоотой нотолгоо баримт бичгийг бүрэн бүтэн үйлдсэн бөгөөд дамжуулан зээлдэгчид хүчин төгөлдөр үйлчилж, түүгээр заавал дагаж мөрдүүлэх боломжтой; мөн (б) холбогдох зээлийн бодлого, удирдамжийн дагуу тухайн зээлтэй холбоотой зээлдэгчийн зээлжих чадварыг баталгаажуулах зорилгоор зээлийн дансанд зохих ёсоор үнэлгээ, шалгалт хийхдээ батлан даалтын гэрээний заалтыг дагаж мөрдсөн болох тус тус болно.

Батлан даалтын эх үүсвэрээс зарцуулалт хийх. Батлан гэрээнд заасны дагуу эргэн төлөх чадваргүй болсон (дефолт үүссэн) тохиолдолд санхүүгийн байгууллага нь дефолт үүссэн дансны батлан даалтад хамрагдсан хэмжээнд нэхэмжлэл гаргаж, батлан даалтын эх үүсвэрээс зарцуулалт хийх хүсэлтээ үнэлүүлэхээр холбогдох баримт бичгийг ХБ-ХУК-инд хүргүүлж, холбогдох шаардлагыг хангана. Батлан даалтад хамрагдсан зээлийн данстай холбогдуулан гаргасан хүчин төгөлдөр нэхэмжлэл гаргаснаар даатгуулсан зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл дүнд төлбөрийг барагдуулах үйл явцыг эхлүүлнэ. Гэсэн хэдий ч санхүүгийн зуучлагч нь ЗБДХ-өөс нөхөн төлсөн дамжуулан зээлийн төлбөрийг зээлдэгчээс буцаан олохын тулд дефолт хийсэн дансыг заавал үргэлжлүүлэн удирдаж, зохис журмын дагуу арга хэмжээ авсан хэвээр байна.

БНХХААБС-гийн нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй инновацын тэтгэлгийн хөтөлбөр. Монгол Улсын ДНБ-ний 11%-ийг эзэлдэг хөдөө аж ахуйн салбар нь тус улсын хоёрдогч том эдийн засгийн салбар бөгөөд улсын хэмжээнд нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын бараг 35%-ийг ажлын байраар хангадгийн хувьд ажлын байрны хамгийн том эх үүсвэр болсон салбар юм. Хөдөө аж ахуйн салбар дотроо мал аж ахуйн салбар нь ДНБ-нд хамгийн том хувь нэмэр оруулж, тус салбарын бараг 85%-ийг эзэлдэг. Монголын мал аж ахуйн салбарын харьцангуй давуу талтай, дотоодын болон олон улсын зах зээлийн асар их боломжууд байгаа хэдий ч зах зээл дээр амжилттай яваа мал аж ахуйн бизнес эрхлэгчид цөөхөн хэвээр байна. Эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвартай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нийгмийн хүртээмжтэй үйлдвэрлэлийг цогцлоосон дунд, том аж ахуйн нэгж болон хөгжиж чадахгүй байгаа бичил, жижиг бизнес эрхлэгч олон аж ахуйн нэгжүүд Монголын аймаг, сумдад олноороо байна. Зах зээл, маркетингийн мэдлэг дутмаг, зохисгүй технологи хэрэглэдэг, нийлүүлэлтийн сүлжээ бага хөгжсөн, санхүүжилт авах боломжгүй, хангалттай хэмжээнд инновац байхгүй зэргээр эрс өөрчлөлт хийхэд олон саад бэрхшээл тулгардаг. Үүний үр дүнд мал аж ахуйн салбарт нэмүү өртөг шингээлт бага байснаас орлого бага, улмаар амьдралын чанар муу гэх сөр мөчлөг үүсэж, улмаар малын тоо толгойг нэмэгдүүлэх хэрэгцээг дэвэргэж, цаашлаад бэлчээрийг улам дордуулах нөхцөл үүсгэж байна. БНХХААБС-гийн нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй инновацын тэтгэлгийн хөтөлбөр (НБУТИТХ)-ийн үндсэн зорилго нь аймаг, сумдын түвшинд бага нүүрстөрөгчтэй, уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийн бүтээгдэхүүн, процесс, бизнесийн загварын инновацыг хөгжүүлэх замаар хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуйн шинэлэг бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар, өсөлтийг нэмэгдүүлж, улмаар бичил, жижиг хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг, Монгол мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээг эрчимжүүлэх, төрөлжүүлэх хүчин чадалтай, өрсөлдөх чадвар бүхий дунд болоод томоохон аж ахуйн нэгж болгон хувиргах үйл явцыг түргэсгэх замаар нүүрстөрөгч багатай ногоон, хүртээмжтэй бүс нутгийн хөдөө аж ахуйн бизнесийн өсөлтийг хурдасгахын зэрэгцээ бэлчээрийн доройтлыг бууруулж, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, илүү үр ашигтай зах зээл, хот-хөдөөг хөгжүүлэхэд дэмжлэг болох болно.

Хөтөлбөрийн шаардлага хангасан санхүүжилт, бүтэц ба менежмент. Уг хөтөлбөрт зориулан УАНС-гаас нийт 45 сая ам.долларын буцалтгүй тусламж хүссэнээс 5 сая ам.долларыг БНХХААБС-гийн НБУТИТХ-т зориулахаар хуваарилсан. УАНС-гийн эх үүсвэртэй нийт буцалтгүй тусламжийн 25 сая ам.долларыг үе шат 1-д хуваарилсан. Энэхүү үе шат 1-д хуваарилсан УАНС-ийн буцалтгүй тусламжийн 3 сая ам.долларыг Монгол Улсын Засгийн газраас БНХХААБС-гаар дамжуулж НБУТИТХ-ийн инновацын тэтгэлэг хэлбэрээр олгохоор болсон.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу БНХХААБС-ыг үүсгэн байгуулж, удирдлагаар хангах үүрэг бүхий ХБ-ХУК нь НБУТИТХ-ийг БНХХААБС-ийн доорх эргэлтийн сан байдлаар үүсгэн байгуулах болно. Тиймээс, уг хөтөлбөрийг хөтөлбөрийн төслийн удирдах хороо (ТУХ) болон Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос баталсан тэтгэлгийн бодлого, механизмын дагуу ХБ-ХУК удирдана.⁹ НБУТИТХ-ийн санхүүгийн удирдлагын систем нь тэтгэлэгт зориулсан тусдаа данс бүртгэл, тайлан, аудит, хяналт-шинжилгээний систем зэрэг АХБ-ны шаардлагад нийцсэн холбогдох стандарт, журамтай нийцсэн байна. ХБ-ХУК нь НБУТИТХ-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тэтгэлгийн администратор томилно. Тэрээр БНХХААБС-гийн сангийн менежерт шууд тайлагнах бөгөөд дараах үндсэн үүрэг хариуцлагыг хүлээнэ, үүнд: (i) тэтгэлгийн

Хүний үсэг /Signature/ М

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

өргөдлийг НБУТИТХ-ийн шалгуурын дагуу үнэлэх, (ii) НБУТИТХ-ийн тэтгэлэг олгох талаар зөвлөмж гаргах, мөн (iii) тэтгэлгийн захиран зарцуулалт, үүнд зарцуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ зэргийг хариуцан ажиллах тус тус болно. Эдгээр чиг үүргийн биелүүлэхдээ СЗХ болон хөтөлбөрийн ТУХ-ны баталсан тэтгэлгийн бодлого, механизмыг НБУТИТХ-т чанд мөрдүүлэн ажиллахыг баталгаажуулна.

Тэтгэлэгт баримтлах механизм, үйл ажиллагаа болон шаардлага хангасан хүлээн авагч. Шаардлага хангасан тэтгэлэг хүлээн авагч нь өөрийн бодлого, хэрэгжүүлж буй болон санал болгож буй хөтөлбөрүүдээрээ хөдөө аж ахуйн бизнесийн инновац, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд тууштай ханддаг болохоо харуулж чадах шинэлэг, ЖДҮ эрхлэгчид байна. Тэд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй бэлчээрийн менежментийг тогтвортой эрхэлдэг малчидтай түншилж эсвэл хамтарч ажилладаг байх бөгөөд компанийн үнэт зүйлс, стратеги, тэргүүлэх чиглэл болон хамтран ажилладаг хүрээлэл, сүлжээнээс харахад нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний манлайлагч болох боломжтой нь илт байх юм. Тэд Монгол Улсын холбогдох бүх хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад бүртгэлтэй ЖДҮ эрхлэгчид байх бөгөөд тэтгэлэгт хамрагдах авах өргөдөл гаргахдаа аудитын сөрөг дүгнэлтгүй, дор хаяж 2 жилийн турш ашигтай ажилласан байх ёстой. БНХХААБС-гийн зээлийн аль нэг цонхноос зээл авах шаардлага хангасан ЖДҮ эрхлэгчид НБУТИТХ-ийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт гаргах эрхтэй. БНХХААБС-гаас зээлд хамрагдаж, дамжуулан зээлдэгч болчихсон ЖДҮ эрхлэгчийн хувьд тэдний санхүүгийн байдал сайн, дефолт хийгээгүй бөгөөд аудитын сөрөг үр дүгнэлт аваагүй байх ёстой. Түүнчлэн, НБУТИТХ-ийн заасан дэд төслийн шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой.

Шаардлага хангасан дэд төсөл болон дэд төсөлд тавих үндсэн шаардлага. Шаардлага хангасан дэд төслийн санал гэж тооцогдохын тулд дор дурдсан зургаан шаардлагыг бүрэн хангаж байгаагаа харуулах шаардлагатай. Үүнд:

- (i) Санал болгож буй дэд төсөл нь эх загвар байна.^h Тухайн дэд төсөл нь зорилтот *аймагт* хамгийн анхдагч буюу бараг анхдагч төсөл байна (тухайн *аймагт* сүүлийн 5 жилийн хугацаанд ижил төрлийн төсөл ихдээ нэг хэрэгжсэн байна).
- (ii) Хангалттай ногоон байна. Тухайн дэд төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицоход хангалттай үр ашигтай байх ба уур амьсгалын өөрчлөлтⁱ - хөрөнгө оруулалтын харьцаа хамгийн багадаа 10% байхаар үнэлэгдсэн байна.
- (iii) Нэмэлт өгөөжийг харуулсан байх. Гагцхүү НБУТИТХ-ийн дэмжлэгээр мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ дэх хүлэмжийн хийн ялгаралтыг дэд төслийн хүрээнд хэрхэн бууруулж буйг суурь үзүүлэлтээс дээшлэх бодит нөлөөгөөр харуулна.^j
- (iv) Түгээн дэлгэрүүлэх боломжтой байх. Энэхүү хөтөлбөрөөс олж авсан туршлага, сургамжаа ойрын ирээдүйд бусад *аймагт* хэрхэн түгээн дэлгэрүүлж эсвэл өргөжүүлж болохыг тодорхой харуулсан аргачлалтай байх ёстой.^k
- (v) Ногоон, нийгмийн хүртээмжтэй байх. Өсөлт, өрсөлдөх чадвар, бэлчээрийн тогтвортой менежментийг, тур дундаа тур малчдын хоршоо, нийгмийн эмзэг хэсэгтэй уялдаа холбоог нэмэгдүүлэх институцийн болон дизайны онцлог шинж чанартай байна.^l
- (vi) ЖДҮ-ийг илүү том, өрсөлдөх чадвартай аж ахуйн нэгж болгон өөрчлөх чадвартай байх. Нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэрлэх чадвартай хөдөө аж ахуйн бизнесийн инноваци нь эдийн засгийн хувьд жилд дор хаяж 10%, ногоон нэмэлт ажлын байрны хувьд дор хаяж 30%-иас доошгүй өсөлт үзүүлэх томоохон аж ахуйн нэгж болж хөгжиж боломжтойгоо харуулна.

Шаардлага хангасан дэд төслийн жишээ. Дэд төслүүд нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, бүтээмж, хөдөө аж ахуйн боловсруулалт, хөдөө аж ахуйн маркетинг зэрэгт шинэлэг мэдлэг, бүтээгдэхүүн, технологийг ашиглан *аймаг, сумын* түвшинд нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй, хүртээмжтэй мал аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. Дараах болон бусад төслүүд байж болно, үүнд: (i) ус хадгалах зорилгоор газарт гель ашиглах; (ii) сайжруулсан үүлдэр; (iii) зохиомол хээлтүүлэг, мал үржил; (iv) метаны ялгаралтыг бууруулах тэжээлийн нэмэлтүүд (v) малын маркетинг ба түгээлтийн дижитал систем (бүтээгдэхүүний гэрчилгээжүүлэлттэй холбоотой), мөн (vi) үйлдвэрлэл болон боловсруулалтад сэргээгдэх эрчим хүч, эсхүл эрчим хүчний хэмнэлтийн шийдлүүдийг ашиглах зэрэг болно.

Шаардлага хангахгүй дэд төсөл, үйл ажиллагаа. Зарим дэд төсөл ба/эсвэл үйл ажиллагааг НБУТИТХ-өөс санхүүжүүлэхгүй. Дараах жагсаалт нь НБУТИТХ-ийн шаардлага хангахгүйд хүргэх дэд төсөлтэй холбоотой үйл ажиллагааны төрлүүд эсвэл зардал болно. НБУТИТХ-өөс дараахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхгүй.

- (i) “ердийн бизнес” зардлууд, үүнд:

Энгийн үйлдвэрлэл / Signatures /
2022 оны 12 сарын 05 өдөр
Урьдчилсан хот
МОНГОЛ
Улаанбаатар

- (a) хэвийн бизнес ба/эсвэл салбарт гардаг урсгал зардал;
 - (b) тухайн бизнес болон/эсвэл салбарт аль хэдийн явагдаж буй үйл ажиллагаа; мөн
 - (c) бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад төлөвлөсөн хөрөнгө оруулалтын зардал, үүнд машин механизм, тоног төхөөрөмж, хувьцаа, программ хангамж болон бусад ижил төстэй зардлууд хамаарна.
- (ii) НБУТИТХ-өөс санхүүжилт аваагүй тохиолдолд ч бизнес/салбартаа зайлшгүй гаргах байсан зардал;
 - (iii) мөнгөн хөрөнгөн бус зардлууд;
 - (iv) хүлэмжийн хийн ялгаралтыг нэмэгдүүлэх эсвэл уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах үйл ажиллагаа;
 - (v) хөтөлбөрийн байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагыг хангаагүй үйл ажиллагаа; мөн
 - (vi) хөтөлбөрийн зорилтыг хангахад хувь нэмэр оруулахааргүй үйл ажиллагаа тус тус болно.

Тэтгэлийн өргөдөл, тэтгэлэг олголт, зарцуулалт ба хяналт-шинжилгээ. БНХХААБС-ийн тэтгэлгийг олгоходоо ХБ-ХУК-иас баталсан өргөдлийн загвар маягыг ашиглах. Энэхүү загвар маягтад тухайн өргөдөл гаргагчдын хүсэлт гаргах болсон үндэслэл, санал болгож буй инновацын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, мал аж ахуйн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээнд үзүүлэх нөлөө, хүлээгдэж буй үр дүн (үр дүн ба бүтээгдэхүүн), холбогдох төсөв, хэрэгжилтийн төлөвлөгөө, явцын гол үр дүн зэргийг тусгана. Тэтгэлгийн өргөдлийг дараах сонгон шалгаруулалтын үзүүлэлтээр үнэлнэ, үүнд: (i) эх загварын түвшинд байгаа бөгөөд зорилтот аймагт хамгийн анхдагч буюу бараг анхдагч төсөл байна; (ii) уур амьсгалын өөрчлөлтийн үр ашиг-хөрөнгө оруулалтын үзүүлэлт дор хаяж 10%, (iii) мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээнд хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах чадвар; (iv) бусад *аймагт* түгээн дэлгэрүүлэх боломж; (v) үр ашгийг илүү тэгш хуваарилах нөхцөлийг бүрдүүлсэн түншлэлийн гэрээг дэмжих ногоон, нийгмийн хүртээмжтэй байдал; (vi) нэмэлт орлого, ногоон ажлын байр бий болгох чадвартай, илүү өрсөлдөх чадвартай, томоохон аж ахуйн нэгж болон өөрчлөгдөх боломж тус тус болно. Батлагдсаны дараа ХБ-ХУК тэтгэлгийн хөрөнгийг хэрэгжилтийн хуваарь, явцын гол зорилт хангагдсан эсэхэд үндэслэн хувь тэнцүүлэн шат дараатай олгож, хяналт тавьж ажиллана. Ингэснээр тэтгэлгийн хөрөнгийг зээлээ эргэн төлөхөд ашиглах эрсдэлийг бууруулах болно.

Бүртгэлийн хэсэг 3 ба БНХХААБС-гийн талаарх илүү нарийвчилсан мэдээллийг хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлагын Хавсралт 3-т тусгасан болно.^m

ы

^a Марк Питер Садлер. 2016 он. *Уур амьсгалын санхүүжилтийг хөдөө аж ахуйд ашиглах нь*. Дэлхийн Банк: Вашингтон, ДС хот.

^b АХБ нь заавал тус банкны шууд хяналт шаардахгүй санхүүжилтийн шаардлагатай тодорхой хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор санхүүгийн зуучлалын зээлийг дангаар нь, эсвэл салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг, эсвэл салбарын эсвэл төслийн зээлийн хүрээнд олгодог. АХБ-ны хөрөнгийг менежмент, захиргааны чадвараас нь хамааран нэг буюу хэд хэдэн санхүүгийн зуучлагчдад шууд өгөх эсвэл засгийн газар болон/эсвэл толгой санхүүгийн байгууллагаар дамжуулан санхүүгийн зуучлагчдад дамжуулж, тогтвортой үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай нөхцөл тавьдаг. Толгой байгууллагууд нь ихэвчлэн санхүүгийн байгууллагууд байх бөгөөд үүгээр дамжуулан хандивлагчдын санхүүжүүлсэн санхүүгийн зуучлалын зээлийг санхүүгийн зуучлалын хоёр дахь давхаргад дамжуулж, улмаар зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдэгчдэд олгодог. Толгой байгууллагууд нь хоёрдогч түвшний зуучлагчдын зээлийн эрсдэлийг хариуцдаг.

^c Засгийн газрын 2017 оны 135 дугаар тогтоол, Хөгжлийн Банкны Захирлуудын зөвлөлийн 2017 оны 8-р сарын 23-ны өдрийн 66 дугаар тогтоолыг үндэслэн Хөгжлийн Банк ХБ-ХУК-ийг байгуулж, хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 12-р сарын 15-ны өдрийн 241-р тогтоолын дагуу ХБ-ХУК нь хөрөнгө оруулалтын сан байгуулах, удирдах эрхийг авсан.

^d Хувийн хөрөнгө оруулалтын сан бол Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хоёр төрлийн сангийн нэг юм. Нөгөө хэлбэр нь хамтын хөрөнгө оруулалтын сан болох төрийн хөрөнгө оруулалтын сан юм.

^e Цонх бүрд заасан нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй зээлийн санхүүжилтийн нөхцөлийг Засгийн газар болон/эсвэл олон улсын хандивлагч байгууллагуудын эх үүсвэрээр Монгол улсад хэрэгжиж буй хөдөө аж ахуйн санхүүжилтийн хөтөлбөрүүдийн судалгаанд үндэслэн боловсруулсан болно. Хэлцлийн техникийн туслалцааны хүрээнд 2018 оны 6-р сараас 9-р саруудад зорилтот *аймаг, сумдад* банк, хувийн хэвшилтэй хийсэн зөвлөлдөх уулзалтын үндсэн дээр хийсэн дүн шинжилгээгээр малчид, малчдын хоршоо, хөдөө аж

арын үсэг /Signature/

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ахуй./эсвэл агро-бизнес эрхэлдэг ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтэд хамрагдах боломж эрс хязгаарлагдмал болох нь баталгаажиж, Монгол Улсын *аймаг, сумын түвшинд*, ялангуяа мал аж ахуй, тариалалтын салбарын хувьд санхүүжилтийн энэ дутагдлыг арилгах шаардлагатай харуулсан.

- ^f Арьс ширний үйлдвэр эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байгаль орчинд үзүүлэх нөлөө өндөр тул хамрагдах боломжгүй юм.
- ^g Тэтгэлгийн нарийвчилсан бодлого, механизмыг агуулсан гарын авлагын төслийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөрийн О4А3 зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр ХБ-ХУК боловсруулна. Энэхүү гарын авлагыг төслийн удирдах хороо (ТУХ)-нд хүргүүлж батлуулах болно. Санхүүгийн Зохицуулах Хороо нь ТУХ-г батлахаас өмнө гарын авлагыг хянаж батална.
- ^h Тухайн интервенц ба/эсвэл дэд төсөл нь зорилтот *аймаг, сумдад* мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаанд ирээдүйд ашиглагдах шинэлэг мэдлэг, технологийн үндэс суурь болох эх загвар (прототип) байх ёстой. Эдгээр үйл ажиллагаанд (i) хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, (ii) хөдөө аж ахуйн боловсруулалт, (iii) сав баглаа боодол, (iv) түгээлт, (v) брэнд болон бусад экспортын зах зээлтэй холбоотой маркетингийн асуудлууд орно.
- ⁱ Уур амьсгалын өөрчлөлтийн үр ашгийн үзүүлэлт нь уур амьсгалын өөрчлөлтийн мөнгөний үнэ цэнийн хэмжүүр юм. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн жилийн үр ашгийг хөрөнгө оруулалтын хэмжээтэй уялдуулж, хөтөлбөр эсвэл интервенцээс үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтийн жилийн үндсэн үр ашгийн мөнгөн хэлбэрт хувиргасан тооцоо юм (ХХГА-ийн Хавсралт 4).
- ^j Нэмэлт өгөөж нь санал болгож буй үйл ажиллагаа нь суурь үзүүлэлт буюу жиших хувилбартай харьцуулахад ирээдүйд "илүү сайн өгөөж" бий болох эсэхийг тодорхойлох явдал юм. Санал болгож буй дэд төсөл нь мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээ дэх хүлэмжийн хийн ялгарлын хэрхэн бууруулахаа харуулах бөгөөд ингэхдээ дэд төсөлтэй, дэд төсөлгүй гэх хоёр хувилбарыг харьцуулах ба үүнд төсөлгүй гэх хувилбар нь суурь үзүүлэлтийн үүрэг гүйцэтгэнэ.
- ^k Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх холбогдох судалгааны материалд ашигласан нэр томъёоны тайлбарын дагуу түгээн дэлгэрүүлэх гэдэг нь тодорхой интервенцийг өөр нэг тодорхой байршлуудад хуулбарлах шууд оролдлого бүхий үйл ажиллагааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, дэд төслийн саналд НБУТИТХ-ийн дэмжлэгтэйгээр бусадтай ижил төстэй төслүүдийг ирээдүйд өөр *аймагт* хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг даван туулах боломжтой болохоо тусгасан байна.
- ^l Дэд төсөл нь зэрэгцээ дэд төсөл өсөлт, өрсөлдөх чадварыг бий болгож, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахын зэрэгцээ үр өгөөжийг талуудад хэрхэн илүү тэгш хуваарилах арга замаа тодорхойлсон байна. Үүний нэг хэлбэр нь ЖДҮ ба малчдын хоршоод, зорилтот *аймаг, сумдын* эмзэг бүлгийн өрхүүдийн хооронд хууль ёсны түншлэлийн гэрээ байгуулж, малчдын хоршоод, эмзэг бүлгийн өрхүүдэд төслөөс гарах үр өгөөжийг хуваалцах боломжийг олгох байж болох юм.
- ^m ХХГА (ЕТЗ-ийн Хавсралт 2-т холбогдох баримт бичгийн жагсаалтаас үзэх боломжтой).

Эх сурвалж: АХБ.

Монгол Улсын Сангийн яам
АНХААРИХНЫ ОРЧУУЛГА МЭН

Гарын үсэг /Signature/ *М*

2022 оны 12 сарын 05 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION